

Олон нийтэд зориулав.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2018 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

/2018.04.05-2018.06.29/

УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

АГУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганыг нээж УИХ-ын дарга М.Энхболдын хэлсэн үг	7
НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	
1.1 Улсын Их Хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны нэгдсэн тойм.....	22
ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН ДЭД ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
2.1. Улсын Их Хурлын Байнгын болон Дэд хороодын бүрэлдэхүүн	26
2.2. Байнгын хороодын үйл ажиллагааны талаарх мэдээлэл	29
ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	
3.1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах ажлын талаар	62
3.2. Улсын Их Хурлын гишүүдийн тавьсан асуулга, асуулт	64
3.3. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл	65
ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
4.1. Мэдээлэл, сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаа	78
4.2. Улсын Их Хуралд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	80
4.3. Мэдээллийн технологи, техник ашиглалтын мэдээ	81
4.4. Судалгаа шинжилгээ, мэдээлэл, лавлагаа	83
4.5. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа	84
ТАВ. ХАВСРАЛТУУД	
Хавсралт 1. Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганаар баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын жагсаалт	94
Хавсралт 2. Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганаар баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга	100

А) Төрийн байгуулалтын болон хууль зүйн чиглэлээр

1. Улсын бүртгэлийн ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга.....	100
2. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга.....	102
3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын танилцуулга.....	103
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга.....	105
5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	106
6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	107
7. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	109
8. Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	110
9. Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	110
10. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	111
11. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	112
12. “Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	113
13. “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	113
14. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга (Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газар).....	114
15. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга (Мал эмнэлгийн ерөнхий газар).....	114
16. “Д.Муратын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	115
17. “Д.Гантулгын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	116

18. “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	116
19. “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга (Бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай).....	117
20. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	117
21. “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай”, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай”, “Нөхөн болон дахин сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолуудын танилцуулга.....	117
22. “Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	118

Б) Төсөв, санхүүгийн чиглэлээр

1. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн танилцуулга.....	120
2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль болон Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн танилцуулга.....	121
3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн танилцуулга.....	122
4. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	123
5. “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	124
6. “Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	125

В) Эдийн засгийн чиглэлээр

1. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн танилцуулга.....	127
2. “Монголбанкны мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүдийг томилж тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	128

3. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	129
4. “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	130
5. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	131
6. “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	133
7. “Тавантолгойн нүүрсний орддын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	134

Г) Нийгэм, боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр

1. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн танилцуулга	135
2. Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	136
3. Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	136
4. Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	137
5. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	137
6. Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	138
7. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга (Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлах тухай).....	139
8. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга (Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай).....	139

Д) Байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр

1. Баяжуулсан хүнсний тухай хуулийн танилцуулга.....	140
2. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	142
3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	143

Е) Аюулгүй байдал, олон улсын гэрээ, конвенцийн чиглэлээр

1. Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн Газар, Оросын Холбооны Улсын Засгийн Газар хооронд байгуулсан Азийн авто замын сүлжсээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга.....	144
2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга.....	145
3. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн танилцуулга.....	146
4. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	147
5. Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	148
6. Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	149
7. “Бүгд Найрамдах Киргиз Улсад Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	151
8. “Цахим бодлогын түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	152
Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганыг хааж УИХ-ын дарга М.Энхболдын хэлсэн үг	153
Товчилсон үгийн жагсаалт	161

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫГ НЭЭЖ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛДЫН ХЭЛСЭН ҮГ



*Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч өө,
Эрхэм хүндэт Ерөнхий сайд аа,
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,*

Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу хаврын чуулганаа эхлүүлэхээр та бид хуран цуглаад байна. Намрын чуулган өндөрлөснөөс хойш Улсын Их Хурлын гишүүд 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, 300 шахам суманд очиж, 178.0 мянга гаруй иргэд, сонгогчтой уулзаж, Улсын Их Хурлаас баталсан хууль, төрийн бодлогыг таниулж, хэрэгжилттэй нь танилцлаа. Уулзалтуудаас ард олны аж амьдралын өнгө төрх, сэтгэлийг нь зовоосон асуудлууд, төр засгийн үйл ажиллагаанд өгч буй үнэлгээ тодорхой харагдсан нь дамжиггүй. Болж бүтэж, ахиц дэвшилд хүрч байгаа, гэрэл гэгээтэй зүйл цөөнгүй ч бүхэлдээ ард түмний аж амьдрал сайнгүй байна. Аймаг, сумдын төвийн айлуудын дийлэнх нь төвлөрсөн эрчим хүчинд, таваас бусад аймгийн төв нийслэлтэй хатуу хучилттай замаар холбогдсон. Нар, салхины эрчим хүч малчдын ердийн хэрэглээ болсон. Бүх сум, сууринд үүрэн холбооны сүлжээ хүрч, интернэт, ухаалаг гар утсаар гэрээсээ, малчны хотноос дэлхийтэй холбогдож байна. Телевизийн бүх сувгийг үзэж, мэдээлэл авч байна.

Гэвч мал аж ахуй, газар тариалан эрхэлж буй иргэд хөдөлмөрийнхөө үр шимийг бүрэн хүртэж чадахгүй байна. Өсгөсөн мал нь, хураасан ургац нь орлогын тогтвортой үүсвэр болохгүй байна.

Ноос, арьс шир тушаасны урамшуулал малчин өрх бүрт хүртээмжтэй хүрэхгүй байна. 2017 онд 302.5 мянган малчны 86.9 мянга нь ноосны урамшуулал авсан бол арьс, ширний урамшуулалд 2016 онд 64.2 мянган малчин хамрагджээ. 2016 онд хонины ноосныхоо 25.5 хувийг, ноолуурынхаа 8.3 хувийг, арьс ширнийхээ дөнгөж 10.0 хувийг л бүтээгдэхүүн болгож боловсруулсан байна. 400.0 мян.тн мах, 874.4 мян.тн сүү үйлдвэрлэсэн хэрнээ махны 2.5, сүүний 8.0 орчим хувийг үйлдвэрийн аргаар боловсруулжээ.

Хөдөөд боловсруулах үйлдвэрлэл хөгжихгүй байгаа нь энэ арчаагүй гэмээр байдалд хүргэсэн. Тиймээс Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн удирдлагууд аймаг, сумдад боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг тэргүүн ээлжинд дэмжиж, төсөв, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, цаашид зах зээл, хүн ам, дэд бүтцийн хөгжилтэй уялдуулан бүсчилсэн хэлбэрээр хөгжүүлэх чиглэл баримталж ажиллах нь зүйтэй юм.

Газар тариалан эрхлэгчид ургуулсан төмс, хүнсний ногоогоо дараагийн ургац хүртэл хадгалж, борлуулж, орлогын тогтвортой эх үүсвэртэй байх хүсэлтэй байдаг. Гэтэл агуулах, зоорьгүйгээс болоод үнэ ханш хамгийн бага үед буюу намар бөөнд нь, хямд зарахаас өөр сонголтгүй болдог.

Салбарын яам хүнсний ногоо хадгалах хүчин чадлын хангамж 2016 оны байдлаар 80 хувьд хүрсэн гэж ярьдаг ч үр өгөөж мэдрэгдэхгүй байна. 2013-2015 онд Засгийн газар “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” хэрэгжүүлэхдээ зоорь, агуулах, худалдааны төвийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 32 аж ахуйн нэгжид 94.6 тэрбум төгрөгийн зээл олгосон. Гэтэл зээлээр байгуулсан 24 агуулах, зоорь нь бүгд Улаанбаатарт байх юм. Энэ бол авсан арга хэмжээ иргэндээ, айл өрхдөө хүрэхгүй, хөдөөг хөгжүүлэх бодлоготой уялдахгүй байгаагийн нэг жишээ юм.

Ирэх жилүүдэд Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сангаас нүхэн болон энгийн зоорь барих зориулалтаар зээл олгох, хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийн нэр төрөлд төмс, хүнсний ногоог нэмж оруулах замаар газар тариалан эрхлэгчдэд тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхийг Засгийн газарт даалгая.

Хөдөөд амьдрах таатай орчин бүрдүүлэх замаар төвлөрлийг сааруулах, хөдөөгийн хөгжлийг хангах чиглэлд дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байгааг иргэд анхааруулж байна. Аймаг, сумын төв, суурин газруудад ажилгүйдэл их хэвээр байна. Ажлын байргүй, амьдрах аятай орчин бүрдэхгүй байгаа нь сум эзгүйрч, залуус нутагтаа тогтохгүй байх гол шалтгаан юм.

Аймгийн төвийг оролцуулаад аймаг, сумдын нийт өрхийн 15 орчим хувь нь төвлөрсөн дулааны хангамжид, 16 орчим хувь нь төвлөрсөн цэвэр, бохир усны сүлжээнд холбогдсон байна. Хөдөөд ус, дулааны асуудал орхигджээ. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд төвлөрсөн ус, дулааны хангамж чухал гэдгийг бид мартжээ.

Тиймээс сумдад байгальд ээлтэй, дэвшилт технологитой ус хангамж, ариутгах татуургын, дулааны нэгдсэн болон хэсэгчилсэн систем шинээр байгуулах, байгааг нь өргөтгөх, түүнд сумдын айл өрхийн 50 хүртэл хувийг холбох ажлыг тодорхой төлөвлөгөө, тооцоо судалгаатай хэрэгжүүлж эхэлье.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал нийслэлийн утаа, орчны бохирдлыг бууруулах, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, төсөв, хөрөнгө оруулалтыг өнөөгийн нөхцөлд хангалттай гэж хэлж болохуйц түвшинд шийдвэрлэсэн. Тодорхой үүрэг, чиглэл Засгийн газарт өгсөн. Одоо хийх ёстой ажлаа хойш тавилгүй эхэлмээр, явц үр дүнг тухай бүр тооцож, дүгнэж баймаар байна.

Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлт, Улсын Их Хурлын шийдвэрүүд, баталж өгсөн төсөв, хөрөнгийн зарцуулалтад Улсын Их Хурал хяналт тавих ёстой.

Хотын иргэдийг бухимдуулж, цаг, мөнгийг үрж байгаа нэг асуудал бол авто замын түгжрэл. Нийслэлийн авто замын урт 858 км, тээврийн хэрэгслийн тоо 586.8 мянга, авто замын ачаалал гурав дахин хэтэрсэн гэсэн мэдээ байна. Түгжрэлийг уулзвар өргөтгөөд шийдвэрлэж чадахгүй гэдэг нь ойлгогдлоо. Харин нүхэн гарц, давхар зам барих, замын урсгалыг зөв зохион байгуулах, нийтийн тээврийн маршрутыг оновчтой болгох байдлаар шийдвэрлэж байгаа дэлхий нийтийн жишгийг анхаарч үзье.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт, бусад эх үүсвэрээр хийгдэх бүтээн байгуулалтын ажил эхний улирал дуусчихаад байхад тендерээ зарлаагүй, орон нутагт эрх шилжүүлэх ажил удаашралтай, тодорхойгүй байгааг анхаарч, ажлаа шуурхайлах хэрэгтэй.

Бүтээн байгуулалтыг иргэдээ ажилтай болгох нэг хөшүүрэг болгож ашигламаар байна. Зам гүүр, барилга угсралтын зэрэг ажилд туслан гүйцэтгэгчдийг гаднаас залж биш, дотроосоо урьж хийлгэдэг байх нь зүйд нийцнэ.

Эрхэм гишүүд ээ,

Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, архидан согтууралт, түүнээс үүдэлтэй гэмт хэргийн гаралт сэтгэл түгшээх хэмжээнд хүрчээ.

2017 онд шүүхээс ял шийтгүүлсэн хүмүүсийн 4.7 хувь нь 14-17 настай, 42.7 хувь нь 18-29 насныхан байна. Ял шийтгүүлэгчдийн 25.0 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Өмнөх онтой харьцуулахад ял шийтгүүлсэн 14-15 насныхны тоо 3.5, 16-17 настай хүүхдийн тоо 23.5, 18-29 насны залуусын тоо 26.8 хувиар, согтуугаар гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүний тоо 30.4 хувь өсчээ.

Улсын хэмжээнд анхан шатны шүүх 8839 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 53.4 хувиар өсөж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 4.9 хувь нэмэгдсэн байна. Хэдийгээр анхан шатны шүүхийн шийдвэр хянагдаж, өөрчлөгдөх нь байдаг ч ял шийтгүүлэгчдийн 48 орчим хувийг өсвөр үеийнхэн, залуучууд эзэлж байгаа нь санаа зовоосон асуудал мөн.

Үүний шалтгаан нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Мөн хүүхэд залуучуудын хүмүүжил, боловсрол, ёс суртахууны асуудалд онцгой анхаарал тавих цаг болжээ. Энэ зорилгоор Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхийг Засгийн газарт чиглэл болгоё.

Түүнчлэн өнгөрсөн оноос хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулиар хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчил, түүнд ногдуулах ял, шийтгэлийн бодлогыг оновчтой тогтоож чадсан эсэхийг эргэж харах шаардлага байгааг Засгийн газар анхааралдаа авах нь зүйтэй.

Мөн бага насны хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, хүчирхийлэгчдэд оноох ялын бодлогыг чангатгах талаар эхчүүдээс гаргасан саналыг элдэв тайлбараар аргацаан өнгөрөөж болохгүй гэдгийг зориуд тэмдэглэе.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр Монгол Улсын нэг хүнд 2.8 л спирт, 7.9 л архи, дарс, 26.3 литр шар айраг ногдох хэмжээнд

дотоодын үйлдвэрлэл хөгжиж байна. Улсын хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх 12263 цэг байгаа нь 18-аас дээш насны 1000 хүн тутамд 124 ногдож байна гэсэн үг. Энэ нь архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ, хэрэглээ зохист түвшингээс хэт давж, үндэсний аюулгүй байдалд ноцтой сөрөг үр дагавар учруулж байгааг харуулж байна.

Улсын Их Хурлаас баталсан, Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Засгийн газар Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг 2017 онд өргөн мэдүүлэхээр заасан. Хуулийн төслийг хаврын чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх, ингэхдээ архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, нэр төрөл, үйлчлэх цэгийг зохист хэмжээнд хүргэж бууруулах, архины агууламжийн дээд хязгаарыг хуульчлах асуудлыг тусгамаар байна.

Энэ дашрамд дээр дурдсан Үндсэн чиглэлийн хэрэгжилт ямар байгааг холбогдох Байнгын хороо дүгнэж үзэх хэрэгтэйг тэмдэглэе. 2017 онд л гэхэд Засгийн газраас 105 хууль өргөн барих ёстойгоос өргөн барьсан буюу баталсан хуулийн тоо 39, хэрэгжилт 37.1 хувь байна гэсэн дүн гарчээ.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хуулиудын чанар ямар байгаатай хамтатган авч үзэх ёстой гэж үзэж байна. Парламентын бүрэн эрхийн эхний гурван чуулганы дүнгээр баталсан, нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн тоо өмнөх парламентынхаас даруй 83.3 хувь илүү байгаа. Гэхдээ тоо биш, чанар илүү чухал нь хэнд ч ойлгомжтой билээ.

Эрхэм гишүүд ээ,

Авлигатай тэмцэх хуулийг 22 жилийн өмнө батлан гаргаснаас хойш Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид нэгдэх, түүнд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, авлигатай тэмцэх бие даасан байгууллага байгуулах, хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлэх чиглэлээр бид олон ажил хийжээ. Энэ ажил цаашид ч үргэлжилнэ.

Үүний хамт авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй хууль хяналтын байгууллагуудын бие даасан, хараат бус байдлыг хангах ёстой. Нөгөө талаар хууль хяналтын байгууллагууд хуулийг чанд мөрдөж, хүний эрхийг зөрчих, хэлмэгдүүлэх явдлаас ангид байж, шударга, шуурхай ажиллах ёстой.

Хэрэг шалгах явц удааширснаас, тэр нь улс төрийн сэдэв болж өргөждөг, олон түмнийг талцуулдаг, дунд нь хэрэг замхарч, тодорхойгүй болдог үзэгдэл хэвших хандлагатай байгаад онцгой анхаарвал зохино.

“Эрдэнэт” үйлдвэрийг тойрсон асуудлыг одоо шуурхай шийдвэрлэж, хууль зөрчсөн этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх ёстой.

Авлига авсан эсэх хэргийг шалгаж байгаатай холбогдуулаад Оюутолгойн гэрээг цуцлах, хөрөнгө оруулагчдыг хөөх тухай яриа гарч, зарим нам, улстөрчид мэдэгдэл хүртэл хийлээ. Оюутолгойн төслийг хэтэрхий улстөржүүлж, улс төрийн сэдэв болгох нь Монгол Улсын ашиг сонирхолд сөрөг үр дагавар дагуулж болзошгүй. Асуудлыг хуулийн аргаар биш улс төрийн аргаар, улстөрийн ашиг хонжоо олох хэлбэрээр шийдэх буруу хандлага байж болохгүй ээ.

Тиймээс Улсын Их Хурлын даргын захирамжаар “Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргах” үүрэгтэй Ажлын хэсэг байгуулсан. Энэ Ажлын хэсгийн үйл ажиллагаанаас олон нийт дорвитой үр дүн хүсэн хүлээж байгааг ухамсарлаж ажиллавал зохино. Түүнчлэн Дэд ажлын хэсэгтээ мэргэжлийн хүмүүс, иргэний нийгмийн төлөөлөл оруулах нь асуудалд нэгдмэл байр сууринаас хандах, зөв дүгнэлт гаргахад чухал ач холбогдолтой юм.

Оффшорын тухай иргэд уулзалт хийсэн газар бүхэнд ярьсаар байна. Асуудлыг нэг мөр шийдвэрлэхийн тулд төр, засгийн бүх институцүүд, эрх үүрэг хүлээсэн нийт байгууллага хамтарч ажилламаар байна. Дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай хамтрах, тэдний туслалцаа дэмжлэгийг авах асуудал ч байхыг үгүйсгэхгүй.

Оффшорын асуудлаар тусгайлсан хууль, эрх зүйн зохицуулалтыг энэ Их хурал л анх удаа хийсэн. Одоо тэдгээрийн хэрэгжилт, үр дүн бидэнд чухал байна.

Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий хүмүүс оффшор бүсэд данс нээсэн бол хаах, мөнгө байгаа бол буцаан татах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилж, хуулийн этгээд үүсгэсэн бол үйл ажиллагааг нь зогсоох хугацаа өнөөдрөөр дуусгавар болж байгааг энэ дашрамд анхааруулж хэлье.

*Эрхэм гишүүд ээ,
Ерөнхий сайд аа,*

Хэрвээ хямрал тогтворжиж, эдийн засаг өсөж байгаа бол үр шим нь яагаад бидний амьдралд мэдрэгдэхгүй байна вэ гэж иргэд асууж байна. Энэ асуултад тодорхой хариулт өгөх ёстой.

Улсын Их Хурлаас “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” батлахдаа бодит салбарыг дэмжих томоохон төслүүдийг эхлүүлэн, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхээр шийдвэрлэсэн.

Тавантолгойн бүлэг ордыг ашиглах, Тавантолгойн 450 МВТ-ын цахилгаан станцыг барих, Дулааны III цахилгаан станцын 250 МВТ, Чойбалсангийн дулааны цахилгаан станцын 50 МВТ-ын өргөтгөл зэрэг төслүүдийг хэрэгжүүлнэ гэж тэнд тусгасан. Таван толгой-Гашуун сухайт, Нарийнсухайт-Шивээхүрэн, Зүүнбаян-Ханги, Хөөт-Бичигт, Тавантолгой-Сайншанд-Баруун-Урт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг дэмжиж, “Богд хан” төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх шийдвэр хэвээр байгаа.

Эдийн засагт шийдвэрлэх нөлөө үзүүлэх эдгээр томоохон төслүүд хэрхэх нь тодорхойгүй явсаар хоёр жил өнгөрлөө. Төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл бэлэн гэж ойлгож байгаа. Яагаад хэрэгжихгүй байна? Ямар саад тотгор байна вэ?

Эдийн засаг, төсөв, санхүүгийн байдал сайжирч, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж байна. Экспортын орлогын дийлэнхийг бүрдүүлдэг зэс, нүүрсний үнэ өссөн. Үнэ ойрын үед тогтвортой хадгалагдана гэж шинжээчид үзэж байгаа. Ийм таатай байдлыг ашиглахгүй алдвал амаа барихад хүрнэ.

Улсын Их Хурлын түвшинд шийдвэрлэх шаардлагатай асуудал байгаа бол хэлэлцэхэд бэлэн байна. Засгийн газар саналаа оруулж ир. Хаврын чуулганы хугацаанд багтаан том төслүүдээ хөдөлгөө.

Мөн дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссан зэсийн баяжмал болон газрын тос боловсруулах үйлдвэр, нүүрснээс нийлэг, байгалийн хий гаргах үйлдвэр байгуулах төслүүдийг эрчимжүүлье.

Иргэдийнхээ нийгмийн халамж, хамгааллыг орхигдуулалгүйгээр бага ч гэсэн боломж бүрдвэл цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг нэмэхэд зарцуулах нь

зайлшгүй шаардлага болсныг орон нутагт ажиллахдаа Та бүхэн мэдэрсэн байх. Хүүхдийн мөнгийг 80 хувьд биш, шаардлагатай хэсэгт бүрэн олгох, цалин нэмэх асуудлыг 10 дугаар сарыг хүлээлгүй наана нь шийдэхийг хичээх нь зүйтэй.

Хаврын тариалалт хаяанд ирлээ. Өнгөрсөн жил ургац муу авсан. Харин энэ хаврын хувьд хөрсний чийг сайн, зуншлага гайгүй болох төлөвтэйг мэргэжилтнүүд онцолж байна. Тиймээс тариалалтын бэлтгэлийг сайтар хангаж, шаардлагатай үр бордоо, техник хэрэгсэл, шатахуун тосыг нөөцлөн базаахад төр засгаас тодорхой дэмжлэг үзүүлэх нь алдсанаа нөхөж, арвин ургац авах гол нөхцөл болно.

Хаврын салхи шуурга, шар усны үер, ой хээрийн түймрээс сэргийлж, гашуун сургамжаа давтахгүй байхад мэргэжлийн байгууллага, орон нутгийн удирдлага онцгой анхаарах ёстойг сануулж хэлье.

Малын гоц халдварт өвчин малчдыг амьжиргааны эх үүсвэрээ бүрэн алдах хүртэл эрсдэлд хүргэж байна. Зөвхөн 2018 он гарсаар шүлхий өвчний улмаас 4700 гаруй толгой мал устгажээ. Өвчин дэгдэхээр вакцин хайдаг, хөрөнгө дайчилдаг, эцэст нь малчдынхаа малыг устгаж, ажлаа дуусгадаг арга барилаа өөрчлөх цаг болжээ.

Өнгөрсөн онд Улсын Их Хурлаас баталсан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хэр хангагдсан, мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын явц ямар байгаа талаар холбогдох Байнгын хорооноос Засгийн газрын мэдээ, тайланг сонсох хэрэгтэй.

Эрхэм гишүүд ээ,

Иргэд, сонгогчидтойгоо уулзаж явахдаа Та бүхэн “ХАРИУЦЛАГА, ЁС ЗҮЙ” гэсэн үгийг олон удаа сонссон гэдэгт би эргэлзэхгүй байна. Иргэдийг бухимдуулж, төрдөө итгэх итгэлийг нь эздүүлж байгаа энэ асуудалд төр, түмнээ гэсэн сэтгэлээр хандаж, шийдвэртэй арга хэмжээ авах цаг болжээ. Тиймээс хариуцлагатай, ёс зүйтэй байх асуудлыг Улсын Их Хурал өөрөөсөө эхэлнэ хэмээн би сонгогчдодоо амласан.

Эхний ээлжинд Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хариуцлагыг чангатгах ажлаа эхэлнэ.

Та биднийг сонгогчид маань өөрийгөө төлөөлүүлэн Төрд илгээсэн. Тиймээс бид хэн нэгний, эсвэл өөрийнхөө төлөө биш, тэдний төлөө ажиллах ёстой. Өөрийнхөө сайнд сонгогдсон, төрийг би л түшиж байгаа гэж бодож болохгүйн учир энэ. Биднийг төлөөлөх үүргээ гишүүд хариуцлагагүй биелүүлж байна гэж тэд анхааруулж байна. Тиймээс үүргээ муу биелүүлсэн, сонгогчдынхоо итгэлийг алдсан Улсын Их Хурлын гишүүдэд хариуцлага тооцох асуудлыг дээрх хуулиудад тусгах болно.

Улсын Их Хурлын гишүүний ёс зүй Монгол төрийн нүүр царай болж байдаг гэдгийг дор бүрнээ санаж ухаарцгаая.

Эрхэм гишүүд ээ,

Чуулганы завсарлагааны хугацаанд Улсын Их Хурлын гадаад харилцаанд хэд хэдэн чухал үйл явдал болж өнгөрлөө.

Улсын Их Хурлын даргын түвшинд Бүгд Найрамдах Турк Улсад 5 жилийн дараа албан ёсны айлчлал хийж, Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан тэргүүтэй төлөөлөгчид Швейцарийн Женев хотноо болсон Олон Улсын Парламентын Холбооны Ассамблейн 138 дугаар чуулганд оролцлоо. Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Олон Улсын Парламентын Холбооны Ардчилал, хүний эрхийн хорооны товчооны гишүүнээр сонгогдлоо.

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуульд Монголын парламентын төлөөлөгчид анх удаа албан ёсны ажиглагчаар оролцлоо.

Монгол, Хятадын парламент хоорондын байнгын уулзалтын механизмын хоёр дахь уулзалт, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын ассамблей дахь “Торгоны замыг дэмжих бүлэг”-ийн олон улсын анхдугаар бага хуралд хамтран санаачлагчийн хувиар Улсын Их Хурлын төлөөлөл оролцсон.

Эдгээр нь олон улсын түвшинд Монголын парламентын нэр хүнд өсөн нэмэгдэж, байр суурь бэхэжсээр байгаагийн тод илрэл юм.

Бидэнд эрх зүйт төрийг улмаар төлөвшүүлэх, улсаа хөгжүүлэх, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэх, саад бэрхшээлээ арилгах чиглэлээр шийдвэл зохих асуудал, засах нь зайлшгүй алдаа, хийх нь гарцаагүй шинэчлэлийн аль аль нь бий.

Гэхдээ өөрчлөн сайжруулах нэрээр нийгмийн сэтгэл зүйг зориуд бэлдсэн буруу технологиор угаах, эмх замбараагүй байдалд турхирахыг оролдох нь яавч сайн зүйл биш. Төр нь ч, нийгэм нь ч, бодлого нь ч тогтвортой, зөвхөн хуульд захирагдаж, шударга, хариуцлагатай байж чадаж гэмээнэ бид илүү сайнд хүрнэ.

Тиймээс нийт үндэстэн, улсын эрх ашгийг эн тэргүүнээ эрхэмлэхийг ард олондоо, төрийн түшээ Улсын Их Хурлын гишүүддээ хандан уриалъя.

Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулган нээснийг мэдэгдье.



Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа

ХАВРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД (УИХ-ЫН ДАРГА М.ЭНХБОЛД)



Хүн төрөлхтний эв нэгдлийн бэлгэдэл олимпын наадмаас Монгол Улс анх медаль хүртсэний 50 жилийн ойг тохиолдуулан олимпын дэвжээнээс медаль хүртсэн тамирчдын төлөөлөл, ар гэрийнхнийг Төрийн ордонд хүлээн авч уулзлаа.

2018.02.13



Монгол-Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны VIII хуралдаанд оролцсон Бүгд Найрамдах Турк Улсын Шадар сайд, Турк-Монголын Засгийн газар хоорондын хамтарсан хорооны Туркийн хэсгийн дарга Хакан Чавушолуг хүлээн авч уулзлаа.

2018.03.21



Манай улсад айлчилсан БНСУ-ын Үндэсний ассамблейн гишүүн, Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүч, жижиг дунд үйлдвэр болон гарааны бизнесийн байнгын хорооны дарга Жан Бен Ван тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзав.

2018.03.26



УИХ-ын дарга М.Энхболд Банкны салбарын зарим хууль тогтоомжийн эх бичвэр хүлээн авах ёслолд оролцлоо.

2018.03.22



Хүүхдийн хүчирхийллийн эсрэг “Дахин тэвчихгүй” нэртэй тайван жагсаалыг зохион байгуулсан залуу ээжүүд, эмэгтэйчүүдийн төлөөллийг Төрийн ордонд хүлээн авч уулзав.

2018.04.03



Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайд Бинали Йылдырым УИХ-ын дарга М.Энхболдод бараалхав.

2018.04.06



Манай улсад айлчилсан ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Ардын Хурлын дарга Цырен-Даши Эрдынеевич Доржиев тэргүүтэй тус улсын парламентын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.

2018.04.12




ХБНГУ-ын Бундестагийн гишүүн, Бундестагдах Төв Азийн бүлгийн дарга Манфред Грунд тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзав. 2018.05.30



Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Гадаад хэргийн сайд, хатагтай Сушима Сваражтай уулзав.

2018.04.25



УИХ-ын дарга М.Энхболдын урилгаар Ирланд Улсын Парламентын Доод танхимын дарга Шон О'Фарел тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. 2018.04.29



Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн гишүүн, Сейм дэх Польш-Монголын парламентын бүлгийн дарга Марек Жонса тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. 2018.05.21


Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дэвид Уиллиам УИХ-ын дарга М.Энхболдод бараалхлаа. 2018.05.23



“Улсаа аврах ард түмний үндэсний хөдөлгөөн”-ий тэргүүн А.Эрдэнэбаяр тэргүүтэй иргэний нийгмийн төлөөллийг өөрсдийнх нь хүсэлтээр хүлээн авч уулзав. 2018.06.25



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тив, дэлхийд эх орныхоо нэрийг дуурсгасан 50 шилдэг хүүхдэд бэлэг гардууллаа. 2018.06.01



УИХ-ын дарга М.Энхболд БНАСАУ-ын Ардын Дээд Хурлын депутат, Ардын Дээд Хурал дахь БНАСАУ-Монголын парламентын бүлгийн дарга, БНАСАУ-ын Дээд боловсролын сайд, Ким Ир Сений нэрэмжит их сургуулийн захирал Тэ Хён Чөл тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. 2018.06.14



Гамигийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хуралд оролцсон НҮБ-ын Хүн амын сангийн Ази, Номхон далайн бүсийн захирал Бьорн Андерссоныг хүлээн авч уулзлаа. 2018.07.05



ОУВС-гийн Удирдах захирлын орлогч Мицүхира Фүрусава, ОУВС-гийн Монгол дахь суурин төлөөлөгч Нэйл Сакер нарыг хүлээн авч уулзлаа. 2018.06.08



НҮБ-ын «Эрчүүд эмэгтэйчүүдийн төлөө» (HeForShe) хөдөлгөөний ерөнхий зохицуулагч, хатагтай Элизабет Няамаяаро тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. 2018.07.09

НЭГ

ҮЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮҮЛЬ ТОГТООХ
ҮЙЛ АЖИЛААГА

НЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

1.1 УЛСЫН ИХ ХУРЛЫН 2017 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТОЙМ

ХУРАЛДСАН ӨДӨР, ТОО

2018.04.05-2018.06.29



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

61

өдөр

ЧУУЛГАН

27

удаа

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТОО

92

удаа

БАЙНГЫН БОЛОН ДЭД
ХОРООНЫ ХУРАЛДААН

■ бие даасан хууль - 17

■ нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль - 67

■ хүчингүй болсонд тооцох тухай хууль - 5

■ гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай хууль - 2

■ Улсын Их Хурлын тогтоол - 50

УИХ-ЫН ГИШҮҮДЭЭС БОЛОН АЖЛЫН

ХЭСГЭЭС АСУУСАН



АСУУЛТ, ХАРИУЛТ 644

УИХ-ЫН ГИШҮҮД ҮГ ХЭЛСЭН

415 удаа,

26 цаг 42 минут



ТӨРИЙН ОРДОНТОЙ
ТАНИЛЦСАН ИРГЭД

14173



Чуулганы нэгдсэн хуралдаан:

2018.04 сар: 8 удаа 30 цаг 03 минут

2018.05 сар: 10 удаа 47 цаг 51 минут

2018.06 сар: 9 удаа 55 цаг 48 минут

- Чуулганы нэгдсэн хуралдааны явцын талаар нийт 341 хуудас гар тэмдэглэл хөтөлж, 2425 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг дууны бичлэгээс буулгажээ.
- Чуулганы хугацаанд Байнгын хороодын хуралдааны явцын талаар 452 хуудас гар тэмдэглэл хөтөлж, 2805 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдсэн байна.
- Дэд хороодын хуралдааны явцын талаар 30 хуудас гар тэмдэглэл хөтөлж, 181 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг дууны бичлэгээс тус тус буулгасан.



УИХ-ын хаврын чуулганы нээлтийн үйл ажиллагаа



УИХ дахь МАН-ын бүлгийн гишүүд



УИХ дахь АН-ын бүлгийн гишүүд



УИХ-ын Тамгын газрын удирдлагууд

ХОЁР

ҮЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН
ДЭД ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН ДЭД ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Байнгын хороодын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

ХУРАЛДСАН ӨДӨР, ТОО

2018.04.05-2018.06.29



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

101
удаа

БАЙНГЫН ХОРОО БОЛОН ДЭД, ТҮР ХОРООД



ХУРАЛДСАН ТОО

ДЭД ХОРОО

2

удаа

Тусгай хяналтын
дэд хороо

2

удаа

Ёс зүйн
дэд хороо

1

удаа

Төсвийн зарлагын хяналтын
дэд хороо

1

удаа

Тогтвортой хөгжлийн зорилгын
дэд хороо

2

удаа

Халдашгүй байдлын
дэд хороо

1

удаа

Цахим бодлогын
Түр хороо

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Байнгын хорооны **205** санал, дүгнэлт, танилцуулга бэлтгэн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлжээ.



Байнгын хороонд иргэд **337** өргөдөл, гомдол ирүүлж, үүнээс **280** өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн ба албан байгууллага, аж ахуйн нэгжээс **667** албан бичиг ирүүлснээс **482** албан бичгийг хуульд заасан журмын дагуу хянаж, хариу өгсөн.

БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАРЬАЛАЛ

/2018 оны 05 сарын 18-ны өдрийн байдлаар/

№	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	Өргөдлийн байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төсвийн байнгын хороо	Хууль зүйн байнгын хороо	Эдийн засгийн байнгын хороо
1	О.Содбилэг	Л.Элдэв-Очир	Ё.Баатарбилэг	М.Оюунчимэг	Д.Лүндээжанцан	Б.Чойжилсүрэн	Ш.Раднаасэд	Д.Дамба-Очир
2	О.Баасанхүү	Б.Бат-Эрдэнэ	О.Баасанхүү	М.Билэгт	О.Баасанхүү	Ж.Батзандан	О.Батнасан	Б.Баттөмөр
3	С.Батболд	Х.Болорчулуун	Х.Баделхан	Д.Гантулга	Ж.Батзандан	О.Батнасан	С.Бямбацогт	Ж.Бат-Эрдэнэ
4	Б.Бат-Эрдэнэ	Ц.Гарамжав	М.Билэгт	Ц.Гарамжав	С.Бямбацогт	Б.Баттөмөр	Л.Болд	Л.Болд
5	Л.Болд	С.Жавхлан	Д.Ганболд	Д.Дамба-Очир	Б.Жавхлан	Ц.Даваасүрэн	Ж.Ганбаатар	Х.Болорчулуун
6	Д.Лүндээжанцан	Л.Мөнхбаатар	Д.Гантулга	Г.Занданшатар	Г.Занданшатар	Ж.Мөнхбат	Д.Ганболд	Ж.Ганбаатар
7	Ц.Мөнх-Оргил	Г.Мөнхцэцэг	Г.Мөнхцэцэг	Г.Мөнхцэцэг	Н.Амарзаяа	З.Нарантуяа	Ц.Гарамжав	Т.Аюурсайхан
8	Б.Наранхүү	Д.Мурат	Н.Номтойбаяр	Д.Мурат	Ж.Мөнхбат	Б.Наранхүү	Б.Дэлгэрсайхан	Б.Дэлгэрсайхан
9	Х.Нямбаатар	Я.Санжмятав	М.Оюунчимэг	Ё.Баатарбилэг	Б.Наранхүү	Ц.Нямдорж	Л.Мөнхбаатар	Б.Жавхлан
10	Н.Номтойбаяр	Б.Саранчимэг	Я.Санжмятав	Б.Пүрэвдорж	Л.Оюун-Эрдэнэ	Д.Оюунхорол	Ц.Мөнх-Оргил	З.Нарантуяа
11	Н.Оюундарь	Я.Содбаатар	Д.Сарангэрэл	Ш.Раднаасэд	О.Содбилэг	Ш.Раднаасэд	Х.Нямбаатар	М.Оюунчимэг
12	Д.Оюунхорол	Г.Солтан	Б.Саранчимэг	Д.Сарангэрэл	Д.Сумъяабазар	Д.Тогтохсүрэн	Ц.Нямдорж	Д.Тэрбишдагва
13	Л.Оюун-Эрдэнэ	А.Сүхбат	Б.Ундармаа	Г.Солтан	Д.Тогтохсүрэн	Ч.Улаан	Н.Оюундарь	Б.Ундармаа
14	Я.Санжмятав	Г.Тэмүүлэн	А.Ундраа	А.Сүхбат	Д.Хаянхярваа	Ч.Хүрэлбаатар	Б.Пүрэвдорж	Я.Содбаатар
15	Т.Аюурсайхан	Д.Тэрбишдагва	Н.Учрал	Д.Тогтохсүрэн	Н.Цэрэнбат	Н.Амарзаяа	Ж.Батзандан	С.Чинзориг
16	А.Ундраа	Д.Цогтбаатар	Ц.Цогзолмаа	Н.Цэрэнбат	М.Энхболд	Г.Тэмүүлэн	Н.Учрал	Б.Чойжилсүрэн
17	Б.Энх-Амгалан	Б.Батзориг	С.Чинзориг	Б.Энх-Амгалан	Н.Энхболд	Ө.Энхтүвшин	Л.Энхболд	Л.Элдэв-Очир
18	Ж.Энхбаяр	Ж.Энхбаяр	Л.Энх-Амгалан	Л.Энхболд	Д.Эрдэнэбат	С.Эрдэнэ	С.Эрдэнэ	Л.Энх-Амгалан
19	Н.Энхболд	Д.Эрдэнэбат	С.Эрдэнэ	С.Эрдэнэ	Ж.Эрдэнэбат	Ж.Эрдэнэбат	Ж.Эрдэнэбат	Д.Эрдэнэбат

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

/2018.06.28-ны өдрийн байдлаар/

№	Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төсвийн байнгын хороо	Хууль зүйн байнгын хороо	Эдийн засгийн байнгын хороо	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
1	С.Батболд	С.Бямбацогт	Б.Жавхлан	З.Нарантуяа	Н.Оюундарь	Ж.Ганбаатар	А.Ундраа	О.Содбилэг	А.Сүхбат
2	Л.Болд	Х.Баделхан	Н.Амарзаяа	Н.Амарзаяа	Ж.Батзандан	Т.Аюурсайхан	Ё.Баатарбилэг	Н.Амарзаяа	Б.Батзориг
3	Н.Номтойбаяр	С.Бямбацогт	О.Баасанхүү	О.Батнасан	Л.Болд	Ж.Бат-Эрдэнэ	Д.Гантулга	Ж.Батзандан	Г.Мөнхцэцэг
4	Д.Оюунхорол	Л.Мөнхбаатар	Ж.Мөнхбат	Б.Баттөмөр	Д.Ганболд	Х.Болорчулуун	М.Оюунчимэг	Д.Сумъяабаазар	Д.Мурат
5	Н.Энхболд	Б.Наранхүү	Б.Наранхүү	Ц.Даваасүрэн	Б.Дэлгэрсайхан	Д.Дамба-Очир	Я.Санжмятав	Д.Хаянхярваа	Б.Саранчимэг
6	Б.Энх-Амгалан	Д.Сарангэрэл	Л.Оюун-Эрдэнэ	Б.Наранхүү	Б.Пүрэвдорж	З.Нарантуяа	Б.Саранчимэг	Н.Цэрэнбат	Я.Содбаатар
7	Я.Санжмятав	Д.Тогтохсүрэн	Н.Цэрэнбат	Д.Тогтохсүрэн	Ш.Раднаасэд	С.Чинзориг	Ц.Цогзолмаа	Д.Эрдэнэбат	Г.Солтан
8		Г.Тэмүүлэн	Д.Эрдэнэбат	Ч.Улаан	Н.Учрал	Л.Элдэв-Очир	С.Эрдэнэ	Д.Тэрбишдаваа	
9		М.Энхболд		Ч.Хүрэлбаатар	Л.Энхболд		С.Чинзориг		Д.Эрдэнэбат
10		Д.Эрдэнэбат							

Нэг.АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО



АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны хаврын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
О.СОДБИЛЭГ



19 ГИШҮҮН

13
удаа **ХУРАЛДААН**

АЖЛЫН ХЭСЭГ

3 удаа	БАЙГУУЛЖ
4 удаа	ХУРАЛДСАН ТОО

- Хуулийн төсөл - **17**
- УИХ-ын тогтоолын төсөл - **3**
- Зөвшилцөх асуудал - **10**
- Байнгын хорооны тогтоол - **4**
- Санал, дүгнэлт - **28**
- Танилцуулга - **7**
- Зарчмын зөрүүтэй саналын томъёолол - **69**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Ирсэн албан бичиг **78**
Явуулсан албан бичиг **32**

Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалын хүрээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, гадаад бодлогын хэрэгжилтийг хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлаар санал, дүгнэлт гаргах, Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх, эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх, үүрэг, чиглэл өгөх, Улсын Их Хурлын гишүүд болон Байнгын хорооны гишүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд чиглэн ажилласан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийг нэмэгдүүлэн 7 жил болгосон нь тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээнд өөрчлөлт оруулах эсэх, даатгуулагчийн эрх ашгийг хэрхэн хөндөж байгаа талаарх санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулж Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын дэд хэсэгт ажлын албанаас орж ажиллан, ажлын хэсгийн 1, ажлын дэд хэсгийн 3 удаагийн хуралд оролцож, саналаа бэлтгэн танилцуулсан.

Орон нутгийн хамгаалалтын тухай, Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн холбогдох хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг 1, ажлын дэд хэсэг 1 удаа тус тус хуралдсан.

Хяналт шалгалтын ажлын талаар:

Тус Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын үйл ажиллагаатай танилцаж, мэдээ, мэдээллийг сонссон. Мөн “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дүнгийн талаарх асуудлыг Байнгын хорооны хурлаар сонсож, танилцав. 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Байнгын хорооны дарга О.Содбилэг болон ажлын албаны ажилтнууд Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн үйл ажиллагаа, артиллерийн байлдааны буудлагатай хээрийн сургуультай танилцав.

Мөн Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар зэрэг байгууллагуудаас эрхлэх асуудлынхаа хүрээнд шаардлагатай мэдээллийг авч ажиллалаа.

Бусад ажлын талаар:

2018 оны 04 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан “Гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох асуудал: Монгол Улсын жишээ” сэдэвт олон улсын бага хурал, 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа, гишүүний ёс зүй, хариуцлага” сэдэвт хэлэлцүүлэг, 2018 оны 05 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Үндэсний Батлан хамгаалах Их сургуульд зохион байгуулагдсан “Мэдээллийн аюулгүй байдал: онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулагдсан “Парламентын хяналт: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, “Солонгосын нэгдлийг хангах нь” сэдэвт олон улсын бага хурал, 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хурал, Азийн Хүн амын хөгжлийн нийгэмлэг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сантай хамтран зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхэд парламентын гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг сайжруулах нь” сэдэвт Ази-Номхон далайн бүсийн орнуудын парламентчдын ээлжит зөвлөгөөн, 2018 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын бага хуралд Байнгын хорооны дарга О.Содбилэг, Байнгын хорооны гишүүд болон ажлын албаны ажилтнууд оролцов.

Байнгын хорооноос хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл 39870 хуудас бүхий материалыг олшруулан тарааж, архивт нийт 637 хуудас бүхий 6 хууль, тогтоолын хувийн хэрэг, 481 хуудас бүхий 3 боть зөвшилцсөн гэрээ, конвенцын хувийн хэрэг, 12 хуудас бүхий 1 боть албан тушаалтан томилох, чөлөөлөх асуудлын хувийн хэрэг, 250 хуудас бүхий 1 боть хууль, тогтоолын эх ноорог, 194 хуудас бүхий 1 боть хуралдааны тэмдэглэлийг тус тус архивын нэгж болгон хүлээлгэн өгсөн.



Байнгын хорооны дарга О.Содбилэг ОХУ-ын Зэвсэгт хүчний жанжин штабын Цэргийн академийн захирал, хурандаа В.Б.Зарудницкийг хүлээн авч уулзав 2018.04.25



Байнгын хорооны дарга О.Содбилэг болон гишүүд олон улсын бага хуралд оролцсон Афганистан, Бутан, Киргизстан, Мьянмар, Лаос, Шри Ланка зэрэг улсын төлөөлөгчдийг Төрийн ордонд хүлээн авч уулзлаа. 2018.04.27

Хоёр.БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО



БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны хаврын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Л.ЭЛДЭВ-ОЧИР



19 ГИШҮҮН

12
удаа

ХУРАЛДААН

- Хуулийн төсөл давхардсан тоогоор - 24
- УИХ-ын тогтоолын төсөл - 3
- Сайдын мэдээлэл - 7
- Байнгын хорооны тогтоол - 3
- Санал, дүгнэлт - 11
- Зарчмын зөрүүтэй саналын томъёолол - 49
- Танилцуулга - 2

Хууль 4

Улсын Их Хурлын тогтоол 1 батлуулсан

АЖЛЫН ХЭСЭГ

1
удаа

БАЙГУУЛЖ

20
удаа

ХУРАЛДСАН
тоо

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Ирсэн албан бичиг 41
Шийдвэрлэсэн албан бичиг 27

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Баяжуулсан хүнсний тухай хууль, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Баяжуулсан хүнсний тухай хууль баталсантай холбогдуулан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2018 оны 30 дугаар тогтоолыг тус тус хэлэлцүүлэн батлуулсан.

Мөн “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хорооны 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүллээ.

Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот тогтоолоор байгуулж, Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва, Б.Батзориг, Л.Мөнхбаатар, Д.Мурат нар ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хорооны 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хийж санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүллээ.

Хяналт, шалгалтын ажлын талаар:

Тус Байнгын хорооны гишүүд болон Байнгын хорооны ажлын алба Өргөдлийн байнгын хороотой хамтран 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Туул голын хамгаалалтын бүсэд олгосон тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан, хууль бусаар үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нөхцөл байдалтай танилцлаа.


Бусад ажлын талаар:

Байнгын хороотайлангийн хугацаанд харьяа яам, сайд, байгууллагуудын тайлан, мэдээллийг хуралдаанаараа сонсож, тэдгээрийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч цаашид эрчимжүүлэх чиглэлээр тодорхой үүрэг, чиглэл өгч ажилласан. Түүнчлэн Байнгын хорооноос хэлэлцүүлэг, зөвлөгөөн, сургалт зохион байгуулав. Тухайлбал, Тус Байнгын хороо Монголын хүнс, хөдөө аж ахуйн үндэсний ассоциацтай хамтран “Хамтдаа хөгжье” уриан дор “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил-Иргэдийн оролцоо” сэдэвт VIII зөвлөгөөнийг 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Мөн Байнгын хороо Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Био аюулгүй байдлыг хангах үндэсний хороо болон Европын холбооны Хими, биологи, цацраг идэвхт болон цөмийн эрсдэлийг бууруулах (CBRN CoE initiative) санаачилгатай хамтран “Төв Азийн орнуудад биоаюулгүй байдал, биоаюулгүй ажиллагааг хангах үндэсний эрхзүйн орчныг сайжруулах P53” бүсийн төслийг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудад “Биоаюулгүй байдал, биохамгаалал” сэдэвт сургалт, семинарыг 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа.


Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн санаачилгаар хуулийн төсөлтэй холбогдуулан сонирхогч талуудын оролцоог хангах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Ус сувгийн удирдах газарт зохион байгуулсан.



“Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил-иргэдийн оролцоо” сэдэвт наймдугаар зөвлөгөөнд Байнгын хорооны дарга Л.Элдэв-Очир оролцоо. 2018.04.13



Байнгын хорооны дарга Л.Элдэв-Очир НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн суурин төлөөлөгчтэй уулзав. 2018.05.25



Байнгын хорооны дарга Л.Элдэв-Очир НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Шадар захирал, Ази, Номхон далайн бүсийн Суурин төлөөлөгч хатагтай Кундави Кадиресан тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзав. 2018.07.05

Гурав.НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО



НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны хаврын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ё.БААТАРБИЛЭГ



19 гишүүн

10
удаа

ХУРАЛДААН

АЖЛЫН ХЭСЭГ

4

удаа

БАЙГУУЛЖ

30

удаа

ХУРАЛДСАН
ТОО

- Хууль - **5**
- УИХ-ын тогтоолын төсөл - **2**
- Байнгын хорооны тогтоол - **7**
- Харьяа байгууллагын тайлан - **2**
- Хяналт, шалгалтын ажлын тайлан - **5**
- Санал, дүгнэлт - **18**
- Зарчмын зөрүүтэй саналын томъёолол - **31**
- Танилцуулга - **5**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Ирсэн албан бичиг **262**
Шийдвэрлэсэн албан бичиг **262**

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Багшийн хөгжлийг дэмжих тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд, “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” /“Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” 1998 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 55/, “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” /“Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 95/ Улсын Их Хурлын тогтоолыг тус тус хэлэлцэж, батлуулсан.

Түүнчлэн Байнгын хорооны анхны хэлэлцүүлгийн шатанд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох, тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Нөхөн үржихүйг дэмжих зохицуулалтын тухай хуулийн төсөл, Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн төслүүд, “Бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж байна.

Хяналт шалгалтын ажлын талаар:

Тайлангийн хугацаанд Байнгын хорооны тогтоолоор эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалтын чиг үүрэг бүхий Ажлын хэсгүүдийг байгуулж, холбогдох яам, харьяа агентлагт Улсын Их Хурлаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцтай танилцаж, биелэлтэд хяналт тавьж ажилласан бөгөөд ажлын хэсэг дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

1/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилт, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагаатай танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулж тус Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцэж, Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өглөө. Хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэнэ.

2/Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн хэрэгжилтийг

шалгах, Монгол Улсын Консерватор /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийн үйл ажиллагаа, санхүүжилт, мэргэжлийн урлагийн салбарын хүний нөөцийг бэлтгэж байгаа байдалтай танилцах, цаашид авах арга хэмжээний тухай шийдвэрийн төсөл боловсруулж Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцэж, Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөн.

3/Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулан хийж гүйцэтгэсэн ажил, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангийн зарцуулалтыг шалгаж, санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулж, Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар сонслоо.

4/Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулж Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцэж, шинэчлэн боловсруулж байгаа хуулийн төсөлд анхаарах санал бүхий Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөн. Хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэнэ.

5/Монгол Улсын Их Хурлаас Азийн Хүн амын хөгжлийн нийгэмлэг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сантай хамтран “Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхэд парламентын гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг сайжруулах нь” сэдэвт Ази, Номхон далайн бүсийн орнуудын парламентчдын ээлжит зөвлөгөөнийг зохион байгуулахад оролцсон.

Бусад ажлын талаар:

Байнгын хорооноос есөн удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. Тухайлбал, “Элэгний эмгэггүй Архангай-1” төслийн үр дүнг танилцуулах уулзалт, “Боловсролын хөгжил, шинэчлэлд төрийн бус ерөнхий боловсролын сургуулиудын оролцоо”, “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, цаашид тавих зорилт”, “Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “Гэр бүлийн талаарх бодлого, эрх зүйн шинэчлэл”, “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулах уулзалт, хэлэлцүүлэг болон “Эх, нярайн яаралтай тусламж” сэдэвт сургалт, “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулах уулзалт, “Сүрьеэ өвчний эрт илрүүлгийг зохион байгуулах, цаашид авах арга хэмжээний тухай” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.



Байнгын хорооны дарга Ё.Баатарбилэг ХБНГУ-ын Фридрих Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Нигелс Хэгвишийг хүлээн авч уулзлаа. 2018.04.23



Байнгын хорооноос “Боловсролын хөгжил, шинэчлэлд төрийн бус ерөнхий боловсролын сургуулиудын оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг Багийн хөгжлийн ордонд зохион байгуулсан. 2018.04.25



Байнгын хорооноос “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. 2018.05.08



Байнгын хорооны дарга Ё.Баатарбилэг болон гишүүд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн үйл ажиллагаатай танилцлаа. 2018.04.25



Байнгын хорооны гишүүд Халдварт өвчин судлалын үндэсний төвд ажиллаж, Сүрьеэгийн клиникийн үйл ажиллагаатай танилцав. 2018.05.16



Байнгын хорооноос “Сүрьеэгүй Монгол” хөтөлбөрийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулав. 2018.06.06

Дөрөв.ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО



ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны хаврын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



19 ГИШҮҮН

14
удаа

ХУРАЛДААН

- Хуулийн төсөл - **4**
- УИХ-ын тогтоол - **21**
- Байнгын хорооны тогтоол - **5**
- Харьяа байгууллагын тайлан - **3**
- Томилох, чөлөөлөх асуудал - **7**
- Цэцийн дүгнэлт - **1**
- Санал, дүгнэлт - **30**
- Танилцуулга - **4**

АЖЛЫН ХЭСЭГ

3

удаа

БАЙГУУЛЖ

28

удаа

ХУРАЛДСАН
ТОО

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Ирсэн албан бичиг **58**

Явуулсан албан бичиг **52**

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Тайлангийн хугацаанд Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах, Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж ажиллав.

Тус байнгын хороо хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4, Улсын Их Хурлын тогтоолын төсөл 18-ыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлууллаа.

Бусад ажлын талаар:

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газрын 2017 оны үйл ажиллагаа, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай мэдээллийг сонсож, Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгсөн.

Түүнчлэн Улсын Их Хурлын даргын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 78 дугаар захирамжаар “Зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий” ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцангаар ахлуулан 27 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэг байгуулагдсан өдрөөс хойших хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1/Ажлын хэсгийн ахлагч, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Лүндээжанцангийн шийдвэрээр төслийн сэдэв тус бүрт хамаарах төслийг боловсруулах үүрэг бүхий таван ажлын дэд хэсэг байгуулж, дэд хэсгүүд Зөвлөлдөх санал асуулгын үр дүнд дүн шинжилгээ, дүгнэлт хийж, гадаад, дотоодын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж, таван бүлэг асуудлаар нийт 22 заалт бүхий Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн эхний хувилбарыг боловсруулж, 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хурлын даргад танилцуулсан.

2/Улсын Их Хурлын даргад танилцуулсан 22 заалт бүхий төслийг Монгол Улсын Их Хурлын 2017 оны 39 дүгээр тогтоолын дагуу олон нийтэд танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан. Тухайлбал,

Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа, мэдээлэл, лавлагааны албанаас хийсэн 86 харьцуулсан судалгаанаас төслийн зүйл, заалт бүрт холбогдох судалгааг түүвэрлэн эмхэтгэж, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар”-ыг боловсруулан боть хэлбэрээр хэвлүүлэн холбогдох сургалт, хэлэлцүүлгийн материалыг боловсруулан, сургагч багш нарыг бэлтгэсэн.

3/2017 оны 07-10 дугаар сарын хугацаанд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 68 удаагийн бүсчилсэн хэлэлцүүлэг зохион байгуулж, улсын хэмжээнд нийт 327,375 иргэнээс 5,584.832 саналыг хүлээн авсан.

4/Иргэдээс ирүүлсэн саналд ангилал, дүн шинжилгээ хийж, хамгийн өндөр давтамжтай гарсан иргэдийн саналд үндэслэн төслийг дахин боловсруулсан. Мөн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх дэгийн асуудал, цагалбар, төлөвлөгөө, ажлын болон дэд хэсгийн ажил, үүргийн хуваарь, хэлэлцүүлгийн шалгах хуудсыг боловсруулж, хэлэлцүүлгийн бэлтгэлийг хангаж ажиллав.

5/Ажлын хэсэг төслийг 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлэгт танилцуулж, бүлгийн хурлаас гарсан санал, зөвлөмжүүдийг үндэслэн долоон чиглэл (зорилго)-ээр 28 заалт бүхий төслийг дахин боловсруулсан. Ингэхдээ 28 заалтаас 11 заалтыг тус бүр гурван хувилбартайгаар боловсруулсан.


6/Ажлын хэсэг төслийг 2017 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Ардын Намын бүлэгт дахин танилцуулж, эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах ажлын дэд хэсэг”-ийг байгуулсан бөгөөд 04 дүгээр сарын 30-наас 05 дугаар сарын 10-ны өдрийн хооронд ажиллаж 53 заалт бүхий төслийн хувилбар санал болгосон.

7/Ажлын хэсэг 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Ардчилсан Намын бүлэгт долоон чиглэлээр 40 заалт бүхий төслийг танилцуулж, Ардчилсан Намын бүлгээс гарсан санал, зөвлөмжийг судлан ажиллаж долоон чиглэлээр 42 заалт бүхий төслийг боловсрууллаа.


Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийт, улс төрийн намын бүлгүүд, эрдэмтэн, судлаачдад танилцуулан хэлэлцүүлж, тэдгээрээс гаргасан саналуудад дүн шинжилгээ, холбогдох судалгааг хийж, төсөлд оруулах шаардлагатай өөрчлөлтийг тухай бүр тусгаж олон нийтэд ойлгомжтой энгийн хувилбараар болон хууль зүйн техникт оруулсан хувилбарыг тус тус боловсруулаад байна.



Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн “Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа, гишүүний ёс зүй, хариуцлага” сэдэвт хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулав.
2018.05.02



Байнгын хорооны дарга Д.Лүндээжанцан Азийн сангийн суурин төлөөлөгч Марк Кэйнигтэй уулзаж, хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.
2018.04.16



Байнгын хорооны дарга Д.Лүндээжанцан ОХУ-ын Сонгуулийн төв комиссын гишүүн Сябшах Магамедович Шатиевийг хүлээн авч уулзав.
2018.06.25

Тав.ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО



ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны хаврын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Б.ЧОЙЖИЛСҮРЭН



19 ГИШҮҮН

13
удаа

ХУРАЛДААН

АЖЛЫН ХЭСЭГ

3

удаа

БАЙГУУЛСАН

9

удаа

ХУРАЛДСАН
ТОО

- Бие даасан хууль - **5**
- Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай - **1**
- УИХ-ын тогтоолын төсөл - **4**
- Гэрээ, хэлэлцээр зөвшилцөх - **4**
- Санал, дүгнэлт - **31**
- Танилцуулга - **6**
- Зарчмын зөрүүтэй санал - **33**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Ирсэн албан бичиг **71**

Явуулсан албан бичиг **53**

Төсвийн байнгын хороо нь Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг хэлэлцэн батлах, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Төрийн аудитын байгууллагын 2017 оны үйл ажиллагааны тайлан, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг тодорхойлох, гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ, хэлэлцээрийг зөвшилцөх талаар санал, дүгнэлт гаргах, хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр голлон ажиллалаа.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Улсын Их Хурлын 2018 оны Хаврын ээлжит чуулганы хугацаанд бие даасан хууль 5, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1 хуулийн төсөл, Улсын Их Хурлын 4 тогтоолыг хэлэлцэж, батлуулсан. Олон улсын зээлийн гэрээ болон хэлэлцээрийн төсөл 4-ийг зөвшилцсөн.

Байнгын хорооноос хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх талаар 15, анхны хэлэлцүүлгийн 16 санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар 6 танилцуулга, анхны болон эцсийн хэлэлцүүлгийн үед 33 зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.

Байнгын хорооны дотоод ажлын талаар:

Байнгын хорооноос гадаадын зочид, төлөөлөгчидтэй таван удаа уулзалт зохион байгуулж, тухай бүр тэмдэглэл хөтлөн ажиллалаа.

Байнгын хорооноос хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон холбогдох 965 хуудас баримт бичгийг олшруулан хувилж нийт 51379 хуудас материалыг Улсын Их Хурлын гишүүд болон холбогдох албан тушаалтнуудад тараасан байна. Ээлжит чуулганы хугацаанд батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хувийн хэрэг хоёр нэгж /нийт 418 хуудас/, хуралдааны тэмдэглэл нэг нэгж /218 хуудас/-ийг тус тус бүрдүүлж, архивт хүлээлгэн өгсөн.

Бусад ажлын талаар:


Байнгын хорооны 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Төрийн аудитын байгууллагын талаар авах зарим арга хэмжээг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон Үндэсний аудитын газарт тус тус үүрэг чиглэл өглөө.

Мөн Байнгын хорооны 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын Тамгын газрын 2019 оны төсвийн төслийг хэлэлцэж Улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.

Түүнчлэн Байнгын хорооны 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны төсвийн төслийг хэлэлцэж Улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэв.



Байнгын хорооны дарга Б.Чойжилсүрэн Олон улсын валютын сангийн Ажлын хэсгийн ахлагч Жеофф Готтлиб, тус сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Нэйл Сакер нарыг хүлээн авч уулзав. 2018.05.09



Байнгын хорооны дарга Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан нар манай улсад ажилласан Нидерланд улсын Засгийн газрын төлөөлөгч, Сангийн яамны ажилтан Чиэрд Тим, Хайс Баккер нарыг хүсэлтээр нь хүлээн авч уулзлаа. 2018.06.05

Байнгын хорооны дарга Б.Чойжилсүрэн Монгол Улс дахь Европын Холбооны Төлөөлөгчийн газрын хэргийг түр хамаарагч Марко Фэрриг хүлээн авч уулзав. 2018.04.25



Зургаа.ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО



ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны хаврын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ш.РАДНААСЭД




18 ГИШҮҮН

12
удаа

ХУРАЛДААН

- Хэлэлцсэн асуудал - **43**
- Хуулийн төсөл - **28**
- Цэцийн дүгнэлт - **3**
- УИХ-ын тогтоолын төсөл - **4**
- Харьяа байгууллагын тайлан - **2**
- Хяналт шалгалтын ажлын тайлан - **1**
- Томилох, чөлөөлөх асуудал - **5**
- Санал, дүгнэлт - **31**
- Танилцуулга - **6**
- Зарчмын зөрүүтэй санал - **119**

АЖЛЫН ХЭСЭГ



ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Ирсэн албан бичиг **50**
Явуулсан албан бичиг **33**

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Хууль зүйн байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудлыг хэлэлцэж, санал, дүгнэлт, танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэн холбогдох Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлээ.

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулиуд, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулиуд, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулиуд, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулиуд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулиуд, Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолуудыг батлууллаа.

Мөн “Хуулийн төсөл буцаах тухай”, “Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай”, “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай”, “Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 08 дугаар дүгнэлтийн тухай”, “Прокурорын албан тушаалын цалин, зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээ, албан ажлын онцгой нөхцөлийн болон төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг батлуулав.

Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04, 07, 08 дугаар дүгнэлт, Улсын Их Хурлын 2018 оны 45, 47 дугаар тогтоолд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг тус тус хэлэлцэв.

Хяналт шалгалтын ажлын талаар:

Ээлжит чуулганы хугацаанд Архидан согтуурахтай тэмцэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай

хуулийн хэрэгжилттэй танилцах, холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсэг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагаатай танилцсан.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2018 оны 05 дугаар 22-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газарт ажиллав.

Олон улсын парламентын холбооны Удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн шийдвэрийг судалж, холбогдох санал, дүгнэлт гарган Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон хохирогчийн хууль ёсны төлөөлөлтэй уулзаж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад холбогдох хууль тогтоомж, үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх зөрчигдсөн эсэх талаар тодруулга авав.

Хүний эрхийн дэд хорооны гишүүд 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагаатай танилцлаа.

Бусад ажлын талаар:

Хууль зүйн байнгын хороо батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулийн давхардал, хийдлийг арилгах, хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам, Фридрих Эбертийн сантай хамтран “Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт”, “Оюуны өмчийн эдийн засагт оруулах хувь нэмэр, оюуны өмчийн үнэлгээ, хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөл” сэдвээр гурван хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулав.

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сан болон e-justice.mn сайтын нээлтийн үйл ажиллагаанд оролцож, Говь-Алтай аймгийн удирдах ажилтны “Сахилга хариуцлагатай төрийн алба-2018” сэдэвт анхдугаар зөвлөгөөнд оролцогчдын дунд Захиргааны ерөнхий хууль болон Зөрчлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулав.



Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Хууль зүйн байнгын хороотой хамтран “Оюуны өмчийн эдийн засагт оруулах хувь нэмэр, оюуны өмчийн үнэлгээ, хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. 2018.04.04



Байнгын хорооны зарим гишүүдээс санаачлан боловсруулсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг Төрийн ордонд болов. 2018.05.09



Хууль зүйн байнгын хорооны гишүүд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд ажиллав. 2018.04.30

Долоо.ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО



ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны хаврын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Д.ДАМБА-ОЧИР



19 ГИШҮҮН

14
удаа

ХУРАЛДААН

АЖЛЫН ХЭСЭГ

16

удаа

БАЙГУУЛСАН

35

удаа

ХУРАЛДСАН
ТОО

- Хэлэлцсэн асуудал - **38**
- Хуулийн төсөл - **4**
- УИХ-ын тогтоолын төсөл - **7**
- Санал, дүгнэлт - **28**
- Зарчмын зөрүүтэй санал - **30**
- Гэрээ, хэлэлцээр зөвшилцөх - **4**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Ирсэн албан бичиг **119**

Явуулсан албан бичиг **55**

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны үйл ажиллагаа 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Банкны салбарын тогтвортой байдлыг хангах зарим хууль, тогтоомжуудыг хэлэлцэн батлах, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг дүгнэж, 2019 оны хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох, Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай, Таван толгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай, Төрөөс төмөр замын тээвэр болон иргэний нисэхийн салбарын талаар баримтлах бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүдийг томилох тухай Улсын Хурлын тогтоолуудыг батлах, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн төсөл, Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Байнгын хорооны санал, дүгнэлт гаргаж, хэлэлцүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зарим яам, газруудын тайлан, мэдээлэл сонсож, үүрэг чиглэл өгөх зэрэгт чиглэгдсэн байна.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хороо давхардсан тоогоор 38 асуудал хэлэлцэж, тэдгээр асуудлаар нийтдээ 28 санал дүгнэлт, танилцуулга бэлтгэн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсний зэрэгцээ хууль, тогтоомжийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх чиглэлээр 16 ажлын хэсэг байгуулан ажиллав.

Ээлжит чуулганы хугацаанд нийт **4** хууль, **7** тогтоолыг эцэслэн батлуулж, Олон улсын **4** гэрээ, хэлэлцээрийн төслийг зөвшилцлөө.

Хяналт, шалгалтын чиглэлээр:

“Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн талаарх Монгол Улсын Шадар сайдын мэдээлэл, Зээлийн хүүг бууруулах стратеги боловсруулсан талаарх Монголбанкны Ерөнхийлөгчийн мэдээлэл сонсох ажлыг зохион байгуулж, үүрэг чиглэл, зөвлөмжүүдийг Байнгын хорооны тогтоол болон хуралдааны тэмдэглэл хэлбэрээр хүргүүлэв.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаарх Монголбанкны Ерөнхийлөгчийн мэдээллийг сонссонтой холбогдуулан банк, санхүүгийн салбарт тулгамдаж буй асуудлын талаар Байнгын хорооноос тогтоол гаргаж хүргүүлэв.

Санхүүгийн зохицуулах хорооны болон Үндэсний статистикийн хорооны 2017 оны үйл ажиллагааны тайланг сонссоны үр дүнд тухайн салбарт тулгамдаад байгаа зайлшгүй шийдвэрлэх асуудлын талаар “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоол гаргаж хүргүүлсэн.

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн, даатгалын болон бусад холбоодоос Санхүүгийн зохицуулах хорооны даргатай холбогдуулан гаргасан санал, гомдлын мөрөөр Улсын Их Хурлын даргын захирамжаар Ажлын хэсэг байгуулан, Байнгын хороогоор уг Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох ажлыг зохион байгуулж, үүрэг чиглэл, зөвлөмжүүдийг өгөв.

Улсын Их Хурлын даргын захирамжаар “Оюу толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны хэрэгжилт, төсөв, санхүүгийн, Бүс нутгийн хөгжил, дэд бүтцийн, Уул уурхай, байгаль орчин, газрын харилцааны, Хөрөнгө оруулалтын болон бусад гэрээний хэрэгжилт, үр дүнг тооцох зэрэг таван чиглэлээр дэд ажлын хэсэг байгуулан ажиллав.

Банкны зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчныг бүрдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанк, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх ажлын хэсэг байгуулан ажиллаж, “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолыг баталж, хүргүүлээд байна.

Бусад ажлын талаар:

Энэ хугацаанд тус Байнгын хорооноос хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон бусад материалыг 77 удаа олшруулж тараасан.

Ээлжит чуулганы хугацаанд батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хувийн хэрэг дөрвөн нэгж, хуралдааны протокол 11 нэгж, албан бичиг дөрвөн нэгжийг тус тус бүрдүүлж, архивт хүлээлгэн өгөв.



Байнгын хорооны дарга Д.Дамба-Очир Дэлхийн банкны төлөөлөгчдийг хүсэлтийнх нь дагуу хүлээн авч уулзлаа. 2018.04.02



Байнгын хорооны дарга Д.Дамба-Очир Бүгд Найрамдах Польш Улсын парламент (Сейм)-ын гишүүн, Сейм дэх Польш, Монголын парламентын бүлгийн дарга Марек Жонса тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзав. 2018.05.21

Найм.ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО



ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны хаврын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
М.ОЮУНЧИМЭГ



18 ГИШҮҮН

5

удаа

ХУРАЛДААН

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ



- Хэлэлцсэн асуудал - **7**
- Байнгын хорооны тогтоол - **4**
- Хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг - **1**

эцэслэн шийдвэрлэсэн өргөдөл **237**
шийдвэрлэх шатанд **40** өргөдөл байна

Байнгын хороогоор хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлын талаар:

Өргөдлийн байнгын хороо нийт таван удаа хуралдаж, долоон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж дөрвөн тогтоол, Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээр нэг удаа Монгол Улсын Засгийн газарт үүрэг, чиглэл өгч иргэдийн өргөдлөөр тавигдсан асуудлыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

Байнгын хорооны 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар тус Байнгын хорооноос гаргасан “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 02, 03 дугаар тогтоолуудын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонсов.

Түүнчлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны холбогдох албан тушаалтны мэдээллийг сонссон. Уг хуралдаанаас Өргөдлийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолын 1 дэх заалтыг “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх” гэж өөрчлөн найруулж, Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг батлав.

Мөн түрээсийн орон сууцанд оруулж өгөхийг хүссэн 700 гаруй иргэдийн өргөдлийн талаар хэлэлцэв. Уг асуудлаар Байнгын хороо хоёр удаа, Ажлын хэсэг дөрвөн удаа хуралдаж, “Буянт-Ухаа 2” хороололд Ажлын хэсгийн гишүүд нэг удаа ажилласан. Иргэдийн орон сууцанд хамрагдах нэгдсэн мэдээлийн сан бий болгох, иргэдийн түрээсийн орон сууцаа өөрийн өмчлөлд авах хүсэлтийн дагуу холбогдох журмуудад өөрчлөлт оруулах, дахин төлөвлөлтөөс хохирсон иргэдийн асуудал, ипотекийн 8 хувийн зээлийг үргэлжлүүлэн олгох чиглэлийг тус Байнгын хорооны тогтоолоор Монгол Улсын Засгийн газар, холбогдох яамдуудад өглөө.

“Заша өвс төв” төрийн бус байгууллага болон 927 иргэнээс аюултай хог хаягдал болох химийн бодис хадгалах зориулалттай хуванцар сав, нийлэг уутыг ахуйн зориулалтаар өргөн хэрэглэдэг нь нийгмийн эрүүл мэндэд болон байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй орчныг бохирдуулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөж байгаа асуудлаар ирүүлсэн өргөдлийг хэлэлцэж тогтоол гаргав.

Туул голын бохирдлын асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу Байнгын хорооноос холбогдох байгууллага, албан тушаалтнаас тайлбар авах, мэдээлэл, судалгаа гаргуулах, газар дээр нь нөхцөл байдалтай танилцах, ажлын

хэсэг байгуулах, хэлэлцүүлэг хийх зэрэг үйл ажиллагааг явуулсны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх 02, 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсов.

Хяналт шалгалтын ажлын талаар:

Өргөдлийн байнгын хорооны дарга М.Оюунчимэг болон Өргөдлийн байнгын хорооны гишүүд 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Туул голын хамгаалалтын бүсэд олгосон тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан, хууль бусаар үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нөхцөл байдалтай танилцаж, холбогдох арга хэмжээ авч ажиллахаар шийдвэрлэв.

Байнгын хорооны дарга М.Оюунчимэг, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, М.Билэгт нар болон Өргөдлийн байнгын хорооны 2018 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд түрээсийн орон сууц нь зорилтот бүлэгтээ чиглэсэн эсэх, иргэд тухайн байрандаа амьдарч байгаа эсэх, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах асуудлаар 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Буянт-Ухаа II” хороололд ажиллав.

Хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулсан талаар:

Тайлант хугацаанд иргэдийн өргөдлийг судлах хүрээнд Туул голын дагуу аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын талаар холбогдох байгууллагын албан тушаалтнудаас тайлбар, мэдээлэл авах хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Түүнчлэн “Утааны эсрэг ээж, аавууд” төрийн бус байгууллага, иргэдээс “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, татан буугдсан “Цэвэр агаар сан”-гийн зарцуулалтын талаар хэлэлцүүлэх хүсэлт ирүүлсний дагуу Агаарын бохирдлыг бууруулахад зарцуулсан хөрөнгийн талаар холбогдох албан тушаалтнаас тайлбар, мэдээлэл авах хэлэлцүүлэг зохион байгуулав.



Байнгын хорооноос иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу Агаарын бохирдлыг бууруулахад зарцуулсан хөрөнгийн талаар албан тушаалтнуудаас тайлбар авах хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулав. 2018.05.16



Байнгын хорооноос химийн бодисын хуванцар савны хэрэглээ нь нийгмийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, мэдээлэл авах хэлэлцүүлэг зохион байгууллаа. 2018.06.20



Байнгын хорооны дарга М.Оюунчимэг Туул голын хамгаалалтын бүсэд олгосон тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан, хууль бусаар үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нөхцөл байдалтай танилцав. 2018.05.02



Байнгын хороо Туул голын дагуу аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага, холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, мэдээлэл авах хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 2018.04.10




Байнгын хорооны дарга М.Оюунчимэг, УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалан, М.Билэгт нар “Түрээсийн орон сууцанд зорилтот бүлгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах журам”-ын хүрээнд “Баянт-Ухаа II” хороололд ажиллалаа. 2018.05.09

ГУРАВ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ
ҮЙЛ АЖИЛААГАА

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах ажлын талаар



Улсын Их Хурлын даргын захирамжаар

Улсын Их Хурал болон Байнгын хороо, дэд хорооноос агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр өгсөн тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг дүгнэх, шаардлагатай тохиолдолд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж, санал, дүгнэлт гарган Засгийн газарт чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсгээс Засгийн газарт зөвлөмж хүргүүлж, Улсын Их Хурлын 02 дугаар тогтоолоор өгсөн үүрэг, чиглэлийн дагуу хийсэн ажлын талаарх мэдээллийг сонсож, цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, тулгарч буй асуудлын талаар мэдээлэл солилцож, үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг шалгаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж, тус Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу ХНХЯ-нд очиж нийгмийн даатгалын бодлогын баримт бичгийн хэрэгжилттэй танилцлаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан Ажлын хэсгийн удирдамж, төлөвлөгөөний төслийг шинэчлэн боловсруулж ажиллаж байна.

Аюулгүй байдал гадаад бодлого, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хамтарсан

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан таван жилийг нэмэгдүүлэн долоон жил болгосон нь тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээнд өөрчлөлт оруулах эсэх, даатгуулагчийн эрх ашгийг хэрхэн хөндөж байгаа талаар санал, дүгнэлт шийдвэрийн төсөл боловсруулж, Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Хууль зүйн байнгын хороо

Архидан согтуурахтай тэмцэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан байгуулагдаж, хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, Ажлын хэсгийн үйл ажиллагааны талаар хэлэлцэж, БСШУСЯ, БОАЖЯ, Гаалийн ерөнхий газраас Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа гишүүд танилцуулга, мэдээлэл хийлээ. Ажлын хэсгийн гишүүд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагаатай танилцан, ажиллаж байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар

Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлын цар хүрээнээс хамааран төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн эрдэмтэд, судлаачдын төлөөллүүдийг оролцуулсан таван ажлын дэд хэсэг ажиллаж байна. Ажлын хэсгийн болон ажлын дэд хэсгийн гишүүд гэрээний хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд Оюу толгой ХХК-ийн уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, ажлын дэд хэсгүүд санал, дүгнэлтээ боловсруулж, Ажлын хэсэгт танилцууллаа. Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас баталгаа гаргаж, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын “Стандарт” банкнаас авсан зээл, түүнтэй холбоотой олон улсын шүүхийн байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар судалж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг удирдамжийн дагуу ажиллаж, “Эрдэнэт

үйлдвэр” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон ажиллагсдын төлөөлөлтэй уулзан, олон улсын шүүхийн байгууллагаас гаргасан шийдвэртэй холбогдох баримт бичиг, материалыг авч судалсны үндсэн дээр Засгийн газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх удирдлагад Ажлын хэсгийн зөвлөмжийг хүргүүлээ. Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар

Туул голын сав газрын хамгаалалт, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах асуудлыг судалж шаардлагатай бол хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, тус голын эрэг дагуу суурьшсан болон үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцав. Туул голд цутгадаг гол горхины голдирлоор зураг авалт хийж, ахуйн болон бусад хог хаягдлын талаар цаашид авах арга хэмжээ, эрэг дагуу олгогдсон тусгай зөвшөөрөл, үүнтэй холбогдуулан татвар хураамж, түүний зарцуулалт зэрэг асуудлын талаар холбогдох судалгааг хийж, санал, дүгнэлт боловсруулж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай саналаа Засгийн газарт хүргүүлсэн байна.

3.2. Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулга, асуултын талаар

Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад хандан давхардсан тоогоор Улсын Их Хурлын 30 гишүүн 91 асуудлаар 19 удаагийн асуулга, Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан “Ам.долларын ханшийн өсөлтийн шалтгаан нөхцөл, цаашид өсөлтийг тогтвортой байлгах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” 1 асуулт тавьсан байна.



Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан “Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, томоохон ажлууд болон тэдгээрийн үр дүнгийн талаар” Боловсрол,

соёл, шинжлэх ухаан, спортын сайдад, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан “Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлын барилгын ажлын явц, тус нисэх буудлыг ашиглалтад оруулахад хөрөнгө оруулалт, боловсон хүчний нөөц болон бусад асуудлаар Засгийн газраас баримталж буй бодлогын талаар” Ерөнхий сайдад, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Л.Энх-Амгалан нар “Төрөөс мал аж ахуйн салбарт баримтлах бодлогын талаар” Ерөнхий сайдад, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг “Арилжааны банкнаас олгож байгаа зээлийн хүүгийн хэмжээг бууруулах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар” Ерөнхий сайдад, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан “Арьс ширний үйлдвэрүүдийг дэмжих, технологийн шинэчлэл хийх, дэд бүтцийг байгуулах, нүүлгэн шилжүүлэх зэрэг асуудлаар Улсын Их Хурлаас батлагдсан тогтоолын биелэлт, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хэтийн төлөвлөлт, хөгжлийн чиглэлээр баримталж буй бодлогын талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг “Хүүхдийн хүчирхийллийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, Засгийн газраас энэ талаар хийгдсэн судалгаа, хэрэгжүүлж байгаа ажлын талаар” Хууль зүй, дотоод хэргийн сайдад тавьсан гээд нийт зургаан асуулгын хариуг тус тус сонсож, асуулга тавьсан гишүүд үг хэлсэн.

Нэгдсэн хуралдаанд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 52 гишүүн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу 156 асуулт асууж, хариулт авч, санал хэлсэн байна.

/Дэлгэрэнгүйг “Мэдээ-1” хүснэгтээс үзнэ үү/

3.3. Монгол Улсын Ерөнхий сайдын нэгдсэн хуралдаанд хийсэн мэдээллийн талаар

Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ-Бүх нийтийн хамралт”, “Монгол Улсын усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”, “Хөрс хамгаалах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар” зэрэг эрүүл мэнд, байгаль орчны төлөв байдал болон олон нийтийн анхаарал татсан асуудлаар нийт гурван удаа мэдээлэл хийж, мэдээллийн үеэр давхардсан тоогоор Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн 11 гишүүн 55 асуулт асууж, хариулт авсан байна.



/Дэлгэрэнгүйг "Мэдээ-2" хүснэгтээс үзнэ үү/

Ээлжит чуулганы хугацаанд Байнгын болон Дэд хорооны хуралдаанаар Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад байгууллагын 20 удаагийн мэдээлэл, тайланг хэлэлцсэн бөгөөд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 132 гишүүн 278 асуулт асууж, хариулт авч, санал хэлсэн байна.

/Дэлгэрэнгүйг "Мэдээ-3" хүснэгтээс үзнэ үү/

Мэдээ-1

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС 2018 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ТАВЬСАН АСУУЛГЫН ТАЛААРХ МЭДЭЭ

№	Улсын Их Хурлын гишүүний нэр	Хэнд, ямар байгууллагад хандаж тавьсан	Асуулгын агуулга	Хамрагдсан асуудлын тоо		Албан бичгийн огноо			Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан			Тайлбар
				Хүрсэн	Хариу ирүүлсэн	Хугацаа хэтэрсэн эсэх	Асуулгын хариуг №4726 2018.04.26	сонсох гишүүний санал 2018.05.11	Нэгдсэн хуралдаанд сонссон огноо	Асуулт тавьсан гишүүний тоо, асуулт		
1.	С.Бямбацогт Л.Энх-Амгалан	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Төрөөс мал аж ахуйн салбарын талаар баримтлах бодлого, зорилт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар	5	5	2018.03.06 №14	2018.04.04 ХЭГ/666	-	2018.04.26 №4726	2018.05.11	10/34	Сонссон
2.	С.Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	60 тэрбум төгрөгтэй холбоотой хийгдсэн аудио бичлэг эвлүүлэг мөн эсэх талаар болон уг асуудлаар Засгийн газрын байр суурь, цаашид авах арга хэмжээний талаар	5	5	2018.03.13 №15	2018.04.17 ХЭГ/756	4	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй
3.	Ё.Баатарбилэг	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас олгож буй 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжих "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн талаар	10	10	2018.03.14 №16	2018.04.17 ХЭГ/Н-22	3	-	-	-	Нууцын журмаар хариу ирсэн

4.	Ч.Улаан Д.Тэрбишдагва Б.Бат-Эрдэнэ	Монгол Улсын ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар	Оюу Толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ болон хувь нийлүүлэгчдийн гэрээний хэрэгжилтийн талаар Засгийн газрын албан ёсны байр суурь болон цаашид авах арга хэмжээний талаар	5	2018.04.03	№20	2018.05.11	ХЭТ/1011	5	2018.05.14	№5638	2018.06.15	7/18	Сонсох хүсэлт ирүүлээгүй
5.	Ч.Улаан Д.Тэрбишдагва Б.Бат-Эрдэнэ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар	Оюу Толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ болон хувь нийлүүлэгчдийн гэрээний хэрэгжилтийн талаар Засгийн газрын албан ёсны байр суурь болон цаашид авах арга хэмжээний талаар	5	2018.04.03	№17	2018.05.02	№01/1184	-	-	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй
6.	Я.Санжмятав	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Малын зүй бус хорогдлоос урьдчилан сэргийлэх, малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх чиглэлээр болон хаврын тариалалт эхэлж байгаатай холбогдуулан Засгийн газраас авах арга хэмжээний талаар	4	2018.04.03	№19	2018.05.03	ХЭТ/947	-	-	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй
7.	М.Оюунчимэг	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Зэвгийн хүгү бууруулах асуудлын хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар	5	2018.04.03	№20	2018.05.11	ХЭТ/1011	5	2018.05.14	№5638	2018.06.15	7/18	Сонссон

8.	М.Оюунчимэг	Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж	Хүүхдийн хүчирхийллийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, Засгийн газраас энэ талаар хийгдсэн судалгаа, хэрэгжүүлж байгаа ажлын талаар	4	2018.04.16 №21	2018.06.11 ХЭГ/1396	2018.06.18 2	-	2018.06.27 №7856	2018.06.29	12/29	Сонссон
9.	С.Бямбацогт Ж.Батзандан	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Эрүүл мэнд, боловсролын салбар, цагдаагийн байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар	5	2018.05.16 №22	2018.06.18 ХЭГ/1396	2	-	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй
10.	Л.Мөнхбаатар	Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ	Усан замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн явц, цаашид хэрэгжүүлэх ажил, баримталж буй бодлогын талаар	9	2018.05.16 №23	2018.06.06 №01/2646	-	-	2018.06.14 №7075	-	-	Хүлээгдэж байна
11.	С.Бямбацогт Ж.Энхбаяр	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилт болон Засгийн газрын баримталж буй бодлогын талаар	4	2018.05.21 №24	2018.06.25 1/1982	4	-	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй
12.	Х.Болорчулуун	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа	Төрөөс дээд боловсролын талаар баримтлах бодлого, багш, сургалтын орчны талаар болон төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлийн талаар	4	2018.05.23 №25	2018.06.21 1а/7047	-	-	2018.06.26 №7714	-	-	Хүлээгдэж байна

13.	Ж.Ганбаатар Ш.Раднаасэд	Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ	Төрөөс иргэний нисэхийн салбарт баримталж буй бодлого, агаарын тээврийн үнэ тариф, цаашид авах арга хэмжээний талаар	7	2018.05.29 №27	Хариу ирүүлэх хугацаа болоогүй
14.	Б.Бат-Эрдэнэ Ч.Улаан	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Цөлжилтийг хязгаарлах, бэлчээрийн гарц муу байгаа зэрэг өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, холбогдох хуулийн хэрэгжилтийн талаар	5	2018.06.08 №28	Хариу ирүүлэх хугацаа болоогүй
15.	Ж.Батзандан	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Эрүүл мэндийн болон Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийн алдагдал, удирдлагын талаар	2	2018.06.14 №29	Хариу ирүүлэх хугацаа болоогүй
16.	3.Нарантуяа	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Хөгжлийн бодлого, телевэлтийн тухай хуулийн хэрэгжилт, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн байдалд хийгдэх хяналт шинжилгээ, үнэлгээний талаар	3	2018.06.20 №30	Хариу ирүүлэх хугацаа болоогүй
17.	3.Нарантуяа	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Үндэсний үйлдвэрлэл, томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал, үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар	5	2018.06.20 №31	Хариу ирүүлэх хугацаа болоогүй

18.	М.Билэгт Д.Ганболд Л.Энх-Амгалан	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, эмнэлгийн ачааллыг бууруулах боломжийг бүрдүүлэх чиглэлээр Засгийн газраас авч буй арга хэмжээний талаар	3	2018.06.20 №32	Хариу ирүүлэх хугацаа болоогүй
19.	З.Нарантуяа	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн явцын талаар	4	2018.06.26 №34	Хариу ирүүлэх хугацаа болоогүй
			ДҮН-19	91	19	12	18	5	3	29/81			

Мэдээ-2

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД СОНССОН
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ**

№	Сэдэв	Мэдээлэл хийсэн сайд	Мэдээллийг сонссон огноо	Асуулт асууж, санал хэлсэн УИХ-ын гишүүдийн тоо	Нийт асуулт, саналын тоо
1.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ-Бүх нийтийн хамралт	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	2018.04.20	5	28
2.	Монгол Улсын усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	2018.05.04	2	7
3.	Хөрс хамгаалах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	2018.05.18	4	20
	ДҮН - 3			11	55

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Мэдээ-3

**2018 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛАН**

№	Байнгын хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт асууж, санал хэлсэн УИХ-ын гишүүд /тоогоор/	Асуулт, саналын тоо
1.	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2018.04.10	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дэд дарга Д.Дэмбэрэл	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайлан	4	4
2.	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2018.04.10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайлан	8	8
3.	Төсвийн байнгын хороо 2018.04.17	Үндэсний аудитын газрын дарга Д.Хүрэлбаатар	Төрийн аудитын байгууллагын 2017 оны үйл ажиллагааны тайлан	12	15
4.	Эдийн засгийн байнгын хороо 2018.04.18	Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа	Үндэсний статистикийн хорооны 2017 оны үйл ажиллагааны тайлан	7	10
5.	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо 2018.04.24	Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа	“Тогтвортой хөгжлийн зорилтуудын талаарх мэдээллийн мониторинг”	2	2

6.	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо 2018.04.24	Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан	“Засгийн газрын гурван тулгуурт бодлого ба үндэсний хөгжлийн үзэл баримтлал-30, НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудын уялдаа”	3	3
7.	Өргөдлийн байнгын хороо 2018.04.25	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар	Өргөдлийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	6	12
8.	Төрийн байгуулалтын байнгын хороо 2018.05.01	Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо	Төрийн албаны зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайлан	4	21
9.	Эдийн засгийн байнгын хороо 2018.05.02	Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн	Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны үйл ажиллагааны тайлан	11	17
10.	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2018.05.02	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат	Богдхан уулын дархан цаазат газарт хамаарах Туул голын эрэг дагуу аялал жуулчлал эрхлэх зориулалтаар эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл	6	41
11.	Төрийн байгуулалтын байнгын хороо 2018.05.09	Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2017 оны үйл ажиллагааны тайлан	3	6
12.	Эдийн засгийн байнгын хороо 2018.05.09	Монгол Улсын шадар сайд Ө.Энхтүвшин	“Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2016 оны 34 дүгээр тогтоолын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дүнгийн талаарх мэдээлэл	4	10

13.	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2018.05.16	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг	Монгол Улсын Их Хурлын 2017 оны 81, 82 дугаар тогтоолын биелэлтийн талаарх мэдээлэл	3	11
14.	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2018.05.16	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг	Мах, сүүний анхдугаар аяны хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх мэдээлэл	3	9
15.	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2018.05.16	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат	Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийн солбицол, Ойн сан бүхий газрын хилийн заагийн солбицол, Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн солбицлын талаарх мэдээлэл	4	12
16.	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2018.05.30	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат	Улсын Их Хурлын “Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2018 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайлан, УИХ-ын даргын 2017 оны 212 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргаас хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээлэл	16	39

17.	Эдийн засгийн байнгын хороо 2018.06.05	Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанкнаас 2017 онд зохион байгуулсан ажлын талаарх мэдээлэл	15	27
18.	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2018.06.26	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд Г.Ганбаяр, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл	Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 2018 оны хөрөнгө оруулалтын явц, гүйцэтгэлийн тухай мэдээлэл	4	5
19.	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2018.06.26	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл	Байнгын хорооны 2018.05.22-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр хүргэгдсэн эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн зарцуулалтыг шалгасан Ажлын хэсгийн тайлангийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл	9	13
20.	Өргөдлийн байнгын хороо 2018.06.27	Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын дарга Ч.Батсансар	Туул голын эргийн дагуу Баянзүрхийн гүүрнээс Яармагийн гүүр хүртэлх газар ашиглах, барилга барих эрхийн зөвшөөрөл олгосон асуудлаарх мэдээлэл	8	13
	ДҮН-20			132	278

ДӨРӨВ

ҮЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛААГАА

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Мэдээлэл, сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаа

Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хууль тогтоох үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд бодитой, шуурхай, дэлгэрэнгүй мэдээлэл хүргэхийг зорьж дараах ажлыг хийж хэрэгжүүлээ.

Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны тойм, Улсын Их Хурлын дарга, гишүүд, Байнгын хороод, Тамгын газраас зохион байгуулсан хэвлэлийн бага хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны талаар нийт 254 текст мэдээ бэлтгэн 1091 гэрэл зургийн хамт parliament.mn цахим хуудсанд байршуулж, иргэдэд шуурхай түгээв. Түүнчлэн энэ хугацаанд Улсын Их Хурлын даргын айлчлал болон Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх 14 мэдээ, мэдээллийг англи хэл рүү хөрвүүлж, 13 фото нийтлэл бэлтгэж нийтэд хүргэлээ.

БЭЛТГЭСЭН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ



Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын долоо хоног тутмын үйл ажиллагааг тоймлон хүргэдэг “УИХ-Энэ долоо хоногт” нэвтрүүлгийн 14 дугаар, Улсын Их Хурлаар хэлэлцэж буй хууль тогтоомжийн төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл, хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагаа болон цаг үеийн асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн байр суурийг олон нийтэд

хүргэдэг “Улсын Их Хурлын гишүүнтэй ярилцах цаг” нэвтрүүлгийн зургаан дугаар, Улсын Их Хурлын нэгдсэн чуулган, Байнгын хороодын хуралдаан, хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын гишүүдийн байр суурийг товч бөгөөд тэнцвэртэй байдлаар хүргэдэг “Парламентын тэмдэглэл” цуврал контент 11 дугаар, Улсын Их Хурлын дарга М.Энхболд тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын Москва хотноо болсон “Парламентаризмын хөгжил” олон улсын чуулганд оролцсон тухай “Томилолт” нэвтрүүлэг, “Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд Парламентын гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт Ази, Номхон далайн бүсийн орнуудын парламентчдын ээлжит зөвлөгөөний тухай тусгай нэвтрүүлгийг тус тус бэлтгэж, өргөн нэвтрүүлгийн есөн телевизийн 10 сувгаар хуваарийн дагуу олон нийтэд түгээж ажиллав. Түүнчлэн дээрх нэвтрүүлгүүдийг [youtube.com](https://www.youtube.com) болон [facebook.com](https://www.facebook.com) цахим хуудсуудад байршуулж нийтэд хүргэлээ.

Түүнчлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүд, Улсын Их Хурлын дарга болон гишүүдийн уулзалт, Байнгын хороодоос зохион байгуулсан хэлэлцүүлэг, семинар, нээлттэй сонсгол болон тэмдэглэлт үйл явдал, Тамгын газрын үйл ажиллагааны талаар 104 дүрст мэдээ бэлтгэж [parliament.mn](https://www.parliament.mn) цахим хуудаст байршуулсны зэрэгцээ [twitter.com](https://www.twitter.com), [facebook.com](https://www.facebook.com) сүлжээгээр олон нийтэд түгээв.

Улсын Их Хурлын Байнгын болон дэд хороод, Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан нээлттэй сонсгол, хэлэлцүүлэг, уулзалт, семинар, хэвлэлийн хуралд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг өргөнөөр оролцуулах ажлыг тухай бүрт нь зохион байгуулж ажиллав. Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлагуудаас хийсэн 21 удаагийн хэвлэлийн хурлыг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээллийг хүргэж, олон нийтэд түгээх ажлыг гүйцэтгэв.

Ээлжит чуулганы хугацаанд “Төрийн мэдээлэл” хууль тогтоомжийн эмхэтгэлийн 12 дугаарыг бэлтгэн хэвлүүлж нийт захиалагчдад 28500 гаруй эмхэтгэлийг шуудангийн компаниудаар дамжуулан хүргүүлээ. Хаврын ээлжит чуулганы хугацаанд 27 хууль, Улсын Их Хурлын 28 тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 14 зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 13 тогтоол, Үндсэн хуулийн цэцийн зургаан дүгнэлт, олон улсын хоёр гэрээг нийтэлжээ.

Олон нийтийн сүлжээн дэх Монгол Улсын Их Хурлын албан ёсны хуудсуудаар хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг текст, фото, видео хэлбэрээр бэлтгэж, олон нийтэд хүргэлээ. Өнөөдрийн байдлаар [facebook.com](https://www.facebook.com) цахим сүлжээн дэх Монгол Улсын Их

Хурлын албан ёсны цахим хуудсаар мэдээлэл хүлээн авах хэрэглэгчийн тоо 26527 байгаа бол twitter.com сүлжээгээр мэдээлэл хүлээн авах хэрэглэгчийн тоо 26100 болж нэмэгдсэн байна. Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд facebook.com, twitter.com олон нийтийн сүлжээн дэх албан ёсны хуудсаар нийт 578 мэдээ, мэдээллийг түгээгээд байна.



Parliament.mn хуудасны like-ийн тоо **26400**

Twitter дагагчийн тоо **26100**

www.parliament.mn хандалтын тоо **26527**

Олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүрээнд Улсын Их Хурлын гишүүд болон иргэд, байгууллагаас ирүүлсэн 482 хүсэлтийн дагуу гадаад, дотоодын 14173 зочныг Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгуулав.

4.2. Улсын Их Хуралд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт

2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүд Байнгын хороодод ирсэн өргөдөл, санал, хүсэлт, гомдлын тоог доорх зургаас харна уу.



Энэ хугацаанд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо хамтран 695 өргөдөл, хүсэлт буюу 56.6 хувийг бүрэн шийдвэрлэж, 538 буюу 43.4 хувь нь судалж, шийдвэрлэх шатандаа байна.

Иргэдээс энэ хугацаанд 1233 өргөдөл ирүүлснээс 832 буюу 67,5 хувь нь нийслэлийн иргэдээс, 401 буюу 32,5 хувь нь хөдөө орон нутгийн иргэдээс тус тус ирүүлжээ.

Иргэдийг хүлээн авах байраар нийт 403 иргэнийг хүлээн авч уулзаж, санал, хүсэлтийг авснаас Улсын Их Хурлын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хэлэлцэж буй хууль тогтоомжийн төслүүдтэй холбогдсон болон нийтэд тулгарч буй асуудлын талаар 20 хүн саналаа илэрхийлж, 383 хүний тавьсан хувийн хүсэлтийг Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслахуудтай нь холбогдож, танилцуулан, зөвлөгөө өгөх, өргөдөл, гомдлын хариуг нь лавлах, шаардлагатай албан тушаалтантай нь холбогдож хариуг өгүүлэх зэргээр ажилласан.

4.3. Мэдээллийн технологи, техник ашиглалтын мэдээ

Хуралдааны цахим системийн үйлчилгээ

Программ хангамж

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хороодын хуралдааны цахим системийг ашиглан Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд 27 удаагийн нийт 133 орчим цагийн нэгдсэн хуралдаанд 469 удаа санал хураалт явуулж, 428 удаа гишүүдийн болон ажлын хэсгийн микрофоныг нээж, үг хэлэх, асуулт асуух, асуултад хариулах боломжийг олгосон.



Байнгын болон дэд, түр хороодын 101 удаагийн нийт 108 орчим цагийн хуралдаанд 547 удаа санал хураалт явуулж, 379 удаа микрофон нээж ажиллуулсан.

Хуралдааны дүрсний систем

Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд 27 удаагийн нэгдсэн хуралдаан, 101 удаагийн Байнгын болон дэд, түр хороодын хуралдаан, 52 удаагийн Улсын Их Хурал дахь намын бүлгийн мэдээлэл, Ажлын хэсэг, сургалт семинар, мэдээллийн цаг, уулзалтын дүрс бичлэгийг хийсэн байна. Мөн хуралдааны бүх дүрс бичлэгүүдийг хөрвүүлэн компьютерийн дотоод сүлжээний сервер компьютерт байршуулан хэрэглэгчид ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаануудыг Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн 2 дугаар суваг, Сансар, Юнивишн, Скаймедиа кабелийн телевизүүд, Төрийн ордны теле сүлжээ болон www.parliament.mn цахим хуудсаар шууд дамжуулж, Байнгын хороодын хуралдааныг Скаймедиа IPTV-ийн дотоод сувгаар дамжуулан дотоод сүлжээний 146 хэрэглэгчдэд шууд дамжууллаа.

Хуралдааны дууны систем

Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд 27 удаагийн нэгдсэн хуралдаан, 101 удаагийн Байнгын болон дэд, түр хороодын хуралдаан, 191 удаагийн ажлын хэсэг, мэдээллийн цаг, сургалт семинар, уулзалтын дууны бичлэгийг хийсэн. Мөн хуралдааны дууны бичлэгүүдийг компьютерийн дотоод сүлжээний сервер компьютерт байрлуулан хуралдааны тэмдэглэл хөтлөгчид болон эрх бүхий бусад хэрэглэгчид ашиглах боломжийг бүрдүүлэв.

Программ хангамжийн үйлчилгээ

Хөдөлгөөнт оффисийн MyParliament системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж хууль тогтоогчдыг хэрэгцээт мэдээ, мэдээллээр шуурхай хангаж байна. Уг системд дараах мэдээ, мэдээллүүд шинээр нэмэгдэн орсон. Үүнд:

- Системийн хандалт - 360;
- Үйл ажиллагаа - 1048;

- Хуулийн төсөл - 258;
- Хуулийн төслийн дагалдах файлууд - 582;
- Үйл явдал, хуралдаан - 280.

Хэрэглэгчдийн компьютер, зөөврийн компьютерийн хэрэглээний хангамж /үйлдлийн систем, стандарт хэрэглээний программ/-ийн засвар үйлчилгээг 63 удаа гүйцэтгэж, хэрэглээний программын талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажилласан.

4.4. Судалгаа шинжилгээ, мэдээлэл, лавлагаа

Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст Улсын Их Хурлын гишүүдийн санаачлан боловсруулж буй хуулийн төсөл болон Улсын Их Хурлаар хэлэлцэн баталж буй хууль, тогтоолын төсөлтэй холбоотой нийт 14 судалгааны захиалгыг Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын Байнгын хороод зэрэг нэр бүхий есөн захиалагчаас ирүүлсэн болно.


Судалгааны ангилал /төрлөөр/



Судалгааны ангилал /захиалагчаар/



Нийт бүтээгдэхүүн: 17



Эдгээр судалгааны ажлуудыг Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудын албан хэрэгцээнд зориулан Улсын Их Хурлын intra.parliament.mn дотоод сүлжээ, хөдөлгөөнт оффисын сүлжээний MYParliament цэсэнд цахим хэлбэрээр, Улсын Их Хурлын Номын санд цахим болон хэвлэмэл хэлбэрээр байршуулж байна. Мөн Улсын Их Хурлын www.parliament.mn цахим хуудсанд судалгааны ажлын жагсаалт болон судалгааны агуулгын тоймыг байршуулж байна.

Улсын Их Хурлын гишүүдийн хууль хэлэлцэн батлах үйл ажиллагаанд мэдээллийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018 оны Улсын Их Хурлын хаврын

ээлжит чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудад холбогдол бүхий гадаад, дотоодын бусад судалгааны байгууллага, судлаачдын гаргасан судалгаа, шинжилгээний материал, өдөр тутмын хэвлэлийн нийтлэл, статистик тоо баримт зэрэг 133 нэгж мэдээлэл, материалыг цуглуулан, хэлэлцэх асуудал тус бүрээр ангилж, Улсын Их Хурлын дотоод сүлжээнд байршуулсан.

Мөн тус албанаас эрхлэн “Судалгааны эмхэтгэл”-ийн 26 дугаар боть, “Судалгааны мэдээллийн сангийн лавлагаа”-ны 20 дугаар цуврал, “Монгол Улсын Их Хурлын 2017 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга” зэрэг ном, товхимол гаргаж Улсын Их Хурал, Тамгын газар, олон нийтийн хэрэгцээнд хүргүүлээ.

4.5. Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы үеэр Улсын Их Хурал, Монголын парламентын бүлгэмийн шугамаар дараах гадаад арга хэмжээ, айлчлалууд хэрэгжлээ.

Дотоодод:

2018.04.11-14

Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын Ардын Хурлын дарга Доржиев Цырен-Даши тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчилж, Улсын Их Хурлын дарга М.Энхболдод бараалхаж, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Буриадын парламентын бүлгийн дарга Н.Оюундарь болон бүлгийн гишүүдтэй уулзан, Монгол, Оросын Холбооны Улсын хил орчмын бүс нутаг, түүний дотор Буриад Улстай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцож, хил орчмын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх боломжуудын талаар ярилцсан.

2018.04.29-05.01

Улсын Их Хурлын дарга М.Энхболдын урилгаар Ирланд Улсын Парламентын Доод танхимын дарга Шон О’Фарел тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Ирланд Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд Оуэн О’Лири, Парламентын даргын хувийн нарийн бичгийн дарга Браян Прунти, Ирланд Улсын Элчин сайдын яамны Улс төрийн хэлтсийн дарга Шэйн Раян болон албаны бусад хүмүүс дагалдан ирэв.

Монголын парламентын бүлгэм:

2018.05.21-26

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Польшийн парламентын бүлгийн дарга Д.Дамба-Очирын урилгаар Бүгд Найрамдах Польш Улсын парламентын Сеймийн гишүүн, Сейм дэх Польш-Монголын парламентын бүлгийн дарга Марек Жонса тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад ажлын айлчлал хийлээ.

Айлчлалын үеэр төлөөлөгчид Улсын Их Хурлын дарга М.Энхболдод бараалхаж, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Польшийн парламентын бүлгийн дарга Д.Дамба-Очир тэргүүтэй бүлгийн гишүүдтэй уулзаж, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх, хууль тогтоох байгууллагуудын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон.

2018.06.13-15

Улсын Их Хурлын дарга М.Энхболдын урилгаар Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Ардын Дээд Хурлын депутат, Ардын Дээд Хурал дахь Солонгос-Монголын парламентын бүлгийн дарга, Дээд боловсролын сайд, Ким Ир Сеней нэрэмжит их сургуулийн захирал Тэ Хён Чөл тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад ажлын айлчлал хийлээ.

Айлчлалын үеэр төлөөлөгчид Улсын Их Хурлын дарга М.Энхболдод бараалхаж, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-БНАСАУ-ын парламентын бүлгийн дарга О.Баасанхүү болон бүлгийн гишүүдтэй уулзаж, хоёр улсын уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх асуудлаар дэлгэрэнгүй санал солилцлоо.

Гадаадад:

2018 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хурлын гишүүд давхардсан тоогоор нийт 67 удаа гадаад улсад албан болон хувийн ажлаар явсан байна. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ж.Батзандан, Г.Тэмүүлэн нар Оросын Холбооны Улсын Москва хотноо 2018 оны 06 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд зохиогдсон “Парламентаризмын хөгжил” олон улсын чуулга уулзалтад, Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурал дахь Монгол-Японы парламентын бүлгийн дэд дарга

Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн М.Билэгт, Б.Ундармаа, Д.Ганболд нар 2018 оны 06 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Япон улсад тус тус айлчилсан байна. Мөн Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг 2018 оны 04 дүгээр сарын 04-07-ны өдрүүдэд болсон “Энэтхэг-Номхон далайн бүс нутагт баримтлах Америкийн Нэгдсэн Улсын стратеги” сэдэвт дээд албан тушаалтнуудын олон улсын семинарт, Улсын Их Хурлын дэд дарга Я.Санжмятав, Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Монгол-Хятадын парламентын бүлгийн дэд дарга С.Бямбацогт, Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, О.Баасанхүү, Д.Тэрбишдагва, Д.Оюунхорол, Л.Оюун-Эрдэнэ, Я.Содбаатар, Б.Энх-Амгалан нар 2018 оны 04 дүгээр сарын 08-12-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Бүгд Найрамдах Чех Улсад зохион байгуулагдсан Монгол, Чехийн Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд тус тус оролцсон.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Л.Мөнхбаатар, Н.Оюундарь, Б.Энх-Амгалан нар 2018 оны 04 дүгээр сарын 12-17-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад, Улсын Их Хурлын дэд дарга Я.Санжмятав, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Жавхлан, Я.Содбаатар, Л.Элдэв-Очир, Ж.Энхбаяр нар Бүгд Найрамдах Франц Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 2018 оны 04 дүгээр сарын 22-30-ны өдрүүдэд Хадгаламжийн даатгалын тухай хуулийг судалж, туршлага судлахаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Б.Жавхлан, Г.Солтан, Л.Элдэв-Очир нар 2018 оны 05 дугаар сарын 05-10-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана хотноо зохиогдсон “Үндэсний бүтээгдэхүүн” олон улсын үзэсгэлэнд оролцохоор, Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очир Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засаг захиргааны онцгой бүс Хонконгт 2018 оны 05 дугаар сарын 05-14-ний өдрүүдэд зохиогдсон олон улсын хуралд суухаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь 2018 оны 05 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсад ажлын айлчлалаар, Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа 2018 оны 05 дугаар сарын 08-16-ны өдрүүдэд Олон улсын эмэгтэй захирлуудын холбооны чуулганд оролцохоор, Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан 2018 оны 05 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд Анкара хотноо зохиогдсон эрдэм шинжилгээний хуралд, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, А.Сүхбат, Л.Энхболд нар 2018 оны 05 дугаар сарын 19-30-ны өдрүүдэд Колумбын хариуцлагатай уул уурхайн холбооноос Колумб, Эквадор Улсад зохион байгуулсан туршлага судлах уулзалтад тус тус оролцсон.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Б.Баттөмөр, Г.Тэмүүлэн, Ч.Улаан нар 2018 оны 05 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн Төсвийн албаны үйл ажиллагаатай

танилцаж, туршлага судлахаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан 2018 оны 05 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсын Хабаровск хотод ажиллахаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, М.Оюунчимэг, Д.Тогтохсүрэн, Н.Учрал нар 2018 оны 05 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн айлчлалд, Улсын Их Хурлын гишүүн Д.Мурат, Д.Тэрбишдагва нар Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгыг дагалдан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Чиндао хотноо 2018 оны 06 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд зохиогдсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын уулзалтад, Улсын Их Хурлын гишүүн С.Батболд Япон Улсад 2018 оны 06 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд зохиогдсон “Никкей” чуулга уулзалтад, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хянган аймгийн Улаан хотод 2018 оны 06 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд зохиогдсон “Хөрөнгө оруулалт, эдийн засгийн чуулга уулзалт”-д, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил 2018 оны 06 дугаар сарын 21-07 дугаар сарын 01-ний өдрүүдэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Шведийн Вант Улсын төрийн өмчийн тогтолцоо, хяналт, эрх зүйн орчинтой танилцах аялалд, Улсын Их Хурлын гишүүн С.Батболд Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо 2018 оны 06 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд зохиогдсон “Соц-Интерн”-ий зөвлөлийн ээлжит хуралдаанд, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан 2018 оны 06 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Улаанцав хотод зохиогдсон “Гурван улсын эдийн засгийн коридор-Хөрөнгө оруулалтын чуулга уулзалт”-д тус тус оролцсон.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА, ДЭД ДАРГЫН ГАДААД УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛ


Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд Бүгд Найрамдах Турк Улсад
албан ёсны айлчлал хийв (2018.03.08-10)



Айлчлалын үеэр БНТУ-ын Үндэсний Их Хурлын дарга Исмаил Кахрамантай албан ёсны хэлэлцээ хийж, тус улсын Ерөнхийлөгч Режеп Тайип Эрдоандоо бараалхлаа.

Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд ОХУ-ын Москва хотноо дэлхийн 96 орны парламентын төлөөлөгчид оролцсон “Парламентаризмын хөгжил” олон улсын чуулга уулзалтад оролцов (2018.06.03-06)


Тэрбээр энэ үеэр ОХУ-ын Холбооны хурлын Төрийн Думын дарга В.В.Володин, ОХУ-ын Ерөнхийлөгчийн зөвлөх И.Е.Левитин, ОХУ-ын Засгийн газрын Тэргүүний орлогч А.В.Гордеев, ОХУ-ын Холбооны хурлын Холбооны зөвлөлийн орлогч дарга Е.В.Бушмин нартай уулзаж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны өргөн хүрээтэй асуудлаар санал бодлоо солилцов.





УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалангаар ахлуулсан УИХ-ын гишүүн О.Баасанхүү, Л.Болд, Б.Саранчимэг нарын Монгол Улсын парламентын төлөөлөгчид Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо болсон ОУПХ-ны Ассамблейн 138-р чуулганд оролцов.

Энэ үеэр УИХ-ын гишүүн Б.Саранчимэг ОУПХ-ны 4 байнгын хорооны нэг болох Ардчилал, хүний эрхийн байнгын хорооны товчооны гишүүнээр сонгогдсон юм. 2018.04.26-30



УИХ-ын дэд дарга, УИХ дахь Монгол-Японы парламентын бүлгийн дэд дарга Л.Энх-Амгалан тэргүүтэй УИХ-ын гишүүн М.Билэгт, Б.Ундармаа, Д.Ганболд нарын Монголын парламентын төлөөлөгчид Япон Улсад ажлын айлчлал хийв. 2018.06.03-06



УИХ-ын дэд дарга Я.Санжмятав БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Боловсрол, шинжлэх ухаан, соёл, эрүүл мэндийн хорооны орлогч дарга Лю Чжан тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж, хоёр орны харилцаа хамтын ажиллагааны талаар санал солилцов.

2018.06.12



УИХ-ын Тамгын газар, Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль хамтран “Дэлхийн номын өдөр”-т зориулсан номын өдөрлөгийг Төрийн ордонд зохион байгуулав. 2017.04.23



УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлаг хамтран “Парламентын хяналт: хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг Төрийн ордонд зохион байгууллаа. 2018.06.06



“Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд Парламентын гишүүдийн чадавхийг бэхжүүлэх: Насжилт, төрөлт ба залуучуудыг эрх мэдэлжүүлэх нь” сэдэвт Ази, Номхон далайн орнуудын парламентчдын зөвлөгөөнийг УИХ-аас НҮБ-ын Хүн амын сан, Азийн хүн ам, хөгжлийн нийгэмлэг, Олон улсын гэр бүл төлөвлөлтийн холбоотой хамтран зохион байгуулав.

2018.06.12



УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар УИХ-ын Тамгын газрын 2017 оны үйл ажиллагааны тайланг сонсов.

2018.05.09



Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу УИХ-ын Тамгын газраас холбогдох арга хэмжээг шуурхай авч, Төрийн ордны арын цэцэрлэгийг нээлттэй болгов.

2018.06.14

ТАВ

ХАВСРАЛТ

Хавсралт -1
УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНААР БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ

Хавсралт -2
УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНААР БАТАЛСАН ХУУЛЬ, ТОГТООЛЫН
ТАНИЛЦУУЛГА

ТАВ.ХАВСРАЛТ

Хавсралт 1.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР
БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ****2018.06.29****Нэг.Бие даасан хууль**

1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (2018.04.26);
2. Баяжуулсан хүнсний тухай (2018.05.03);
3. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай (2018.05.10);
4. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай (2018.05.10);
5. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (2018.05.10);
6. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (2018.05.10);
7. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай (2018.05.25);
8. Улсын бүртгэлийн ерөнхий хууль (шинэчилсэн найруулга) (2018.06.21);
9. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай (2018.06.21);
10. Иргэний улсын бүртгэлийн тухай (шинэчилсэн найруулга) (2018.06.21);
11. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай (шинэчилсэн найруулга) (2018.06.21);
12. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай (шинэчилсэн найруулга) (2018.06.21);
13. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (2018.06.21);
14. Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (2018.06.21);
15. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай (2018.06.22);
16. Орон нутгийн хамгаалалтын тухай (2018.06.27);
17. Багшийн хөгжлийг дэмжих тухай (2018.06.27).

Хоёр.Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.04.12);

2. Монгол Улсын батлан хамгаалах тухай (шинэчилсэн найруулга) хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.04.19);
3. Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.04.19);
4. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.04.26);
5. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.04.26);
6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.04.26);
7. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.04.26);
8. Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.04.26);
9. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.04.26);
10. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.04.26);
11. Гаалийн тухай хуульд (шинэчилсэн найруулга) нэмэлт оруулах тухай (2018.04.26);
12. Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.04.26);
13. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд (шинэчилсэн найруулга) өөрчлөлт оруулах тухай (2018.04.26);
14. Нотариатын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.04.26);
15. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.04.26);
16. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.05.03);
17. Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.05.10);
18. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.07);
19. Иргэний хуульд нэмэлт оруулах тухай (2018.06.21);
20. Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
21. Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
22. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
23. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
24. Цэргийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
25. Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
26. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
27. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
28. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
29. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);

30. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
31. Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
32. Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
33. Цахим гарын үсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
34. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.06.21);
35. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
36. Санхүүгийн түрээс (лизинг)-ийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
37. Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
38. Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
39. Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
40. Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
41. Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
42. Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
43. Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.21);
44. Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.06.21);
45. Банкны тухай (шинэчилсэн найруулга) хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.22);
46. Зөрчлийн тухай (шинэчилсэн найруулга) хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.22);
47. Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.06.22);
48. Монгол Улсын Батлан хамгаалах тухай (шинэчилсэн найруулга) хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
49. Дайчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.06.27);
50. Зөрчлийн тухай (шинэчилсэн найруулга) хуульд нэмэлт оруулах тухай (2018.06.27);
51. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.06.27);
52. Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
53. Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
54. Монгол Улсын Батлан хамгаалах тухай (шинэчилсэн найруулга) хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
55. Цэргийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
56. Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
57. Зөрчлийн тухай (шинэчилсэн найруулга) хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
58. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);

59. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
60. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
61. Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
62. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.27);
63. Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.06.27);
64. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.06.28);
65. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.29);
66. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.29);
67. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.06.29).

Гурав.Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль

1. Хэлэлцээр соёрхон батлах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай хэлэлцээр”, (2018.04.12);
2. Олон улсын гэрээ соёрхон батлах тухай “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээ”, (2018.05.10).

Дөрөв.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль

1. Улсын бүртгэлийн ерөнхий хууль хүчингүй болсонд тооцох тухай (2018.06.21);
2. Иргэний бүртгэлийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай (2018.06.21);
3. Эд хөрөнгө өмчлөх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай (2018.06.21);
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай (2018.06.21);
5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай (2018.06.21).

Тав.Улсын Их Хурлын тогтоол

1. Бүгд Найрамдах Киргиз Улсад Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай (2018.04.06, дугаар 24);

2. Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай (2018.04.19, дугаар 25);
3. Тогтоолын төсөл буцаах тухай (2018.04.20, дугаар 26);
4. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүдийг томилох тухай (2018.05.03, дугаар 27);
5. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай (2018.05.03, дугаар 28);
6. Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай (2018.05.03, дугаар 29);
7. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (2018.05.03, дугаар 30);
8. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.05.10, дугаар 31)
9. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай (2018.05.24, дугаар 32)
10. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай (2018.05.24, дугаар 33);
11. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай (2018.05.24, дугаар 34);
12. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай (2018.05.24, дугаар 35);
13. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай (2018.05.24, дугаар 36);
14. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” батлах тухай (2018.05.24, дугаар 37);
15. Цахим бодлогын түр хороо байгуулах тухай (2018.05.24, дугаар 38);
16. Хуулийн төсөл буцаах тухай (2018.05.25, дугаар 39);
17. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай (2018.05.30, дугаар 40);
18. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай (2018.05.30, дугаар 41).
19. Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 07 дугаар дүгнэлтийн тухай (2018.06.07, дугаар 42);
20. Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай (2018.06.07, дугаар 43);
21. Тооллогын комисс байгуулах тухай (2018.06.08, дугаар 44);
22. Д.Муратын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай (2018.06.08, дугаар 45);
23. Тооллогын комисс байгуулах тухай (2018.06.08, дугаар 46);
24. Д.Гантулгын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай (2018.06.08, дугаар 47);
25. Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 08 дугаар дүгнэлтийн тухай (2018.06.14, дугаар 48);
26. Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай (2018.06.14, дугаар 49);
27. Хуулийн төсөл буцаах тухай (2018.06.14, дугаар 50);
28. Хуулийн төсөл буцаах тухай (2018.06.15, дугаар 51);
29. Хуулийн төсөл буцаах тухай (2018.06.21, дугаар 52);
30. Хуулийн төсөл буцаах тухай (2018.06.21, дугаар 53);
31. Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай (2018.06.21, дугаар 54);

32. Хуулийн төсөл буцаах тухай (2018.06.21, дугаар 55);
33. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.21, дугаар 56);
34. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.21, дугаар 57);
35. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай (2018.06.21, дугаар 58);
36. Ерөнхийлөгчийн хоригийн тухай (2018.06.22, дугаар 59);
37. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай (2018.06.27, дугаар 60);
38. Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай (2018.06.28, дугаар 61);
39. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай (2018.06.28, дугаар 62)
40. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай (2018.06.28, дугаар 63);
41. Нөхөн болон дахин сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай (2018.06.28, дугаар 64);
42. Түр хорооны даргыг сонгох тухай (2018.06.28, дугаар 65);
43. Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай (2018.06.28, дугаар 66);
44. Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай (2018.06.28, дугаар 67);
45. Хуулийн төсөл буцаах тухай (2018.06.28, дугаар 68);
46. Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай (2018.06.29, дугаар 69);
47. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай (2018.06.29, дугаар 70);
48. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.06.29, дугаар 71);
49. Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай (2018.06.29, дугаар 72);
50. Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай (2018.06.29, дугаар 73).

Хавсралт 2.

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

А) Төрийн байгуулалтын болон хууль зүйн чиглэлээр:


УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2018.06.21	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2018.05.04-ний өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2018.11.01
--	--	--


ХУУЛИЙН ЗОРИЛГО

 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТОГТЛОЦООГ ҮЕ ШАТТАЙ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХ	 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮРГЭН ШУУРХАЙ, ЧИРЭГДЭЛГҮЙ БОЛГОХ	 ХУУЛЬД ЗААСНААС БУСАД ТОХИОЛДОЛД УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙХ	 ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭХ
--	---	---	--

 НЭЭЛТТЭЙ -ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭР, ХАЯГ, ХЭЛБЭР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ -ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН МЭДЭЭЛЭЛ -НЭРИЙН САН -ХАЯГИЙН САН	УЛСЫН БҮРТГЭЛ  - ИРГЭНИЙ БҮРТГЭЛ - ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ - ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ - ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛ
 ХААЛТТАЙ -ИРГЭНИЙ БИЕНИЙН ДАВХЦАХГҮЙ ӨГӨГДӨЛ -ТӨРИЙН НУУЦАД ХАМААРАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН МЭДЭЭЛЭЛ	ТӨРӨЛЖСӨН БҮРТГЭЛ  -ТӨРӨЛЖСӨН БҮРТГЭЛ НЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭНЭ -УГ БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХОЛБОГДОХ ХУУЛИАР ЗОХИЦУУЛНА
 ХЯЗГААРТАЙ -ДЭЭРХ 2 МЭДЭЭЛЛЭЭС БУСАД МЭДЭЭЛЛИЙГ ХУУЛИАР ТОГТООСОН ШААРДЛАГА ХАНГАСАН ЭТГЭЭДЭД, МӨН ТУХАЙН ИРГЭНИЙ ЗӨВШӨӨРЛӨӨР, ЭСХҮЛ ХЯЗГААРТАЙГААР БҮЮУ НОТАРИАТЧААР ДАМЖУУЛАН ИРГЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ӨГНӨ.	ЦАХИМ ҮНЭМЛЭХ  -ИРГЭНИЙ ЦАХИМ ҮНЭМЛЭХИЙН ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛНЭ.



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ
ЦАХИМААР АВАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛСЭН






УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ АНГИЛАН ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВӨӨР ДАМЖУУЛАН ТӨРИЙН БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГУУД АШИГЛАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛСЭН




УЛСЫН БҮРТГЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА



УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО



ХУУЛЬ ХЭРЭГЖСЭНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН




ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2018.06.21	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2016.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2018.11.01
--	---	--


ХУУЛИЙН ЗОРИЛТ

- Иргэний бүртгэлийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй болгох
- Бүртгэлийн ажил үйлчилгээг олон улсын чиг хандлагад нийцүүлэх
- Бүртгэлийн байгууллагын ачаалал, зардлыг бууруулах, ажлын үр дүн нөлөөг нэмэгдүүлэх




1 575 345 Архангай | 1 605 243 Дорнод

НИЙТ 3 180 588



1. Бүртгэлийн хуулбар
2. Бүртгэлийн лавлагаа
3. Эрхийн бүртгэлийн гэрчилгээ
4. Засаг даргын тодорхойлолт
5. Цагдаагийн байгууллагын тодорхойлолт

- Төрсний бүртгэл
- Гэрлэсний бүртгэл
- Гэрлэлт цуцлуулсны бүртгэл
- Эцэг тогтоосны бүртгэл
- Үрчилсний бүртгэл
- Нас барсны бүртгэл
- Иргэний үнэмлэхийн бүртгэл
- Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл
- Гадаадад зорчих эрхийн бүртгэл




10 □ Арьяалал харгалзахгүй бүртгэх үйлчилгээ

4 □ Арьяаллын дагуу бүртгэх үйлчилгээ


- Шилжилт хөдөлгөөн бүртгэл
- Иргэний харьяаллын бүртгэл
- Хүйс өөрчлөгдсөний бүртгэл
- Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчлөгдсөний бүртгэл

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТООГ ЦӨӨЛСӨН

10 ЖИЛ



5 ЖИЛ



01 ТӨРСНИЙ

02 ГЭРЛЭСНИЙ

олгох гэрчилгээнүүд

03 НАС БАРСНЫ

04 ОВОГ ЭЦЭГ/ЭХ/-ИЙН НЭР, НЭР ӨӨРЧИЛСНИЙ

05 ГЭРЛЭЛТ ЦУЦЛАСНЫ

06 ҮРЧИЛСНИЙ

ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД ПАСПОРТ ХУГАЦАА

ИРГЭНИЙ БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ХУГАЦААГ ТОДОРХОЙ БОЛГОЖ ӨГСӨН.

1 ӨДӨР

Төрсний, үрчилсний бүртгэл **30 ХОНОГ** байсан.

5 ӨДӨР

Гэрлэсний бүртгэл **30 ХОНОГ** байсан.

1 ӨДӨР

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл **30 ХОНОГ** байсан.

1 ӨДӨР

Нас барсны бүртгэл хийх хугацаа тодорхойгүй байсан.

7 ӨДӨР

Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл **30 ХОНОГ** байсан.

7 ӨДӨР

Хүйс өөрчлөгдсөний бүртгэл хийх хугацаа тодорхойгүй байсан.

1 ӨДӨР

Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл хийх хугацаа тодорхойгүй байсан.

3 ХОНОГ

Үндэсний гадаад паспортын бүртгэл **3-45 ХОНОГ** байсан.

3 ХОНОГ

Харьяатын бүртгэл хийх хугацаа тодорхойгүй байсан.

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА) БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИУДЫН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2018.06.21	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2016.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2018.11.01
--	---	--

ХУУЛИЙН ЗОРИЛГО

 Бүртгэлийн үнэн зөв, нэгдмэл, бодитой байх нөхцөлийг бүрдүүлэх	 Иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрхийн баталгааг хангах	 Бүртгэлийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах, цахим мэдээллийн санг бүрдүүлэх
---	---	--

БҮРТГЭЛИЙН ЗАРИМ ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ НОТАРИАТААР ДАМЖУУЛАН ХҮЛЭЭН АВАХ




НОТАРИАТЧ

ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙХ
 УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ
 МЭДҮҮЛГИЙН ҮНЭН ЗӨВИЙН БАТАЛГААГ ХАНГАЖ,
 ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВРЫГ ХАРИУЦАХ

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

- Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийн эрхийг **ӨМЧИЙН ХЭЛБЭР** харгалзахгүйгээр бүртгэх
- ТӨРИЙН ӨМЧИЙН ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ**
- Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийн эрхийг **ӨМЧЛӨГЧИЙН ХАРЯАЛАЛ** харгалзахгүйгээр бүртгэх



ГАЗАР, ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙГ ХАМТАД НЬ БҮРТГЭХ



ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ + ГАЗАР = **НЭГ БҮРТГЭЛ НЭГ ГЭРЧИЛГЭЭ**

- УЛСЫН БҮРТГЭГЧИЙГ ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛД ХАМРУУЛНА.
- ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАРУУЛАХ АСУУДЛЫГ ХЗДХЯ ХАРИУЦНА.
- ДААТГАЛЫН ХУРААМЖИЙГ ТӨР ХАРИУЦНА.

Уг хууль 5 бүлэг, 39 зүйлтэй бөгөөд 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зорилтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг улсын бүртгэлд бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлсон бөгөөд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг хуульд шинээр тусгасан болно. Үүнд:

Орон сууц худалдан авахаар захиалга өгсөн иргэдийн өмчлөх эрх нь урьдчилсан тэмдэглэл хийлгэх замаар хамгаалагдах боломж бүрдсэн.




Хуульд заасан зарим төрлийн маргааныг улсын байцаагчийн шийдвэрээр залруулах боломжтой болсон.




Орон сууц болон хэсгээр өмчлөх дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг доорх болон орчны газрын **НЭГЖ ТАЛБАРТ** үндэслэн бүртгэнэ.

Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд тусгах **ҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ** аргыг хуульчилсан.



ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ



2003 онд баталсан Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэдэггүй байсан бол шинэчлэн баталсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар бүртгэлийн үнэн зөв, нэгдмэл, бодитой байх нөхцөлийг бүрдүүлэх, эд хөрөнгийн бүхий л эрхийг улсын нэгдсэн бүртгэлд хамруулж, бүртгэлийн улсын хэмжээний статистик мэдээг үнэн зөв, бодитой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийг өмчийн хэлбэр, өмчлөгчийн иргэний харьяалал харгалзахгүй бүртгэхээр тусгасан.

Мөн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг газрын эрхээс салангид байдлаар бүртгэснээр газар олголтын давхардал, бүртгэлтэй холбоотой маргаан ихээр гардаг байдлыг өөрчилж, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн нэгдмэл байдлыг бүрдүүлэх зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн /барилга, байгууламж/ өмчлөх эрхийг түүний доорх болон орчны нэгж талбарын дугаарт үндэслэн бүртгэх зохицуулалт шинээр орсон.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.06.21

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас

2018.05.04-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

2018.11.01

ХУУЛИЙН ЗОРИЛТ

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ШИНЭЭР БОЛОН ӨӨРЧЛӨН БАЙГУУЛСАН, ТАТАН БУУЛГАСНЫГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ БОЛОН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ, ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ ОЛГОХТОЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛНА.



ХУУЛИЙН ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХЭЛБЭР

ШИНЭЭР ҮҮСГЭН БАЙГУУЛЖ БУЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ХУГАЦАА АЖЛЫН 10 ӨДӨР БАЙСНЫГ СУНГАЖ 30 ХОНОГ БОЛГОСОН.

ТАТАН БУУЛГАЛТЫН БҮРТГЭЛ ХИЙХ ХУГАЦААГ АЖЛЫН 3 ӨДӨР БАЙХААР ТОДОРХОЙ ЗААЖ ӨГСӨН.

1.НӨХӨРЛӨЛ
2.КОМПАНИ

3.ХОЛБОО
(ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА)
4.САН

5.ХОРШОО
6.ШАШНЫ
БАЙГУУЛЛАГА


7.НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН
ХУУЛИЙН ЭТГЭЭД
8.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ГАЗАР

9.УЛСЫН ТӨСӨВТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
10.АЖ АХУЙН ТООЦООТОЙ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

ШИНЭЭР БАЙГУУЛАГДАЖ БУЙ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖИЙГ БҮРТГЭХ ХУГАЦАА АЖЛЫН 10 ӨДӨР БАЙСНЫГ АЖЛЫН 5 ӨДӨР БОЛГОН БОГИНОСГОСОН.

НЭР АВАХ ХҮСЭЛТИЙГ НУТАГ ДЭВСГЭРИЙН ХАРЬАЛАЛ ХАРГАЛЗАХГҮЙ ГАРГАХААР, БИЕЧЛЭН ЭСХҮЛ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ГАРГАЖ БОЛОХООР ХУУЛЬЧИЛСАН.

ХУУЛИЙН ЭТГЭЭД
(2017)



170 752

БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛДЭЭ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУГАЦААГ УЯН ХАТАН ЗОХИЦУУЛСАН.

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРЭЭР БАЙГУУЛАГДСАН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДЫГ БҮРТГЭХЭЭР БОЛСОН.

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.5 дахь заалтад заасны дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар уг хуулийг баталсан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалтад нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авна гэж заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэж үзсэн тул уг заалтыг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй нийцүүлэх үүднээс хүчингүй болгох, мөн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн “67.1.5” дахь заалтыг эшлэснийг хасах өөрчлөлтийг тусгасан болно.

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.06.21

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас

2018.01.31-ний өдөр өргөн мэдүүлсэн


**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

2018.07.01

ХУУЛЬД ШИНЭЭР НЭМЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТУУД

ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ

Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа зохицуулалт нь "үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх"-д нэг адил үйлчлнэ.



ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулж, Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл Засгийн газрын түвшинд ажиллана.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн.



Энэхүү хуулиар терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа зохицуулалт нь "үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх"-д нэг адил үйлчлэх талаар, ингэхдээ терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх асуудалд тагнуулын байгууллага, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудалд Санхүүгийн

мэдээллийн алба хяналт тавихаар, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бий болгох, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл Засгийн газрын түвшинд ажиллах зэрэг асуудлыг хуульд шинээр тусгаж, холбогдох заалтуудыг өөрчлөн найруулж хуульчилсан.

ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ЗОХИЦУУЛАЛТУУД



МОНГОЛБАНКНЫ ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

Санхүүгийн мэдээллийн албаны эрх зүйн байдал, үйл ажиллагааны чадамжийг бэхжүүлэх зорилгоор хуульд тус албаны чиг үүрэг, эрх хэмжээний талаарх зохицуулалтыг өргөжүүлсэн.

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД

Мэдээлэх үүрэгтэй этгээд"-ийн хүрээг ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэн өргөжүүлсэн. Тухайлбал үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, нотариатч, хуульч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нар нь хуулийн хүрээнд мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамаарна.



МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД

Мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавих хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт оруулах нөхцөлийг бүрдүүлж, мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналтын хөтөлбөр болон харилцагчийг таньж мэдэх талаарх зохицуулалтыг боловсронгуй болгосон.



ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ

Эдийн засгийн харилцаанд орж байгаа аливаа хөрөнгийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэн зөв, бодитоор бүртгэх тогтолцоог бий болгох зорилгоор бүртгэлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА****БАТАЛСАН
ОГНОО****2018.05.03****ХУУЛЬ САНААЧИЛСАН**УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан
2018.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн журмаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд Улсын Их Хурлын гишүүнийг гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчилсан болон гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэнтэй холбогдуулан Улсын ерөнхий прокурор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэхээр заасан.

Хууль батлагдсанаар Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хамгаалсан хуулийн зохицуулалт Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг тус тус зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэцээс үзэж, Цэцийн 2017 оны 02 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгосон шийдвэрт нийцсэн болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ...” гэж заасныг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн гэж үзсэн.

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Тахарын албаны тухай хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр хүчингүй болсонд тооцсон. Үүнтэй холбогдуулан хууль санаачлагчаас Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Жолоочийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтаас “тахар” гэсэн нэр томъёог хасахаар хуулийн төсөл боловсруулж батлуулсан.

ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БУСАД ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан бөгөөд уг хуулийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 01 дүгээр тогтоолд Шүүх байгуулах тухай хуулийг нийцүүлэх үүднээс нийслэлийн Багахангай, Налайх дүүргийн дунд ажиллаж байгаа дүүргийн эрүүгийн болон иргэний хэргийн анхан шатны шүүхийг салгаж, Багахангай дүүрэгт тусад нь дүүргийн иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Налайх дүүрэгт мөн дүүргийн иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүх байгуулах зохицуулалтыг тусгасан Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан.

Түүнчлэн Налайх, Багахангай дүүрэгт тус тусад нь дүүргийн анхан шатны шүүх байгуулахтай холбогдон үүсэх шүүгчийн орон тоо, зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудлыг Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолуудаар тус тус шийдвэрлэхээр хуульчилсан.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.06.27

ХУУЛЬ САНААЧИЛСАН

УИХ-ын гишүүн О.Батнасан,
Д.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар нараас
2018.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

2018.07.05

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХУУЛЬД ЗААСАН ХЯЗГААРЛАЛТАД ОРООГҮЙ ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛАХҮЙГЭЭР АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ, ОНОГДУУЛСАН ХОРИХ ЯЛЫГ ХОЙШЛУУЛАХ, ТЭНСЭХ БОЛОМЖИЙГ БИЙ БОЛГОХОД ХУУЛИЙН ЗОРИЛГО ОРШИНО.

ХУУЛЬД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

ХОЙШЛУУЛАХ

АНХ УДАА ХОРИХ ЯЛЫН **ДЭЭД 8** жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛАХААР ЗААГААГҮЙ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН БОЛ ШҮҮХ ШИЙТГЭХ ТОГТООЛЫГ БИЕЛҮҮЛЭХИЙГ ХОЙШЛУУЛЖ БОЛНО.



ТЭНСЭХ

ХОРИХ ЯЛЫН **ДЭЭД 8** жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛАХААР ЗААГААГҮЙ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН БОЛ ОНОГДУУЛСАН ЯЛЫГ ТЭНСЭЖ БОЛНО.



ЯЛ

ХОРИХ ЯЛЫН **ДООД 5** жил, түүнээс дээш хугацаагаар тогтоосон ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН БОЛ ЯЛ ОНОГДУУЛЖ, АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВНА.



ХҮРЭХ ҮР ДҮН

- ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ ДЭЭРДЭХ
- ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙГ ЗААВАЛ ХОРЬЖ НИЙГМЭЭС ТУСГААРЛАЛГҮЙГЭЭР ТЭДНИЙ ХУВИЙН БАЙДЛЫГ ХАРГАЛЗАН ҮЗЭЖ, ТҮҮНД НЬ ТОХИРСОН АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВАХ БОЛОМЖ НЭЭГДЭХ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**
2018.06.29

ХУУЛЬ САНААЧИЛСАН

УИХ-ын гишүүн Д.Хаянхярваа 2018.02.09,
УИХ-ын гишүүн С.Бямбацогт нарын 16
гишүүн 2018.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**
Ердийн журмаар

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ХАРИУЦЛАГАТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



ХУРАЛДААНЫ ИРЦ, САНАЛ ХУРААЛТАД ХУРУУНЫ
ХЭЭГЭЭР ИДЭВХХДЭГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАХ
/2019 оны хаврын чуулганаас эхлэн дагаж мөрдөнө/



НЭГДСЭН ХУРАЛДААН ТАСАЛСАН ӨДРИЙН
ЦАЛИНГ ХАСАХ



ГИШҮҮНИЙ ХУРАЛДААНД ОРОЛЦСОН ИРЦИЙН
МЭДЭЭГ САР БҮР ГАРГАЖ, ОЛОН НИЙТЭД
МЭДЭЭЛЭХ



ХЭЛЭЛЦЭЖ БАЙГАА АСУУДАЛТАЙ ХОЛБОГДОЛГҮЙ
АСУУДЛААР ҮГ ХЭЛБЭЛ САНУУЛЖ, САНУУЛГЫГ
БИЕЛҮҮЛЭХГҮЙ БОЛ ҮГ ХЭЛЭХ ХУГАЦААГ
ДУУСГАВАР БОЛГОХ

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ӨӨРЧЛӨЛТ

Байнгын хорооны
хуралдаанаар холбогдох
байгууллагын мэдээллийг
сонсох дэгийг журамлах

Хуралдааны үеэр авсан
нэмэлт тайлбар хангалтгүй
гэж үзвэл тухайн гишүүний
саналаар 2 хүртэл удаа
тус бүр 1 минутаас илүүгүй
хугацаагаар дахин нэмэлт
асуулт асууж, тайлбар авах
боломжийг бүрдүүлэх

Хуралдаанд оролцож
байгаа албан тушаалтан
үнэн зөв мэдээлэл өгөх
үүргийг зааж, хариуцлагыг
нэмэгдүүлэх

“ЗАРИМ ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас “Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” шийдвэрийг 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр гаргаж Улсын Их Хурлын тогтоол баталсан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8 дахь хэсэгт “Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалагдах Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнд тооцно” гэж заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Батзориг, Дуламсүрэнгийн Оюунхорол нарыг Нутгийн удирдлагын дэд хорооны бүрэлдэхүүнээс, Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Ундармааг Нутгийн удирдлагын болон Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлөхөөр тусгасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтын “Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүнд орох, нэг Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарч өөр Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох” гэсэн гишүүний бүрэн эрхийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Данзангийн Лүндээжанцанг Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэнг Ёс зүйн дэд хорооны, Октябрийн Баасанхүүг Нутгийн удирдлагын дэд хорооны, Намсрайн Амарзаяаг Нутгийн удирдлагын болон Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны гишүүнээр тус тус батлах тухай тогтоолын төсөлд тусгасан болно.

“СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр баталсан.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно” гэж заасны дагуу 2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилсон Ш.Солонго нь мөн

хуулийн 4.6 дахь хэсгийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ хороогоор дамжуулан 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн.

Иймд Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсгийг үндэслэн Шилагарьдын Солонгыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай тогтоолыг Улсын Их Хурал баталсан болно.

**“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**
(Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газар)

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Уг тогтоолоор “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг салгаж, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газар болгон өөрчилсөн.

Оюуны өмчийн байгууллагыг бие даан байгуулснаар Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний оюуны бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх үндсэн эрх бүрэн хангагдах, Монгол Улсын оюуны өмчийн эрхийн хамгаалалтын тогтолцоог сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах нөхцөл сайжирна гэж үзсэн.

**“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**
(Мал эмнэлгийн ерөнхий газар)

Монгол Улсын Их Хурлаас “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” шийдвэрийг 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр гаргаж Улсын Их Хурлын тогтоол баталсан.

Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сард баталсан Мал, амьтны эрүүл мэндийн тухай болон Малын генетикийн нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газрын

нэрийг Мал эмнэлгийн ерөнхий газар болгон өөрчлөхөөр төсөлд тусгаж, мал эмнэлгийн чиглэлийн үйл ажиллагааг Мал эмнэлгийн ерөнхий газар, харин малын үржил, бүртгэлийн үйл ажиллагааг Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бүтцийн нэгж зохион байгуулахаар төлөвлөжээ.

Иймд “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “18.Мал эмнэлэг, үржлийн газар” гэснийг “18.Мал эмнэлгийн ерөнхий газар” гэж өөрчлөхөөр тогтоолд тусгасан.

Улсын Их Хурлын тогтоол батлагдсанаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай болон Малын генетикийн нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөл бий болж, мал эмнэлгийн нэгдсэн шуурхай, удирдлагын босоо тогтолцоо бий болж, харин мал үржлийн албаны чиг үүргийг бодлогын түвшинд зохицуулах боломж бүрдэж байна.

“Д.МУРАТЫН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙГ НЬ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ЭСЭХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас “Д.Муратын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай” шийдвэрийг 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр гаргаж Улсын Их Хурлын тогтоол баталсан.

Монгол Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд хандаж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.2 дахь заалтад заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Д.Муратын бүрэн эрхийг түдгэлзүүлэх санал ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо, Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо тус Улсын ерөнхий прокурорын саналыг хэлэлцээд санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулсан бөгөөд санал хураалтыг нууцаар, саналын хуудсаар явуулж, гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх санал дэмжигдээгүй тул “Д.Муратын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлан гаргасан болно.

**“Д.ГАНТУЛГЫН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙГ НЬ
ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ЭСЭХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлаас “Д.Гантулгын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай” шийдвэрийг 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр гаргаж Улсын Их Хурлын тогтоол баталсан.

Монгол Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд хандаж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.2 дахь заалтад заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Д.Гантулгын бүрэн эрхийг түдгэлзүүлэх санал ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо, Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо тус Улсын ерөнхий прокурорын саналыг хэлэлцээд санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулсан бөгөөд санал хураалтыг нууцаар, саналын хуудсаар явуулж, гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх санал дэмжигдээгүй тул “Д.Гантулгын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлан гаргасан болно.

**“УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлаас “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдөр баталсан.

Улсын Их Хурлын гишүүн Дорждугарын Гантулгаас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3-д заасныг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хуралд 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдөр ирүүлсэн.

Уг хүсэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн Д.Гантулгыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталсан болно.

**“ХУУЛИЙН ТӨСӨЛ БУЦААХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**
(Бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай)

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 6 гишүүнээс 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд Бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар уг хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцсэн бөгөөд санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасан.

**“МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХОРИГИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг үндэслэн, мөн хуулийн 31.5, 31.6 дахь заалтын дагуу “Д.Муратын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай” Улсын Их Хурлын 45 дугаар тогтоолд тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авахаар шийдвэрлэсэн.

**“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 42 ДУГААР ТОЙРОГТ
НӨХӨН СОНГУУЛЬ ТОВЛОН ЗАРЛАХ, САНАЛ АВАХ ӨДРИЙГ ТОГТООХ
ТУХАЙ”, “МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 42 ДУГААР
ТОЙРГИЙН НӨХӨН СОНГУУЛЬД ТЕХНИК ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ”,
“НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ
ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛУУДЫН ТАНИЛЦУУЛГА**

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэг болон Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс товлон зарлаж, санал авах ажиллагааг 2018 оны 10 дугаар сарын 07-ны өдөр явуулахаар тогтоосон.

2.Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт болон Сонгуулийн ерөнхий хорооны саналыг тус тус

үндэслэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхээр шийдвэрлэсэн.

3. Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2.14 дэх заалт болон Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд 228 095 885 (хоёр зуун хорин найман сая ерэн таван мянга найман зуун наян таван төгрөг), орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд 162 537 250 (нэг зуун жаран хоёр сая таван зуун гучин долоон мянга хоёр зуун тавин төгрөг) төгрөгийг тус тус Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулж, тус Байнгын хорооны 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн тухай санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн уг тогтоолыг баталлаа.

“Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолд 24 хууль тогтоомжийн төслийг нэр заан тусгахдаа дараах зарчмыг баримталсан болно. Үүнд:

Дараах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж байхаар тогтоосон.

Дараах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлбэл намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Монгол Улсын Их Хурлын даргад зөвшөөрсөн.

Энэ тогтоолд нэр зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа

Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн

Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон

1. Намрын ээлжит чуулганаар хэлэлцэн батлахаар хуульд тусгайлан заасан хууль тогтоомжийн төслүүд;

2. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа төслүүдээс холбогдох Байнгын хороод эхний ээлжинд хэлэлцүүлэхээр саналаа ирүүлсэн төслүүд;

3. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд заасан болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр тэргүүн ээлжинд хэлэлцэх хууль тогтоомжийн төслүүдийг хамруулах.

Энэхүү тогтоолоор хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолд нэр зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж байхаар тогтоосон. Мөн Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлбэл намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Монгол Улсын Их Хурлын даргад зөвшөөрсөн болно.

Б) Төсөв, санхүүгийн чиглэлээр:**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

БАТАЛСАН ОГНОО	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2018.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2019.01.01
---------------------------	--	--

ГВАЛИНГААС БУСАД БҮХ ТӨРЛИЙН ТҮЛШНИЙ ЗОРИУЛАЛТЫН МОД

СТАНДАРТЫН ДАГУУ ХИЙГДСЭН, УГСРАХАД БЭЛЭН МОДОН БАРИЛГЫН УГСАРМАЛ ХИЙЦ

ОЙЖУУЛАЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ, ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖИЛ

ИМПОРТООР ОРУУЛЖ БАЙГАА ТУУШ ЧИГЛЭЛИЙН НИМГЭН ДАВХАРГАТАЙ ХАВТАН \ОСВ\

2019.01.01 ~ 2022.12.31
НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛНӨ

СТАНДАРТЫН ДАГУУ ХИЙГДСЭН, УГСРАХАД БЭЛЭН МОДОН БАРИЛГЫН УГСАРМАЛ ХИЙЦ

ОЙЖУУЛАЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ, ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖИЛ

ИМПОРТООР ОРУУЛЖ БАЙГАА ТУУШ ЧИГЛЭЛИЙН НИМГЭН ДАВХАРГАТАЙ ХАВТАН \ОСВ\

2018.01.01 ~ 2019.01.01
ХУГАЦААНД ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ТӨЛСӨН НӨАТ-ЫГ БУЦААН ОЛГОНО

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН
ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.05.10

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас

2018.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

2019.01.01



ГУАЛИНГААС БУСАД БҮХ
ТӨРЛИЙН ТҮЛШНИЙ
ЗОРИУЛАЛТЫН МОД



ТУУШ ЧИГЛЭЛИЙН НИМГЭН
ДАВХАРГАТАЙ ХАВТАН /OSB/



СТАНДАРТЫН ДАГУУ ХИЙГДСЭН,
УГСРАХАД БЭЛЭН МОДОН
БАРИЛГЫН УГСАРМАЛ ХИЙЦ

2019.01.01

2022.12.31

ИМПОРТООР ОРУУЛАХАД
ГААЛИЙН АЛБАН
ТАТВАРААС ЧӨЛӨӨЛНӨ



ТУУШ ЧИГЛЭЛИЙН НИМГЭН
ДАВХАРГАТАЙ ХАВТАН
/OSB/



СТАНДАРТЫН ДАГУУ ХИЙГДСЭН,
УГСРАХАД БЭЛЭН МОДОН
БАРИЛГЫН УГСАРМАЛ ХИЙЦ

2018.01.01

2019.01.01

ИРГЭД, АЖ АХУЙН
НЭГЖИЙН ТӨЛСӨН
ГААЛИЙН АЛБАН
ТАТВАРЫГ БУЦААН
ОЛГОНО

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС БЭЛТГЭВ


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2020-2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2018.05.25	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2018.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	---	---

ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ 2019-2021



Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь ирэх 3 жилийн макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөлд суурилсан дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын баримт бичиг



ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН “ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралаас өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцээд 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдөр баталлаа.

Төрийн санхүү, эдийн засгийн чадавхыг сайжруулах, татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөгчөөс улсын төсөвт төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг батлагдсан норм, норматив, стандарт, зураг төсөвгүй зарцуулж байгааг таслан зогсоох, төсвийн эрх захирагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Хууль батлагдсанаар төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ батлагдсан норм, норматив, стандарт, зураг төсвийг үндэслэхээс гадна төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн нийлбэрээс бүрдэнэ гэсэн зохицуулалтыг тусгасан.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасныг үндэслэн “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хорооноос боловсруулан Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

Тогтоолоор бүх салбарт мөрдөгдөж байгаа зардлын норм, норматив, стандартыг валютын ханш, зах зээл дэх бараа, ажил үйлчилгээний үнийн өөрчлөлт, техник, технологийн дэвшлийг үндэслэн шинэчлэх ажлыг зохион байгуулах, урсгал болон хөрөнгийн зардлын төлөвлөлт, төсвийн гүйцэтгэлийн хяналт хийхэд эдгээр норм, норматив, стандартыг хэрхэн ашиглах талаар холбогдох хуульд заасан журам, зааврыг баталж мөрдүүлэх, шаардлагатай бол хуульд өөрчлөлт оруулах төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

**“ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙН ХАМРАХ ХҮРЭЭГ
НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.05.30

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2018.04.06,

Засгийн газраас
2018.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн журмаар

**ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙН ХАМРАХ
ХҮРЭЭГ 2018 ОНЫ 4 САРААС ЭХЛЭН НЭМЭГДҮҮЛЭЭ**

2018.04 сараас өмнө

2018.04 сараас хойш



Хамрагдах хүүхэд

684.0

912.0

МЯНГАН ХҮҮХЭД



Олгох тэтгэмж

164.2

205.2

ТЭРБУМ ТӨГРӨГ



Зорилтот бүлэг



60%



80%

ХАМРАХ ХҮРЭЭ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС БЭЛТГЭВ

**ЦААШИД 0-18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД БҮРД ХҮҮХДИЙН
МӨНГӨН ТЭТГЭМЖ ОЛГОХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭНЭ**

Тогтоол батлагдсанаар өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны нийт хүүхдийн 80 хувьд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг сар бүр бэлэн мөнгөөр олгохоор болов.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2018 онд 684.0 мянган хүүхдэд олгохоор 164.2 тэрбум төгрөг улсын төсвийн Халамжийн санд тусгагдан батлагдсан юм. Харин 80 хувьд олгоход нийт 228.0 мянган хүүхэд нэмж хамрагдах бөгөөд үүнд төсвөөс 41.3 тэрбум төгрөг нэмж зарцуулахаар боллоо.

**“МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА****БАТАЛСАН
ОГНОО****2018.06.28****ХУУЛЬ САНААЧИЛСАН**

Засгийн газраас

2018.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн журмаар

**1. МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР:**

Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2017 оны жилийн эцсийн байдлаар 7,958.3 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 29.3 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 9,017.3 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 33.2 хувь болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,742.5 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 6.4 хувьтай тэнцэж байна. Нийт орлого ба тусламжийн дүнд нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж 91.4 хувийг, Тогтворжуулалтын сангийн орлого 4.1 хувийг, Ирээдүйн өв сангийн орлого 4.5 хувийг тус тус эзэлж байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн: 2017 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 7,274.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 591.1 тэрбум төгрөгөөр буюу 8.1 хувиар илүү биелсэн бол өмнөх оны гүйцэтгэлээс 1,439.9 тэрбум төгрөг буюу 19.8 хувиар өссөн байна.

Тайлант онд татварын орлогын бүрдүүлэлт 6,315.1 тэрбум төгрөгт хүрч, нийт тэнцвэржүүлсэн орлогын 86.8 хувийг бүрдүүлж, төлөвлөсөн орлогоос 10.4 хувиар буюу 597.4 тэрбум төгрөгөөр давж биелэсэн байна.

Харин татварын бус орлогын гүйцэтгэл 959.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 6.3 тэрбум төгрөгөөр тасарч, 99.3 хувийн биелэлттэй байна.

Нэгдсэн төсвийн зарлага санхүүжилт: Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2017 онд 9,017.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 477.1 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцэл: Монгол Улсын 2017 оны тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,810.6 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,742.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу 1,068.1 тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 2.1 дахин буурч, дотоодын нийт бүтээгдэхүүний 6.4 хувийг эзэлж байна.


МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



ТӨСВИЙН ОРЛОГО



ТӨСВИЙН ЗАРЛАГА



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН



ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

В) Эдийн засгийн чиглэлээр:**БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Банкны салбарт хийгдэх бүтцийн өөрчлөлтийн суурь нөхцөлийг бэхжүүлэх замаар банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих зорилго бүхий Банкныг дахин хөрөнгөжүүлэх тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн “Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль” нэртэйгээр баталсан.

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд банкинд өөрийн хөрөнгийн шаардлага тавих, өөрийн хөрөнгийн шаардлагыг банк, банкны хувьцаа эзэмшигч, бусад хөрөнгө оруулагчаар хангуулах, эдгээрээс банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг тогтоосон хугацаанд хангаж чадаагүй тохиолдолд банкнаас дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх, төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлэх нөхцөл, хэлбэр, үйл ажиллагаа, банкинд төрөөс оруулсан хөрөнгийг удирдах, төсөвт буцаан төвлөрүүлэх, төрийн байгууллагын бүрэн эрх, төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банкинд хийх хяналт шалгалт, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг тусгасан.

Өөрийн хөрөнгийн дутагдал, алдагдлыг банкны хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд хүлээсний дараа төрөөс бусад хөрөнгө оруулагч банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд энгийн хувьцаа, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд энгийн хувьцаанд хөрвөх давуу эрхийн хувьцаа хэлбэрээр хөрөнгө оруулах бол төрөөс банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд энгийн хувьцаа, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг хэлбэрээр хөрөнгө оруулах зохицуулалтуудыг тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар олон нийтээс банкинд итгэх итгэл нэмэгдэж, банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ сайжирч, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдлээ.

**“МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ
ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монголбанк Мөнгөний бодлогын хороотой байх, уг хороо нь Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэх тухай зохицуулалт нэмж оруулсан билээ.

Хуулийн дээрх заалтыг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос Мөнгөний бодлогын зөвлөлийн орон тооны бус гишүүдэд Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шалгуурыг хангасан Цэрэндоржийн Батсүх, Цэдэвсүрэнгийн Мөнхбаяр, Чулуундоржийн Хашчулуун нарыг тус тус санал болгосон. Нэр дэвшигчдийг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилохоор шийдвэрлэж, “Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүдийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталлаа.

Мөнгөний бодлогын хорооны эрх зүйн байдал, гишүүдийн томилгоог анх удаа хуульчлан тогтоосон бөгөөд Хорооны хуралдаанаар төрийн мөнгөний бодлогын төсөл, мөнгөний бодлогын хэрэгслийн хүү болон банкны заавал байлгах нөөцийн хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хувь, хэмжээг хэлэлцэн шийдвэрлэх юм.

“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2018.05.24	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2018.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	---	---

■

"МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ" БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛ

Хөрөнгө оруулалтыг дэмжиж эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах; төсөв, мөнгөний бодлогыг хослуулж инфляцийг зорилтот түвшинд байлгах; ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах; нэгдсэн төсвийн үндсэн тэнцлийг зэрэг болгох нөхцөлийг бүрдүүлэх; эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болон хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангана.

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах; агаар орчны бохирдлыг бууруулах, байгалийн нөөцийн хамгаалалт зохиистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг авна.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Улсын Их Хурлын Тамгын газар

Эдийн засгийн бодит салбаруудын бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд эдгээр салбаруудын өсөлтийн нөлөөгөөр ДНБ-ий бодит өсөлт хангагдах боломж бүрдэнэ. 2019 онд уул уурхайн салбар 6.3%, уул уурхайн бус салбар 8.4%, барилгын салбар 14%, үйлчилгээний салбар 8.6%-иар тус тус өснө.

Нийгмийн хамгаалал, нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

• Үндсэн чиглэлд 5 бүлэг, 20 зорилт, 135 арга хэмжээ төлөвлөгдсөн

Эмнэлэг 11-ийг шинээр барьж, өргөтгөнө

Сургууль 62-ыг шинээр барина

Цэцэрлэг 85-ыг шинээр барина

Уул уурхайн салбар - 6.3% ↑

Уул уурхайн бус салбар - 8.4% ↑

Барилгын салбар - 14% ↑

Үйлчилгээний салбар - 8.6% ↑

2019 оны үндсэн чиглэл нь Макро эдийн засгийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, инфляцыг зорилтот түвшинд байлгах, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах, нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг өмнөх оны түвшнээс бууруулах замаар дунд хугацаанд төсвийн үндсэн тэнцлийг эерэг болгох нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болон Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалт татах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилтуудад чиглэгдлээ.

**“ТӨРИЙН ӨМЧӨӨС АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД
ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

Төрийн болон орон нутгийн өмчийн 2016 оны улсын үзлэг, тооллогын дүнгээр төрийн өмчийн зарим эд хөрөнгийг аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх асуудал тавигдаж, Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Уг тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Тогтоол 2 заалттай бөгөөд 1 дүгээр заалтаар төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар батлахаар заасан бөгөөд хавсралтад тэдгээр эд хөрөнгийн байршил, эд хөрөнгө тус бүрийн балансын үнийн дүнг тусгасан. Тогтоолын 2 дугаар заалтад эд хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой урсгал зардлыг 2018 оны батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан. Тогтоолыг хэрэгжүүлэхэд 8.7 сая орчим төгрөг зарцуулах урьдчилсан тооцоолол гарсан байна. Мөн зарим аймагт байгаа барилгыг хүүхдийн цэцэрлэгийн зориулалттай болгон өөрчлөх барилгын засварын зардал болон цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах багш ажилчдын цалин хөлс, урсгал зардлыг тооцож орон нутгийн төсөвт тусгах шаардлага байгаа болно.

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлснээр шинээр байгууллага байгуулах, эсхүл байгууллага дотор шинээр нэгж, алба бий болгох шаардлага үүсэхгүй бөгөөд цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж нэмэх зэрэг эдийн засгийн нэмэлт зардал шаардахгүй болно. Тогтоолд тусгагдсан бусад хөрөнгийн хувьд орон нутгийн өмчид шилжсэнээр ашиглалтын зардал нэмэгдэхгүй бөгөөд түрээсийн төлбөрийн зардал буурах юм.

Тогтоолын хавсралтаар нийтдээ 28,136,741.71 мянган төгрөгийн үнэ бүхий 68 хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэхээр тусгалаа:

1.Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говь-Сүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон

эргэлтийн хөрөнгийг цогцолбороор нь /санхүүгийн тайлангийн 2017.12.31-ний дүнгээр/ холбогдох аймгийн өмчид шилжүүлэх;

2.Аймгууд дахь Хөдөлмөрийн хэлтэс татан буугдсан тул дансанд нь бүртгэлтэй байсан зарим автомашиныг Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Сүмбэр, Дундговь, Дорноговь, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн өмчид шилжүүлэх;

3.Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн худалдааны битүү захын барилгыг тухайн аймгийн өмчид шилжүүлэх;

4.Мөн эрчим хүч, дэд бүтцийн зарим байгууламж, объектууд болон төрийн өмчийн компаниудын дансанд бүртгэлтэй суудлын автомашинуудыг тухайн орон нутгийн өмчлөлд шилжүүлэхээр тусгалаа.

Энэхүү тогтоол батлагдсанаар, төрийн өмчид байгаа илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг хэрэгцээ шаардлагатай байгаа орон нутагт шилжүүлэх хөрөнгийн зохицуулалт хийх, Төсвийн тухай хууль, Эрчим хүчний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, хяналтыг сайжруулах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэх, аймаг, нийслэлийн эдийн засагт багагүй нөлөө үзүүлэх зэрэг ач холбогдол бий болж байна.

Үүнээс гадна төрийн өмчөөс шилжүүлж авсан барилгыг ашиглан хүүхдийн цэцэрлэг дөрвийг ажиллуулснаар цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн тоо буурна. (Дархан-Уул, Баянхонгор, Говь-Алтай, Архангай аймагт цэцэрлэг нэмж байгуулан, нийт 350 орчим хүүхдийг цэцэрлэгт хамруулна.)

“БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН 2010 ОНЫ 32 ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн чуулганы 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан.

Дээрх тогтоолын хавсралтад хилийн зарим боомтын төмөр замын ачаа тээврийн төвлөрлийг багасгах, төмөр замын дэд бүтцийн сүлжээг өргөтгөх, уул уурхайн болон бусад салбарын бүтээгдэхүүний экспорт, импортын тээврийг

дэмжих зорилгоор Зүүнбаян-Ханги-280 км, Эрдэнэт-Арцсуурь-780 км төмөр замын шинэ чиглэлийг тогтоох, замын уртыг 900 км байсныг 1900 км болгон өргөтгөхөөр тусгасан байна.

Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам баригдсанаар БНХАУ-ын ӨМӨЗО-ы аж үйлдвэрийн төв болох Бугат хот руу Монгол Улсаас жилд 2-4 сая тонн коксжих нүүрс, 0.3-0.5 сая тонн зэсийн баяжмалын (Цагаансуварга, Эрдэнэт) нийлүүлэлт, ОХУ-аас 1-6 сая тонн нефть, 1 сая тонн модны транзит тээвэрлэлт, мөн Бугат-Зүүнбаян чиглэлд 1-2 сая тонн бараа бүтээгдэхүүн (барилгын материал, металл хийц, нефтийн бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, хүнд машин механизм)-ий тээвэрлэлт нэмэгдэж Монгол Улсаас экспортод гаргаж байгаа түүхий эд, бараа бүтээгдэхүүний эргэлт, өрсөлдөх чадвар нэмэгдэж, өртөг зардал буурч Монгол Улсын эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулах боломж бүрдэх юм.

Түүнчлэн Эрдэнэт-Арцсуурь чиглэлийн төмөр замыг ашиглалтад оруулснаар Монгол Улсын баруун хойд бүс нутгийн ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг нээж, жилдээ 10-15 сая тонн бүтээгдэхүүн тээвэрлэх, цаашид ОХУ-ын Тува улсын Кызылтэй холбогдсоноор Улуг-Хемийн нүүрсний сав газрын ордуудаас жилдээ 47 хүртэлх сая тонн нүүрсийг Монгол Улсаар дамжуулан тээвэрлэх бололцоотойгоос гадна Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтран хэрэгжүүлэхээр тохиролцсон “Эдийн засгийн коридор”-ын хойд чиглэл болох Курагино - Кызыл - Цагаантолгой - Арцсуурь - Овоот - Эрдэнэт - Салхит - Замын-Үүд - Эрээн -Улаанцав - Жанчхүү - Бээжин - Тяньжин чиглэлийн төмөр замын төсөл нь Ази-Европыг холбосон транзит тээврийн шинэ коридорыг бий болгох, гурван улсын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түлхэц болох, Монгол Улсын хойд бүсийг хөгжүүлэх, тухайн бүс нутгийн худалдааны тээврийг хөнгөвчлөх чухал ач холбогдолтой юм.

Уг тогтоолд тусгагдсан “Зүүнбаян-Ханги”, “Эрдэнэт-Арцсуурь” чиглэлийн төмөр замын төслүүдийг хэрэгжүүлснээр Монгол Улсын төмөр замын үндсэн коридорыг БНХАУ, ОХУ-тай тус бүр 2 төмөр замын гарцаар холбож Европ, БНХАУ-ын хоорондох транзит тээвэрт өрсөлдөх чадвар өндөртэй коридоруудын нэг болж, улсын валютын орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

**“ТӨРӨӨС ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРТ 2020 ОН ХҮРТЭЛ
БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН
2013 ОНЫ 18 ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн чуулганы 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан.

Дээрх тогтоолын хавсралтад “Агаарын тээврийн зах зээлийг үе шаттай чөлөөлөх бэлтгэл хангах зорилгоор үндэсний агаарын тээвэрлэгчийн олон улсын үндсэн нислэгийн чиглэлд (Улаанбаатар-Сөүл-Улаанбаатар, Улаанбаатар-Бээжин-Улаанбаатар) хоёрдогч тээвэрлэгчийг оруулахгүй байх, бусад тээвэрлэгчийг олон улсын бусад шугамд, орон нутаг, бүс нутгийн шугамд хуваарилах зарчмаар агаарын тээврийн зах зээлийг эдийн засгийн хувьд зохицуулах чиглэл баримтлах, гадаад улсын үндсэн нислэгийн чиглэлээс Монгол Улс руу хуваарьт нислэг үйлдэх тээвэрлэгчийн тухайд “нэг шугам-нэг тээвэрлэгч” бодлого баримтална” гэж заасан нь агаарын тээврийн харилцаанд чөлөөт өрсөлдөөнийг хязгаарласан, тээвэрлэлтийн үнэ тарифыг бууруулах боломжгүй нөхцөл байдал үүсгэж байгаа тул уг зохицуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан байна.

“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолын хавсралтад заасан “олон улсын үндсэн нислэгт хоёрдогч тээвэрлэгчийг оруулахгүйгээр нислэгийн шугамыг хуваарилж байгаа одоогийн зарчмыг өөрчилж агаарын харилцаанд чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, нислэгийн давтамжийг агаарын хөлгийн суудлын багтаамжтай уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх зарчмаар олон улсын шугамыг хуваарилж”, “гадаад улсын үндсэн нислэгийн чиглэлээс Монгол Улс руу хуваарьт нислэг үйлдэх тээвэрлэгчийн тухайд “нэг шугам-нэг тээвэрлэгч” бодлого баримтална” гэж заасныг “үндэсний компанийн өрсөлдөх чадварыг харгалзан, ижил тэнцүү орчинд өрсөлдөх бодлого баримтлах”-аар үндэсний агаарын тээвэрлэгчид ач холбогдолтой уян хатан зохицуулалтыг тусгах нь зүйтэй гэж үзэн Улсын Их Хурлаас тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулан шийдвэрлэлээ.

Ингэснээр агаарын тээврийн харилцаанд чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, хоёр талын агаарын тээвэрлэгч зах зээлд ижил тэгш боломжоор хангагдаж, зах зээлийн зарчмаар өрсөлдөх, зорчигч тээврийн хүчин чадал нэмэгдэх, агаарын тээврийн үнэ тариф буурах боломж бүрдэж байна.

**“ТАВАНТОЛГОЙН НҮҮРСНИЙ ОРДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЭРЧИМЖҮҮЛЭХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.06.29


ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас

2018.06.21-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн журмаар



Улсын Их Хурлын тогтоолоор жил бүрийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлахдаа Тавантолгойн ордыг түшиглэн нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам, төмөр зам, авто зам барих асуудлуудыг тусгасаар ирсэн боловч гүйцэтгэл нь хангалтгүй байсаар ирсэн. Тодруулбал, тус ордыг түшиглэн үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн нөхцөл байдлаас үүдэн бүтээн байгуулалтын төслүүдийг ойрын үед хэрэгжүүлэх боломж тааруу байгаагаас гадна тус ордыг ашигласнаар нийгэм, эдийн засагт үүсэх үр өгөөжийг тооцоолсон хэмжээнд хүргэж чадахгүй, экспортын орлогыг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн экспортод гаргах зорилтын хэрэгжилтийг хангаж чадахгүй байлаа.

Г) Нийгэм, боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр

**БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2018.06.27</p>	<p>ХУУЛЬ САНААЧИЛСАН</p> <p>УИХ-ын гишүүн Н.Учрал, Ж.Энхбаяр нараас 2018.06.15-ны өдөр өргөн мэдүүлсэн</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>Ердийн журмаар</p>
---	---	--

<p>ХАМРАХ ХҮРЭЭ:</p> <p>Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх шатны албан болон албан бус боловсролын сургалтын байгууллагад ажиллаж буй 55 мянга гаруй багш хамрагдах болно.</p>	<p>БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТОГТОЛЦОО:</p> <p>БАГШ БЭЛТГЭХ</p> <p>ДАВТАН СУРГАХ</p> <p>МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ</p> <p>ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИХ</p>
---	---

БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВД: | БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИНЭ:

<p>БАГШ ХӨГЖИЛ ТӨВ</p> <p>↓</p> <p>СӨБ ЕБС МБСТ</p> <p>ХУВЬСАХ ЗАРДЛЫН 2% ЗАРЦУУЛНА</p>	<p>Үндэсний түвшинд Орон нутгийн түвшинд Сонирхлын түвшинд Багшийн түвшинд</p>
--	--

<p>Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл хэлэлцэж батална.</p>	<p>Багшид:</p> <ul style="list-style-type: none"> -Хөдөө орон нутагт дадлагагич багшаар 6 сар ажиллавал тэтгэмж олгоно. -Үр дүнд суурилсан урамшуулал олгоно. -Мэргэжлийн зэргийг хугацаанаас өмнө нэмэгдүүлэх боломжтой. -ЕБС-ийн 44-өөс дээш суралцагчтай 1,2 дугаар ангид туслах багш ажиллаж болно.
--	--

Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль 7 бүлэг, 18 зүйлтэй бөгөөд энэ хуулийн зорилт нь багш бэлтгэх, багшийн хөгжил, оролцоог дэмжих, ёс зүй, нэр хүнд, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлж өгсөн.

Хоёрдугаар бүлэгт багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо, багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, багшийн хөгжлийн төв, багш бэлтгэх талаар тусгасан.

Гуравдугаар бүлэгт багшийн нийгмийн баталгаа, багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох зэрэг зохицуулалтыг тусгасан.

Дөрөвдүгээр бүлэгт багшийн Ёс зүй, ёс зүйн хороо, Ёс зүйн дүрмийг тусгасан.

Тавдугаар бүлэгт төрийн байгууллагын эрх үүрэг, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт арга-зүйн байгууллагын эрх үүргийг тусгав.

Зургадугаар бүлэгт хуулийн биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой заалтыг тусгасан.

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэн баталлаа.

Боловсролын тухай хуульд зааснаар аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй харьяа ерөнхий боловсролын сургуулийн захирал, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийг томилж, чөлөөлдөг байсныг сум, дүүргийн Засаг дарга томилж, чөлөөлж байхаар тус хуульд тусган хуульчиллаа.

Сум, дүүргийн Засаг дарга нь аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох бөгөөд тэдгээрийн үр дүнгийн гэрээний хэрэгжилт, аймгийн Боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлж байхаар боллоо.

Мөн дүүргийн Засаг дарга тухайн дүүргийн Боловсролын хэлтсийн даргыг нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн нийслэлийн Боловсролын газрын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх болсон бөгөөд энэхүү зохицуулалт нь одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хуульд тусгагдаагүй байсан тул энэ асуудлыг хуульд нэмж тусган баталсан.

Энэ хуулийг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэлэлцэн баталлаа.

Хууль батлагдсанаар ерөнхий боловсролын сургуулийн захирал нь сургуулийн барилга байгууламж дахь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байр, талбай, тоног төхөөрөмжийг нийтийн өмчийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахтай холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актаар тогтоосон журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар зориулалтын дагуу түрээслүүлэх эрхтэй болсон бөгөөд энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын зургаан гишүүнээс 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Орон нутгийн түвшинд төрийн үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, анхан шатны үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагын хүний нөөц, түүний чадавхыг бэхжүүлэх, чиг үүрэг, эрх мэдлийг оновчтой хуваарилах, шилжүүлэх, тэнцвэржүүлэх ажлыг дэс дараатай, тогтвортой үе шаттай хийх шаардлага байсаар байна.

Орон нутагт мэргэжлийн байгууллагын удирдлагыг томилохдоо дээд шатны байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлдөг байх зарчмыг баримтлан Нийгмийн даатгалын тухай хуулийн “Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага” гэсэн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын даргыг нийгмийн даатгалын төв байгууллагын дарга, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын даргыг нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө” гэсэн өөрчлөлт оруулсан.

Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын зургаан гишүүнээс 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Орон нутагт мэргэжлийн байгууллагын удирдлагыг томилохдоо дээд шатны байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлдөг байх зарчмыг баримтлан Нийгмийн халамжийн тухай хуулийн “Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, хяналт” гэсэн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт “аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллагын дарга, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө” гэсэн өөрчлөлт орууллаа.

Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын зургаан гишүүнээс 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Орон нутагт мэргэжлийн байгууллагын удирдлагыг томилохдоо дээд шатны байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлдөг байх зарчмыг баримтлан Хүүхэд хамгааллын тухай хуулийн “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа” гэсэн 18 дугаар зүйлд 18.3, 18.4 дэх хэсгийг нэмсэн болно.

Тухайлбал, дээрх хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилж чөлөөлөхөөр, 18.4 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан газар, хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан газар, хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж тус тус томилж, чөлөөлнө” гэж тусгалаа.

Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх юм.

**“ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

(Шинжлэх ухаан, технологийн талаар
төрөөс баримтлах бодлогыг батлах тухай)

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр баталлаа.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт “Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна” гэж зааснаар “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг 2017 оны Монгол Улсын Засгийн газрын 295 дугаар тогтоолоор баталсантай холбогдуулан “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар тогтоолыг хүчингүй болгохоор тогтоолын төсөлд тусгасан.

**“ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

(Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар
төрөөс баримтлах бодлого батлах тухай)

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдөр “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт “Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар батлуулна” гэж заасантай нийцүүлж “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 95 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлан гаргасан.

Д) Байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр**БАЯЖУУЛСАН ХҮНСНИЙ ТУХАЙ
ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА****БАТАЛСАН
ОГНОО****2018.05.03****ХУУЛЬ САНААЧИЛСАН**УИХ-ын гишүүн А.Ундраа,
Б.Батзориг, Ц.Гарамжав нараас
2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА****2019.12.31**

Монгол Улсад 1992, 1999, 2004, 2010 онд хүн амын хоол тэжээлийн үндэсний судалгааг 4 удаа зохион байгуулсан.

Хүн амын хоол тэжээлийн 5 дугаар судалгааг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв 2016-2017 онд зохион байгуулсан.

Дээрх судалгаануудын дүнгээс харахад хүн амын дунд бичил тэжээлийн дутал байнга өсөн нэмэгдсээр байна. Хүн амын бичил тэжээлийн дутлыг хамгийн бага зардлаар нөхөх гарц, шийдэл нь хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг аминдэмээр баяжуулах явдал юм. Хууль нь 4 бүлэг 13 зүйлтэй.

Хүнс баяжуулах үйл явц:

Хүн амын хоол тэжээлийн үндэсний судалгааны дүнг үндэслэн эрүүл мэндийн болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран албан журмаар баяжуулах хүнсний саналыг Засгийн газарт хүргүүлэх бөгөөд тухайн саналыг үндэслэн албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтыг Засгийн газар батална.

Улмаар албан журмаар баяжуулах хүнсний төрөл тус бүрээр Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь бүтээгдэхүүний үндэсний стандартыг батална.

Үндэсний стандартын хүрээнд тухайн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүнээ баяжуулж үйлдвэрлэнэ.

Хуулийн үр нөлөө:

- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах;
- Амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой иргэд шим тэжээллэг хүнс хэрэглэх боломж бүрдэх;
- Бага зардлаар хүн амын аминдэмийн хэрэгцээг хангах;
- Улирлын чанартай шим тэжээлийн дутлаас сэргийлэх;
- Хүүхдийн оюуны болон бие бялдрын өсөлт хөгжилтөд эерэг нөлөөлөх зэрэг болно.

Баяжуулан үйлдвэрлэж байгаа хүнсний бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүнийг импортлох тохиолдолд Монгол Улсын Үндэсний стандартыг баримтлахаар хуульд тусгасан болно.



Улсын Их Хурлын
Тамгын газар

БАЯЖУУЛСАН ХҮНСНИЙ ХУУЛЬ

Баталсан огноо: 2018.05.03



Хуулийн зорилт

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, аминдэм, эрдэс бодисын дутлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зарим төрлийн хүнсний албан журмаар баяжуулах

Хүнс баяжуулах?

Хүнсэнд аминдэм, эрдэс бодисыг дангаар болон холимог хэлбэрээр үйлдвэрийн аргаар нэмэх

Хэн хяналт тавих?

Хүнсний чанар, стандартын улсын байцаагч

Импорт?

Албан журмаар баяжуулах хүнстэй ижил нэр төрлийн импортын бүтээгдэхүүн нь Монгол Улсын Үндэсний стандартын шаардлагыг хангасан байна

3

Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтыг ЗАСГИЙН ГАЗАР батална.



Албан журмаар баяжуулах хүнсний бүтээгдэхүүн тус бүрээр ҮНДЭСНИЙ СТАНДАРТ батална.

4

2
Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтыг ЗАСГИЙН ГАЗАРТ хүргүүлнэ.

1

Эрүүл мэндийн болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран албан журмаар баяжуулах хүнсний талаарх саналыг боловсруулна.



ХУУЛИЙН ҮР НӨЛӨӨ

- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах
- Амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой иргэд шим тэжээллэг хүнс хэрэглэх
- Бага зардлаар аминдэмийн хэрэгцээг хангах
- Удирлын чанартай шим тэжээлийн дутлаас сэргийлэх
- Хүүхдийн оюуны болон бие бялдрын өсөлт хөгжилтөд эерэг үр дагавар гарах

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.04.26

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас

2018.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

2019.05.01

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛСЭН ХУУЛИЙН ХУГАЦАА



2003-2007

ГЭР БҮЛ 174,016
6,6%

ГАЗАР ӨМЧИЛСӨН

2008-2012

ИРГЭД 330,240
11,5%

ГАЗАР ӨМЧИЛСӨН

2013-2017

ИРГЭД 570,771
18,3%

ГАЗАР ӨМЧИЛСӨН

2018.05.01-НЭЭС 2028.05.01

10 ЖИЛИЙН ХУГАЦААГААР СУНГАВ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын зургаан гишүүнээс 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан.

Хууль батлагдсанаар:

Аймаг, нийслэлийн ус цаг уур, орчны шинжилгээний төв болон лаборатори, хүрээлэнгийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, улсын сүлжээний нэгжийн албан хаагчийг төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж, тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн харьяалах төв, лаборатори, хүрээлэнгийн дарга томилж, чөлөөлдөг болсон буюу төвлөрлийг сааруулсан шинэ зохицуулалт бий болсон.

Е) Аюулгүй байдал, Олон улсын гэрээ, конвенцийн чиглэлээр

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНД БАЙГУУЛСАН АЗИЙН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭГЭЭР ОЛОН
УЛСЫН АВТОТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.04.12

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас

2018.02.02-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн журмаар

БАТАЛСАН ОГНОО: 2018.04.12

**ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХЭД
ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**



**Зөвшөөрлийн бичиг
авсан байх**

**Жолооны үнэмлэх, тээврийн
хэрэгслийн гэрчилгээний
баталгаат орчуулгатай байх**

Хариуцлагын даатгалтай байх

**Аюултай ачаа тээвэрлэхэд
тусгай зөвшөөрөл авах**

АВТОТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХ ЧИГЛЭЛ

АН4

Новосибирск
Барнаул
Горно-Алтайск
Ташақта/Улаанбайшинт
Ховд
Ярантай/Такешикан
Өрөмч
Каши
Хонгираф

АН3

Улаан-Үд
Хиагт/Алтанбулаг
Улаанбаатар
Сайншанд
Замын-Үүд/Эрээн
Бээжингийн гадна тойргоор
Тяньжин

RUSSIA
MONGOLIA
CHINA

Бусад улс нэгдэн орох боломжтой

ХАМТАРСАН ХОРОО

**Тал тус бүрээс
хоёр төлөөлөгч**

Зөвшөөрлийн тоо хэмжээг тогтооход

**Талуудын дотоодын хууль тогтоомжийн
талаар мэдээлэл солилцох**

Хэлэлцээрийн хэрэгжилт хянах

ХЭЛЭЛЦЭЭРИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Монголын тээвэрчид гуравдагч улс руу тээвэрлэлт гүйцэтгэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх, дамжин өнгөрөх тээвэрлэлтийн шинэ гарц нээгдэх эрх зүйн зохицуулалт бий болох

Олон улсын худалдаа, тээвэр, логикийн зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх

Гадаад худалдааны эргэлт өсч, ажлын байр нэмэгдэх

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН УРГАМЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.05.10


ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас

2018.05.04-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн журмаар



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас санаачлан ургамлын генетик нөөцийг хадгалж хамгаалах, тогтвортой ашиглах замаар даян дэлхийн хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээг 2001 онд баталжээ. Энэхүү гэрээ нь 2004 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд 2018 оны байдлаар дэлхийн 145 орон нэгдээд байна.

Энэхүү гэрээний үндсэн зорилго нь хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийг хамгаалах, хадгалах, ашиглах, түүнийг ашигласнаас бий болсон ашгийг Биологийн олон янз байдлын конвенцын зарчимтай (CBD) уялдуулан шударга, тэгш хуваарилах замаар хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил, хүнсний аюулгүй байдлыг хангах явдал юм.

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**
2018.06.27

ХУУЛЬ САНААЧИЛСАН
Засгийн газраас
2018.05.18-ны өдөр өргөн мэдүүлсэн


**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**
Ердийн журмаар

УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, БЭХЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХАД ЭНЭ ХУУЛИЙН ЗОРИЛТ ОРШИНО.



“ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТ” - ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ СТРАТЕГИ, УЛС ОРНОО БАТЛАН ХАМГААЛАХ ТОГТОЛЦООНЫ ТУЛУУР ҮНДСЭ БӨГӨӨД БҮХ НИЙТИЙН ОРЛОЦООТойгоор ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ, ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ НЭГДМЭЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЦОГЦ

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, УЛСЫН БОЛОН ЦЭРГИЙН ДАЙЧИЛГААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛНА.



УЛС ОРНОО БАТЛАН ХАМГААЛАХ НЭГДМЭЛ ТОГТОЛЦООНЫ ЦОГЦ БАЙДАЛ ХАНГАГДАНА.
 - ТАЙВАН ЦАГТ ИРГЭДИЙГ ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД СУРГАНА.
 - ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН БЭЛТГЭЛИЙГ БҮХИЙ Л ТҮВШИНД ХАНГАГДАНА.
 - ОНЦ БОЛОН ДАЙНЫ БАЙДЛЫН ҮЕД ОРОН НУТГАА ХАМГААЛАХ ЗАМААР МОНГОЛ УЛСЫГ ГАДНЫ ЗЭВСЭГТ ХАЛДГАА, ТҮРЭМГИЙЛЭЛЭЭС БАТЛАН ХАМГААЛАХ, ИРГЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ДЭМЖЛЭГ ЗҮҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ БОЛНО.

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-Д ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 01 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.5 дахь заалтад заасны дагуу боловсруулсан Монгол Улсын Батлан хамгаалах тухай (Шинэчилсэн найруулга) хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр баталсан Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад “дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох,” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурал 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авсан.

Энэхүү хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд Монгол Улсын Батлан хамгаалах тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг хүчингүй болгох тухай тусгасан.

Монгол Улсын Батлан хамгаалах тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг хүчингүй болгосноор ямар нэгэн хуулийн хийдэл, зөрчил үүсэхгүй, батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд аливаа сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй нийцэж байгаа болно.

Дайн бүхий байдал, дайны байдлын үед Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг холбогдох хууль тогтоомжид тодорхой хуульчилсан бөгөөд хууль тогтоомжоор хуульчлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн аливаа бүрэн эрхийг хүчингүй болгож байгаа асуудал байхгүй болно.

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.04.19

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас

2018.02.09-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн журмаар

ХУУЛИЙН ЗОРИЛТ



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх, улсын нисэхийн нислэгтэй холбогдолтой харилцааг зохицуулахад оршино.



Батлан хамгаалахын сайд ерөнхий шинжээчийг томилно. /5.1.4/

Гарын авлага, техникийн баримт бичгийг үйлдвэрлэгч орны хэл дээр ашиглана. /14.6/



Батлан хамгаалахын сайд осол зөрчлийг шинжлэн шалгах комиссын дүрмийг батална. /5.1.4/



Агаарын цэргийн командлалын хэрэгжүүлэх нислэгийн хөдөлгөөний зохицуулалт тодорхой болов. /11.1, 11.3/



Улсын нисэхийн багц дүрмийн өөрчлөлт /7-р зүйл/

Сургууль-байлдааны нислэгийн осол зөрчлийг улсын нисэхийн нислэг-техникийн шинжлэн шалгах комисс шалгана. /18.3/

Улсын агаарын хөлгийн нислэгийг 2 ангилалаар нэмэв. /10-р зүйл/



ХҮРЭХ ҮР ДҮН



- АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ, БОЛОМЖ БИЙ БОЛЖ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ САЙЖИРНА.

- УЛСЫН АГААРЫН ХӨЛГИЙН НИСЛЭГИЙН АНГИЛАЛ, ТӨРӨЛ ШИНЭЭР ТОДОРХОЙЛОГДОНО.


- УЛСЫН НИСЭХИЙН НИСЛЭГ-ТЕХНИКИЙН ОСОЛ ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ТОДОРХОЙ БОЛНО.


- АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ЗОХИЦУУЛАЛТ НАРИЙВЧЛАГДАН ЗОХИЦУУЛАГДАНА.



ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2018.06.27	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2018.05.18-ны өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	---	---





**“БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСАД
ЭЛЧИН САЙДЫН ЯАМ НЭЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.04.06

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас


2018.03.21-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн журмаар

**МОНГОЛ УЛСААС ХИЛИЙН ЧАҢАДАД СУУГАА
ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУД**

/2018.03-Р САРЫН БАЙДЛААР/



БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСТАЙ **1992.04.22**-нд
ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСОН.
ИРГЭД ХАРИЛЦАН **ВИЗГҮЙ** ЗОРЧДОГ.

ХОЁР ОРНЫ ХООРОНД БАЙГУУЛСАН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ **18** ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР

ХУДАЛДААНЫ НИЙТ ЭРГЭЛТ /2017.11-Р САРЫН БАЙДЛААР/

328,000 ам.дол



268,600 ам.дол



2018 ОНД

ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗРЫГ
ЭЛЧИН САЙДЫН ЯАМ
БОЛГОЖ ТҮВШИН АХИУЛАВ.



2014 ОНД

ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗРЫГ
НЭЭВ.

АЧ ХОЛБОГДОЛ

- Түүх, соёлын эртний уламжлалт харилцаа,
хэлхээ холбоо бэхжих,

- Хоёр орны худалдаа, эдийн засгийн
харилцааг түүхэн уламжлал, туршлагадаа
тулгуурлан харилцан ашигтай хэлбэрээр
хөгжүүлэх,

- Бус нутгийг хамарсан эдийн засгийн
томоохон төслүүдэд оролцох боломжтой
болох,

- Евроазийн эдийн засгийн холбооны гишүүн
орнууд болон бус нутгийн орнуудтай хийх
худалдааны эргэлт сайжрах.

“ЦАХИМ БОДЛОГЫН ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.05.24


ХУУЛЬ САНААЧИЛСАН

УИХ-ын гишүүн Ж.Энхбаяраас

2018.04.11-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн журмаар



Түр хорооны бүрэлдэхүүнийг 26 гишүүнтэй байхаар тогтоосон бөгөөд бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ж.Батзандан, Б.Баттөмөр, Л.Болд, С.Бямбацогт, Г.Занданшатар, Б.Жавхлан, Л.Мөнхбаатар, Ж.Мөнхбат, Ц.Мөнх-Оргил, З.Нарантуяа, Н.Оюундарь, Д.Оюунхорол, М.Оюунчимэг, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, О.Содбилэг, Г.Тэмүүлэн, Б.Ундармаа, А.Ундраа, Н.Учрал, Д.Цогтбаатар, Л.Элдэв-Очир, Б.Энх-Амгалан, Л.Энх-Амгалан, Ж.Энхбаяр нарыг тус тус баталсан байна.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ ХАВРЫН
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫГ ХААЖ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА М.ЭНХБОЛДЫН ХЭЛСЭН ҮГ**



Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулган хуулийн дагуу өнөөдөр өндөрлөж байна.

Өнгөрсөн хугацаанд байнгын, дэд хороод 101 удаа 180 орчим цаг хуралдаж, 304 асуудал, нэгдсэн чуулган 27 удаа, 133 орчим цаг хуралдаж, 181 асуудал хэлэлцжээ. Нэгдсэн чуулганы 27 удаагийн хуралдааны ирц дунджаар 83.0 хувьтай байж, бие даасан хууль 17, хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 67, олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай хууль 2, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 5, Улсын Их Хурлын тогтоол 50-ийг баталлаа.

Энэ удаагийн чуулганы нэг онцлог нь гишүүдийн ирц сайжирсан явдал юм. Үүргээ ухамсарлаж, хариуцлагыг эрхэмлэж ажилласан Та бүхэнд талархал илэрхийлье. Зөвхөн ирц оролцоо төдийгүй, батлан гаргасан хууль тогтоомж, Ажлын хэсэг, хуулийн төсөл болон бусад сэдвийн хэлэлцүүлэг зэрэг тоон үзүүлэлтээр энэ парламент өмнөх Их хурлуудаас илүү бүтээлч байгаа нь Та бүхний зүтгэл, чармайлттай шууд холбоотой гэдгийг тэмдэглэж хэлэхийг хүсэж байна.

Улсын Их Хурлын үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл болсон хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх талаар манай парламент томоохон ахиц өөрчлөлт гаргаж байгааг бас хэлэх хэрэгтэй. Зөвхөн 2018 оны хаврын чуулганы хугацаанд 15 ажлын хэсэгт давхардсан тоогоор 101 гишүүн оролцож, хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хэрэгжилтийг хянан шалгах ажил зохион байгуулжээ.

Улсын Их Хурлын гишүүд чуулганы хугацаанд Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Төрийн орон сууцны корпораци, Баянхонгор, Дархан-Уул аймгийн мэргэжлийн боловсролын байгууллагууд, “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Оюу толгой” ХХК зэрэг 21 байгууллагад хууль тогтоомжийн хэрэгжилттэй биечлэн танилцжээ.

Өнөөдөр бид “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталлаа.

Бүтэн арван жил ярьж, талцаж маргаж, улстөржилтийн нэг сэдэв болсоор ирсэн энэ ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төсөл бүрэн утгаараа хэрэгжих боломж бүрдлээ. Түүнийг дагасан авто зам, төмөр зам зэрэг дэд бүтцийн болон бусад төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга замыг Улсын Их Хурлын энэ шийдвэрээрээ тодорхойлсон.

Тавантолгой бол дэлхийн хэмжээний орд. Дэлхийд гайхагдах энэ баялаг Монголынх. Монголын баялаг Монголынхоо хөгжил дэвшил, монгол түмнийхээ сайн сайхан амьдралыг тэтгэх эх булаг болох ёстой. Тиймээс орд тойрсон элдэв эш мухаргүй яриа, хоосон улстөржилтөө цэглэж, туршлага сургамжаа санаж, шилдэг менежментэд суурилсан, өндөр үр ашигтай бүтэц бүрдүүлэхийн төлөө хугацаа алдалгүй, эрчтэй, далайцтай ажиллахыг Засгийн газарт даалгаж байна.

Төсөл амжилттай хэрэгжсэнээр ирэх онуудад эдийн засаг 10-аас дээш хувь өсөж, экспортын орлого 2.8 тэрбум ам.доллараар нэмэгдэж, улсын төсөвт жил бүр 400 саяас 1.1 тэрбум ам.долларын орлого төвлөрч, дунджаар 5800 орчим ажлын байр бий болно гэж тооцож байна.

Эрхэм гишүүд ээ,

Ёс зүйг эрхэмлэх, хариуцлагыг бэхжүүлэх асуудал нийт улс даяар нэн чухал байгаа. Энэ чиглэлээр хууль тогтоох дээд байгууллага Улсын Их Хурал үлгэр дуурайл үзүүлж ажиллана гэдгийг миний бие өмнө нь ч хэлж байсан.

Тиймээс ирц бүртгэх, үг хэлэх, санал өгөхөд хурууны хээний өгөгдөл ашиглах, хуралдаанд оролцсон ирцийг нь сар бүр олон нийтэд мэдээлж байх зэргээр сахилга, хариуцлагыг чангатгасан хуулийн өөрчлөлтийг хэлэлцэн баталлаа.

Гишүүд нь хуралдаа суухаа байгаад арга ядсандаа ийм өөрчлөлтүүд хийгээгүй юм. Хуралдаан таслах явдал өмнөх парламенттай харьцуулахад бараг 10 дахин багассан. Ард түмний элч, төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүдийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх замаар Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон парламентын засаглалын дархлааг нэмэгдүүлэхэд дээрх хуулиуд чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа юм.

Улсын Их Хурал Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны үндсэн үзүүлэлт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойллоо.

2019 онд эдийн засгийн өсөлтийг 8.0 хувьд хүргэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 8 их наяд 888.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээ 10 их наяд 993.8 тэрбум төгрөг, төсвийн алдагдал 2 их наяд 105.8 тэрбум төгрөг байхаар баталлаа. Эдгээр үзүүлэлтийг 2016 онтой харьцуулахад эдийн засаг 6.8 пунктээр өсч, төсвийн тэнцвэржүүлсэн орлого 3.5 их наяд төгрөгөөр буюу 3.5 пунктээр нэмэгдэж, төсвийн зарлага 8.4 пунктээр буурахаар байна.

Түүнчлэн 2016 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 88.0 хувьтай тэнцэж байсан Засгийн газрын өрийг 2019 онд 32.7 пунктээр бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 55.3 байхаар баталсан.

2019 онд Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт 60 хувьд хүрч, Тавантолгойн ордын ашиглалт өргөжинө. Газрын тос боловсруулах, нүүрс угаах, гүн боловсруулах болон зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрүүдийг барьж эхэлнэ. Эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, өргөтгөх томоохон төслүүд хэрэгжинэ. Ийнхүү уул уурхай, дэд бүтцийн томоохон төслүүд урагшилснаар Монгол Улсын эдийн засаг тогтворжиж, өсөх төдийгүй, төсвийн орлого нэмэгдэж, өр, зээлийн дарамт багасах юм.

Улсын Их Хурал Монгол-Орос-Хятадын “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн хүрээнд БНХАУ, ОХУ-тай байгуулсан Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэр гүйцэтгэх хэлэлцээрийг соёрхон баталлаа. Монголын тээвэрчид гуравдагч улс руу авто тээвэр гүйцэтгэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх, дамжин өнгөрөх тээврийн шинэ гарцыг нээж, худалдаа, тээвэр, татвар, даатгалыг харилцан хөнгөвчлөхөөр боллоо.

Бид дэлхий хэмээх нэгэн бүлийн бүрэн эрхт гишүүн нь. Бүс нутгийнхаа нэг хэсэг нь. Дэлхийн эдийн засагт чухал нөлөөтэй хоёр их хөрштэй айлсан суудаг. Өөрийн боломжийг алдаж, бусдын замд тээглэж сууж болохгүйг олон улсын харилцааны шинэ хандлага бидэнд сануулж байна. Тиймээс дэлхий рүү гарах гарц нь аль болох олон байх, хөрш болон бусад орнуудтай харилцах хамтын ажиллагаанаас ахиу өгөөж хүртэхийн төлөө санаж бодох зүйл их байна.

Эдийн засгийн өсөлтийг богино хугацаанд өрх, иргэнд хүргэх, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг тулгамдсан зарим асуудлыг энэ онд болон ирэх жилүүдэд шийдвэрлэх боломж бүрдэж байна.

Хаврын чуулганаар хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг 80 хувьд хүргэж, 912 мянга орчим хүүхдэд 205.2 тэрбум төгрөг олгох шийдвэр гаргасан. Цаашид хамрах хүрээг үе шаттай нэмэгдүүлж, шаардлагатай хэсэгт бүрэн олгох шийдвэр гаргах боломжтой гэж үзэж байна.

Энэ оны дөрөвдүгээр улиралд төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэхээр тооцож байна. 2019 онд тэтгэвэр, тэтгэмжийг нэмэхэд 137.3 тэрбум төгрөг зарцуулна.

Ирэх онд 85 цэцэрлэг, 62 сургуулийг ашиглалтад оруулж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 85.0 хувьд хүргэнэ. Гурван ээлжээр хичээллэж байгаа сургуулиудыг хоёр ээлжинд бүрэн шилжүүлнэ. Энэ бол боловсролын салбарт гарч буй томоохон дэвшил мөн. Энэ өөрчлөлт өсвөр үеийнхний боловсрол эзэмших, хүмүүжин төлөвших, авьяасаа хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Хүчирхийллээс хүүхдүүдээ хамгаалах, аюулгүй орчинд сурч, бойжих нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр иргэд, байгууллагуудын хүчин чармайлтыг нэгтгэн зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах, зөрчлийг нэн даруй арилгах, хариуцлага тооцох, шаардлагатай гэж үзвэл хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хойшлуулахгүй хийх шаардлагатай байна. Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар, бүх шатны байгууллага, ажил хариуцсан хүмүүс энэ асуудлыг онцгой анхааралдаа авбал зохино.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгох шийдвэр гаргасан нь энэ салбарт үйлчилгээний соёл, чанарын өрсөлдөөн бий болгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чанарын хувьсал болно гэж үзэж байгаа юм.

Улсын Их Хурал хойч үеийг сурган хүмүүжүүлэгч, оюуны соёл, мэдлэгийг өвлүүлэгч багш нарын хөгжлийг дэмжих хууль баталлаа. Энэ хуулиар багшийн мэдлэг, боловсрол, ёс зүй, нийгмийн баталгаа, мэргэжлийн ур чадвар, үнэлэмж, багш мэргэжлээр суралцагчдыг дэмжих тогтолцоог бүрдүүлсэн.

Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын 2 хүртэл хувийг буюу 11.6 тэрбум орчим төгрөг зарцуулдаг болно. Багш нарыг ажилласан жилээр нь бус ажлын амжилт, эцэг эх, хамт олны санал, сэтгэл ханамжид тулгуурлан мэргэжлийн зэргийг нэмэгдүүлж, цалин хөлсийг нэмэгдүүлэх боломж бүрдлээ. Энэ хууль Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх шатны албан болон албан бус сургалтын байгууллагын 55 мянга гаруй багшид хамаарна.

Монголын бурхны шашны судрын хамгийн эхэнд “Багш дор мөргөмү” хэмээдэг билээ. Багшаа дээдэлсэн нийгэм л илүү саруул, зөв тогтолцоотой, хөгжил дэвшил нь тогтвортой, иргэндээ ээлтэй байдгийг дэлхийн улс орнуудын туршлага бэлхнээ харуулсаар байна.

Хаврын чуулганаар Цахим бодлогын түр хороог 26 гишүүний бүрэлдэхүүнтэй байгууллаа. Энэ хороо төрийн ажил, үйлчилгээг ил тод, хүнд сурталгүй, шуурхай болгох, мэдээлэл технологийн хөгжил, дэвшлийг ашиглан хөгжлийн шинэ гарц нээх, олон улсын зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах боломжийг судлах, цахим бодлогын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиг үүрэгтэй ажиллана.

Түүнчлэн төрийн байгууллагын хүний нөөц, чадавхыг бэхжүүлэх, чиг үүрэг, эрх мэдлийг оновчтой хуваарилах ажлыг дэс дараатай, тодорхой үе шаттай хийж, төвлөрлийг сааруулах үйл явцыг дэмжих шийдвэрүүдийг Улсын Их Хурал гаргалаа.

Сум, дүүргийн Засаг дарга ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилж, чөлөөлдөг байх, дүүргийн Боловсролын хэлтсийн даргыг дүүргийн Засаг дарга нийслэлийн Боловсролын газрын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлдөг байхаар Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулав. Мөн ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн болон хүүхэд, гэр бүл, залуучуудын асуудал эрхэлсэн байгууллагын орон нутаг дахь удирдлага, зарим ажилтныг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлдөг байхаар хуулиудыг өөрчилсөн.

Ингэснээр орон нутгийн удирдлагын томилгоонд хөндлөнгөөс хутгалдан оролцдог, мэдлэг, чадвар, туршлагын шударга шалгуур биш, аль нам, хэн гэдэг албан тушаалтанд үйлчилсэн бэ гэдэг улс төрийн үнэлгээ голлох гээд байдаг ёс бус байдлыг халахад нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн ашиглахгүй байгаа 28.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 68 хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг аймаг, нийслэлийн өмчид шилжүүлсэн. Энэ шийдвэр хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, төсвийн зардлыг хэмнэнэ.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал банкны өөрийн хөрөнгийн дутагдлыг банкны хувьцаа эзэмшигч, бусад хөрөнгө оруулагчаар тэргүүн ээлжинд хангуулах эрх зүйн шинэ орчин бүрдүүлээ. Ингэснээр дампуурсан нэрээр харилцагчдаа хохироодог, улмаар татвар төлөгчдийн мөнгөөр төрд авдаг явдал үгүй болж, банкны салбарт эрүүл, зөв тогтолцоо бүрдэнэ. Харилцагч, хадгаламж эзэмшигчид учрах эрсдэл бас буурна.

Төрийн байгууллагууд бараа, бүтээгдэхүүнийг ялгаатай бөгөөд өндөр үнээр худалдан авдаг, ижил төрлийн барилга, объектын төсөвт өртгийн зөрүү их, барих явцад өртөг нь нэмэгдэж, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагддаг байдлыг Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хязгаарлалаа. Урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг заавал үндэслэж байхаар боллоо.

Засгийн газар бүх салбарын зардлын норм, норматив, стандартыг шинэчлэх ажлыг богино хугацаанд зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангах ёстой.

Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, төрийн болон банк, санхүүгийн байгууллага, нотариат зэрэг хуулийн этгээд улсын бүртгэлийн мэдээллийн санд хандан мэдээлэл авах шинэ тогтолцоо бий боллоо. Иргэд цахим үнэмлэхээрээ аль ч байгууллагаас чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчилгээ авах эрх зүйн орчин бүрдлээ. Улсын бүртгэлийн байгууллага өөрт байгаа мэдээллийг нэмж шаарддагийг хязгаарлаж, ТҮЦ машин болон цахим хуудсаар бүх төрлийн лавлагаа, мэдээлэл авах зохицуулалтыг бий болгов.

Ийнхүү улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн орчныг шинэчлэх ажлыг Улсын Их Хурал энэ чуулганаар бүрэн шийдлээ.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх хугацааг 2028 он хүртэл 10 жилээр сунгасан нь монгол хүн Монгол нутагтаа эзэн нь байх, газар өмчлөх, өмчилсөн газраа эдийн засгийн эргэлтэд оруулах, өгөөжийг нь хүртэхэд ач холбогдолтой шийдвэр болсон гэж үзэж байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт иргэдийн 18.3 хувь, нийт өрхийн 62.5 хувь нь газраа үнэгүй өмчлөн авсан байгаа нь чамлалттай үзүүлэлт юм. Иймд нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга нар хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай анхааралдаа авах нь зүйтэй.

Эрхэм гишүүд ээ,

Энэ парламентын бүрэн эрх замынхаа хагасыг тууллаа. Эхний дөрвөн чуулганы үйл ажиллагаа хямарсан эдийн засгаа өөд татах, буруудсаныг засаж залруулах шийдвэр гаргахад үндсэндээ чиглэсэн. Үр дүн ч гарсан. Эдийн засаг төсөөлснөөс илүү дүнгээр сэргэлээ. Монголд итгэх гаднынхны итгэл нэмэгдлээ. Хөрөнгө оруулалтын хэмжээ өслөө. Аргагүйн эрхэнд гаргасан амаргүй шийдвэрээ зөөллөх эхний боломжууд бас бүрдлээ.

Бүрэн эрхийн үлдэж буй хугацаанд Монгол Улсад засаглалын хяналт, тэнцлийг хангах, улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгох, цэвэр өрсөлдөөнд суурилсан сонгуулийн тогтолцоог бүрдүүлэх суурь хуулиудад өөрчлөлт оруулах томоохон хэрнээ хариуцлагатай ажил биднийг хүлээж байна.

Үндэсний эв нэгдлийг хангах, авлигаас ангижрах, зөвхөн хууль засагладаг нийгмийг төлөвшүүлэх, шударга ёсыг бэхжүүлэхэд бид онцгой анхаарах ёстой.

Монгол түмэнд эв нэгдэл эрхэм чухал гэдэгтэй санал нийлэхгүй монгол хүн байхгүй биз ээ. Гэвч эвдрэлцүүлэх, талцуулах, нэгийг нь нөгөөгөөр үзэн ядуулах зохион байгуулалттай технологи газар авч байгааг иргэд байнга сануулах боллоо.

Монгол үндэстний эрх ашигт онцгой хор хөнөөлтэй энэ мэт үйлдлээс ангид байх, иргэдээ хамгаалах, сэрэмжлүүлэх үүрэг хууль тогтоогч Та биднийх билээ. Монгол төрийн мөн чанар, ёс дэг, ноён нуруу парламентын энэ танхимаас л илүү тод харагдаж байх учиртай.

Үг үйлдэл бүхнээ хянан нягталж, төв голчийг баримтлан, бие ухаанаа тэгшлэн засамжилж явах нь бидний нэр төрийн хэрэг төдийгүй хүндэт үүрэг юм. Улсын Их Хурлын гишүүний эрхэм хүндэт алба бол шагнал биш. Харин шалгуур сорилт юм шүү гэдгийг сануулж хэлэхийг хүсэж байна.

Энэ дашрамд Улсын Их Хурлын 19 гишүүний гарын үсэг зурсан “Нээлттэй сонсгол” явуулах албан бичгийг хуулийн дагуу Хууль зүйн байнгын хороонд шилжүүлснийг мэдэгдье. Чуулган завсарласан ч Байнгын хорооны үйл ажиллагаа үргэлжилж, хуулийн дагуу асуудлаа шийдвэрлэж ажиллах ёстой.

Эрхэм гишүүд ээ,

Чуулган завсарлах нь иргэд, сонгогчидтойгоо идэвхтэй хамтран ажиллах боломж юм. Энэ боломжийг бүрэн дүүрэн ашиглаарай.

“Төрийн ухаан түмэн олонд буй” гэдэг үгийн үнэ цэнийг санаж, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, баталсан хууль, шийдвэрээ ард түмэндээ танилцуулж, санал бодлыг нь сайтар сонсохыг Та бүхэндээ захиж байна.

Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулган өндөрлөснийг мэдэгдье.



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АБГББХ	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОХХААБХ	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БХ	Байнгын хороо
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЁЗДХ	Ёс зүйн дэд хороо
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НББСШУБХ	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨБХ	Өргөдлийн байнгын хороо
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
СХД	Сүхбаатар дүүрэг
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТЗХДХ	Төсвийн зарлагын хяналтын дэд хороо
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТХДХ	Тусгай хяналтын дэд хороо
ТХЗДХ	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо
УИХ	Улсын Их Хурал
УИХГХБДХ	Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХК	Хувьцаат компани
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХЭДХ	Хүний эрхийн дэд хороо
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Редактор:	С.Батбаатар
Эмхэтгэсэн:	Ц.Оюун
Эх бэлтгэсэн:	Т.Цэнд-Аюуш
Гэрэл зургийг:	Г.Эрдэнэтуяа А.Батжаргал

Улсын Их Хурлын Тамгын газраас
2018 оны 07 дугаар сарын 26-ны өдөр эрхлэн гаргав.

/Төлбөргүй тараана/

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх, олшруулах цехэд 1350 хувь хэвлэв.